



ОНЦГОЙ БАЙДЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР



ГАМШИГ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ГАМШГААС ХАМГААЛАХ ЦАГААН НОМ 2021

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

ГАМШГААС ХАМГААЛАХ ЦАГААН НОМ 2021

Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын
Олон нийттэй харилцах хэлтэст эх бэлтгэлийг хийв.

Хянан тохиолдуулсан:

Бригадын генерал Б.Ууганбаяр
Дэд хурандаа П.Чимэдцэрэн (Ph.D)

Боловсруулсан:

Гамшиг судлалын үндэсний хүрээлэн

Ахлах дэслэгч Б.Ариунтунгалаг

Ахмад Э.Оюунгэрэл (Ph.D)

Дэслэгч Т.Билгүүн

Ахлах дэслэгч Д.Балжинням

Хошууч Э.Энхбат

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Ахмад Ч.Наранцацрал

Улаанбаатар хот. 2022 он
Онцгой байдлын ерөнхий газар

ГАРЧИГ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ УДИРДЛАГА

БҮЛЭГ 1.1. ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ	5
1.1.1. Улсын Их Хурлаар батлагдсан баримт бичиг	6
1.1.2. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан баримт бичиг	7
1.1.3. Монгол Улсын Шадар сайдын тушаалаар батлагдсан баримт бичиг	8
1.1.4. Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан баримт бичиг	9
БҮЛЭГ 1.2. ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ	11
БҮЛЭГ 1.3. ГАМШГААС ХАМГААЛАХ ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА	12
1.3.1. Гадаад хамтын ажиллагаа, айлчлал	12
1.3.2. Онцгой байдлын байгууллагад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр	17
БҮЛЭГ 1.4. ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХ	20
1.4.1. Онцгой байдлын байгууллагын техник тоног төхөөрөмжийн бэхжилт, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт	20
1.4.2. Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн талаар	21
1.4.3. Техник хэрэгсэл, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт	29
БҮЛЭГ 1.5. ГАМШГААС ХАМГААЛАХ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ ...	29
1.5.1. Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн үйл ажиллагаа	29
1.5.2. Онцгой байдлын байгууллагын сургалт, эрдэм шинжилгээний нэгжүүдийн гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээний ажил	31
1.5.3. Онцгой байдлын байгууллагын инновацын үйл ажиллагаа	39

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ

БҮЛЭГ 2.1. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	46
2.1.1. Монгол Улсын Шадар сайдын баталсан нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийн удирдамжийн хүрээнд хийсэн ажил	46
2.1.2. 2021 онд төв, орон нутгийн хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил	48
2.1.3. Дадлага, сургалт, бэлэн байдлын үзлэг	49
2.1.4. Онцгой байдлын албаны үйл ажиллагаа, алба хаагчдын ажил мэргэжлийн онцлогийг олон нийтэд сурталчлах	51
2.1.5. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын	

ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагаа	59
БҮЛЭГ 2.2. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	61
2.2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилт	61
2.2.2. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал	62
2.2.3. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа	66
2.2.4. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаа	67

ГУРАВДУГААР ХЭСЭГ. ГАМШГИЙН ШУУРХАЙ УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТ

БҮЛЭГ 3.1. ГАМШГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	70
3.1.1. Монгол оронд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын тойм	70
3.1.2. Монгол Улсад 2021 онд гарсан зарим томоохон аюулт үзэгдэл, ослын тойм:	76
3.1.3. 2021 оны уур амьсгалын жилийн тойм	81
БҮЛЭГ 3.2. ГАЛ ТҮЙМРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	85
3.2.1. Объектын гал түймэр	85
3.2.2. Ой, хээрийн гал түймэр	86
3.2.3. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын үйл ажиллагаа	88

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. ХОР УРШГИЙГ АРИЛГАХ, СЭРГЭЭН БОСГОХ АЖИЛЛАГАА

БҮЛЭГ 4.1. УЛСЫН НӨӨЦ, ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ	92
БҮЛЭГ 4.2. УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	95
БҮЛЭГ 4.3. ХӨВСГӨЛ НУУРТ 1985 ОНД ЖИВСЭН “СҮХБААТАР” ХӨЛӨГ ОНГОЦЫГ ТАТАН ГАРГАХ АЖИЛЛАГАА	98

ТАВДУГААР ХЭСЭГ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

БҮЛЭГ 5.1. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ	104
ХАВСРАЛТ	114



НЭГДҮГЭЭР ХЭСЭГ.

**ГАМШГААС ХАМГААЛАХ
УДИРДАГА**

БҮЛЭГ. 1.1. ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

1.1.1. УЛСЫН ИХ ХУРЛААР БАТЛУУЛСАН БАРИМТ БИЧИГ

1. ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой болон бүх шатны онцгой комиссын бүрэн эрх, онцгой байдлын байгууллагын алба хаагчийн нийгмийн баталгааг дээшлүүлэхтэй холбоотой зохицуулалтыг хуульд шинээр тусгаж, Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 10 дугаар сарын 22, 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар тус тус батлуулсан.

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар доорх өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- 4 дүгээр зүйлд 3 заалт
- 11 дүгээр зүйлд 1 заалт
- 19 дүгээр зүйлд 1 заалт тус тус нэмэлтээр оруулсан;
- 26 дугаар зүйлд 1 заалт
- 27 дугаар зүйлд 2 заалт
- 40 дүгээр зүйлд 1 заалт тус тус өөрчлөлт оруулсан;
- 50 дугаар зүйлд 1 заалт нэмж, 4 заалтад өөрчлөлт оруулсан

Дээрхээс тухайлбал:

1. "Голомтын бүс" гэж гамшиг, аюул, аюулт үзэгдэл, ослын улмаас хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоон, эсхүл шууд эрэн хайх, аврах, нүүлгэн шилжүүлэх, хор уршгийг арилгах ажиллагаа явуулж байгаа объект, нутаг дэвсгэрийг зэрэг нэр томъёоны тодорхойлолтыг шинээр нэмж;

2. Монгол Улсын холбогдох хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийн зорилт болон шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгуулах талаар бодлогын зөвлөмж өгөн;

3. Орон нутгийн онцгой комисс нь энэ хуулийн 27¹.1.1, 27¹.1.2, 27¹.1.3, 27¹.1.4, 27¹.1.5, 27¹.1.6, 27¹.1.7, 27¹.1.8-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

4. Алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт байрлах онцгой байдлын байгууллагын харьяа нэгжид тухайн аймгийн харьяалалгүй алба хаагчийг томилон ажиллуулбал түүнд албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг улирал тутамд олгох.

Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно гэх мэт өөрчлөлтүүдийг тусгажээ.

2. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН

СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, шинээр гарч буй мутацлагдсан хувилбарууд, хүн амын дархлаажуулалтай холбогдуулан Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 06 дугаар сарын 29, 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар тус тус батлуулсан. Тухайлбал:

Цар тахлын нөхцөл байдал цаашид үүсэх эрсдэлийг бууруулах, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, коронавирусын халдварын цар тахалтай тэмцэж буй төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах, цар тахлын үед харилцаа холбоо, мэдээллийн технологи, эрчим хүч, цэвэр ус, хүнс хангамж, шатахуун түгээх газар, төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйл ажиллагаа эрхэлдэг үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, гадаад худалдаа, экспорт, импортын бараа, бүтээгдэхүүний эргэлтийг сайжруулах, хил, гаалийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой хилийн боомтын захиргаа байгуулах, банк, санхүү, барьцаалан зээлдүүлэхтэй холбоотой зохицуулалтыг хуулинд шинээр нэмж тусган хуулийн үйлчлэх хугацааг 2 удаа сунгасан.

1.1.2. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛООР БАТЛАГДСАН БАРИМТ БИЧИГ

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, байгалийн болон хүний хүчин зүйлээс хамааралтай аюул ослоос урьдчилан сэргийлэх шуурхай хариу арга хэмжээ авах, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 2021 онд Засгийн газрын дөчин нэгэн тогтоолыг батлуулж, хэрэгжүүлж ажилласан.

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшинг тогтоож төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшинг тогтоох, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, халдварын тархалтын түвшинтэй уялдуулан төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоолоор тус журмыг батлуулсан. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, нийт хүн амын дархлаажуулалтын эзлэх хувийг харгалзан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор байгууллага, иргэдийн үйл ажиллагааны хязгаарлалтыг бууруулах чиглэлээр тус журамд өөрчлөлт оруулж, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 118 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан байна.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль болохтой холбогдуулан сонгуулийн үйл ажиллагааг халдвар хамгааллын дэглэмийг баримтлан хэвийн явуулах зорилгоор Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 152 дугаар тогтоолоор “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх түр журам”-ыг батлуулсан.

3. Цахилгааны хэрэглээнд хязгаар тогтоож, зөрүүг иргэн, ААН хариуцах тухай журам.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор айл өрх болон зарим аж ахуй нэгж, байгууллагын цахилгаан, дулаан, усны төлбөрийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төрөөс хариуцахаар шийдвэрлэсэн.

Засгийн газрын дээрх шийдвэр гарсан эхний хоёр өдөр улсын хэмжээнд цахилгаан эх үүсвэрийн ачаалал хамгийн дээд цэгтээ хүрсэн байна. Тиймээс 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Засгийн газраас хуралдаанаас цахилгааны хэрэглээнд хязгаар тогтоож, зөрүүг иргэн, ААН хариуцах тухай журмыг гаргасан байна.

1.1.3. МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТУШААЛААР БАТЛАГДСАН БАРИМТ БИЧИГ

1. “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний II дугаар шат (2021-2025 он)-ны төлөвлөгөө.

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 51 дүгээр тушаалаар “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх 2021-2025 оны II үе шатны арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан.

2. Газар хөдлөлтийн тухай мэдээ, мэдээллийг дамжуулах, мэдээлэх журам.

Энэ журмын зорилго нь газар хөдлөлтийн мэдээлэл солилцох, дамжуулах, мэдээлэх харилцааг зохицуулахад оршино. Одон орон, геофизикийн хүрээлэн /цаашид “ООГХ” гэх/ болон Онцгой байдлын ерөнхий газрын Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв /цаашид ШУЗМТ гэх/ хооронд газар хөдлөлтийн мэдээ, мэдээллийг хүлээн авах, дамжуулахдаа “Газар хөдлөлтийн мэдээлэл дамжуулах систем”, “Гамшгийн аюулын зарлан мэдээлэх систем”-ийг ашиглах талаар журамд тусгасан байна.

3. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйл 7.3 дахь хэсэгт зааснаар Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 100 дугаар тушаалаар баталсан. Дээрх тушаал батлагдсанаар мэргэжлийн зөвлөл нь

Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох тухай хууль, Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах эрх зүйн орчин бий болсон.


4. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 190 дүгээр тогтоолоор Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журмыг батлан гаргасан. Тус журмын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 68 дугаар тушаалаар Гамшгийн эрсдэлийн үнэлгээний зааврыг шинэчлэн баталсан. Тус заавар нь гамшгийн эрсдэлийг ерөнхий болон нарийвчилсан байдлаар үнэлж, аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагаанаас үүсч болох гамшгийн эрсдэлийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хуулийн этгээд, стратегийн болон онц чухал объектын түвшинд үнэлгээ хийхэд ашиглагдах юм.

1.1.4. ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛААР БАТЛАГДСАН БАРИМТ БИЧИГ

1. Батлагдсан төлөвлөгөө, заавар, хяналтын хуудас

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/135 дугаар тушаалаар “Гал түймэр унтраах тактик, тархалтын дадлага, сургалтын төлөвлөгөө”, “Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө, карт боловсруулах заавар”, 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/271 дүгээр тушаалаар үйлдвэр, агуулахын барилга байгууламж, худалдаа олон нийтийн барилга байгууламж, газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станц, шингэрүүлсэн нүүрст устөрөгчийн хий болон байгалийн хий хадгалдаг, борлуулдаг байгууллагад гал түймрийн улсын хяналт шалгалт хийх хяналтын хуудсыг боловсруулж тус тус батлуулсан.



Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн Хяналтын хуудас батлах тухай А/271 дугаар тушаал



Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн Заавар батлах тухай А/135 дугаар тушаал

2. Онцгой байдлын байгууллагад алба хаах журам.

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 07 дугаар сарын 21-ний 67 дугаар тушаалын хавсралтаар “Онцгой байдлын байгууллагад алба хаах журам”-ыг баталсан.

Журам нь 5 бүлэг 14 заалттай ба удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн сонгон шалгаруулах, бүрдүүлэх, хүний нөөцийн томилгоо, алба хаагчийг үнэлэх, урамшуулах, сургаж дадлагажуулах, хүний нөөцийн тоо бүртгэл, тусламж, дэмжлэг, хариуцлага зэргийг нарийвчлан тусгаж өгсөн.

3. Онцгой байдлын байгууллагын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/49 дугаар тушаалын хавсралтаар “Онцгой байдлын байгууллагын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”-ыг баталсан.

Энэхүү журам нь Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Улсын нөөцийн тухай, Төрийн болон албаны нууцын тухай, байгууллагын нууцын тухай, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиуд, Онцгой байдлын ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журам, Онцгой байдлын байгууллагад алба хаах журам, цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрэм болон бусад хууль, дүрэм, журамтай нийцсэн байхаар боловсруулагдсан байна.

4. Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам.

Галын аюулгүй байдлыг хангах, гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр аж ахуй нэгж байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийн дагуу гал түймрийн улсын хяналтын /ахлах/ байцаагчийн шалгалтын дүнг үндэслэн галын аюулгүй байдлын дүгнэлтийг гал түймрийн онц аюултай барилга байгууламжид 1 жилийн хугацаатай, гал түймрийн аюултай 1 дүгээр зэргийн барилга байгууламжид 2 жилийн хугацаатай, гал түймрийн 2, 3 дугаар зэргийн барилга байгууламжид 3 жилийн хугацаатай дүгнэлт гаргах зорилгоор энэхүү журмыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/154 дугаар тушаалаар “Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам”-ыг баталсан.

5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн өгсөн үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс бие бүрэлдэхүүнд өгсөн үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг боловсруулж Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн А/258 дугаар тушаалаар батлуулсан.

6. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланг дүгнэх шалгуур үзүүлэлт.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 190 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ыг үндэслэн Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/255 дугаар тушаалаар Гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний тайланг дүгнэх шалгуур үзүүлэлтийг батлуулсан байна.

БҮЛЭГ. 1.2. ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

1. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 50 дугаар тушаалаар батлагдсан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 2020 оны хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд:

№	Хөтөлбөрийн зорилтууд	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээ			Дундаж хувь
			100%	70%	50%	
1.	Олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн орчин, тогтолцоог бүрдүүлэх	1	1	-	-	100%
2.	Гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн сургалт, сурталчилгааг бүх түвшинд шат дараалан зохион байгуулах	9	8	-	1	94.4%
3.	Олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх	3	3	-	-	100%
4.	Уур амьсгал, ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээллийг шуурхай мэдээллэх тогтолцоог бэхжүүлэх	1	1	-	-	100%
5.	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоо идэвх, санаачлагыг дэмжих	2	2	-	-	100%
6.	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх	4	3	1	-	92.5%
Нийт		20	18	1	1	96.0%

“Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд 6 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг 2021-2025 он хүртэл хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг 2021 оны жилийн эцсийн байдлаар тооцож үзэхэд биелэлт 96.0 хувьтай дүгнэгдсэн байна.

2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 203

дугаар тогтоолоор Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан.

Тус төлөвлөгөөнд засаглалын бодлогын 4.3.11.1, 4.3.14.1, 4.3.14.2, 4.3.15.1, ногоон хөгжлийн бодлогын 5.1.2.1 зэрэг нийт 5 заалт арга, хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагаар Онцгой байдлын ерөнхий газрыг заасан байна. Арга хэмжээний биелэлт 96.6 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн байна.

3. Онцгой байдлын байгууллага 2021 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын 4 хуулийн 30, Улсын Их хурлын 5 тогтоолын 18, Улсын Их хурлын байнгын хорооны 3 тогтоолын 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 6 зарлигийн 16, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 3 зөвлөмжийн 6, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1 хуралдааны тэмдэглэлийн 13, Засгийн газрын 49 тогтоолын 61, Монгол Улсын Ерөнхий сайдын 1 захирамжийн 1, Засгийн газрын хуралдааны 21 тэмдэглэлийн 30, Засгийн газрын 3 албан даалгаврын 12 нийт 96 шийдвэрийн 192 заалтыг хяналтад авч ажилласан. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээгээр гүйцэтгэл 98.9 хувьтай хэрэгжсэн гэж дүгнэгдсэн.

4. Онцгой байдлын ерөнхий газарт гадаадын зээл тусламжаар 2021 онд хэрэгжиж буй 4 төслийн хэрэгжилт 96.8 хувийн үнэлгээтэй дүгнэгджээ.

БҮЛЭГ 1.3. ГАМШГААС ХАМГААЛАХ ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА

1.3.1. Гадаад хамтын ажиллагаа, айлчлал

1. Оросын Холбооны Улсын Онцгой байдлын яамнаас 2021 оны 05 дугаар сарын 11-18-ны өдрүүдэд Москва хотноо зохион байгуулсан "Иж бүрэн аюулгүй байдал 2021" олон улсын үзэсгэлэнд Онцгой байдлын ерөнхий газрын төлөөлөгчид оролцсон.

Айлчлалын хүрээнд Оросын Холбооны Улсын Онцгой байдлын тэргүүн дэд сайд, хурандаа генерал А.П.Чуприянтай хоёр талын уулзалт хийж, Монгол-Оросын онцгой байдлын салбар дахь хамтын ажиллагааны талаар санал солилцсон. Үүнд:

- Оросын Холбооны Улсын Онцгой байдлын яамны Хямралын удирдлага, зарлан мэдээлэх төв болон Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвтэй хамтран ажиллаж, цаашид бүс нутгийн зарлан мэдээллийн төвүүдийг холбох талаар хамтран ажиллах.
- Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт багтсан Хөвсгөл нууранд живсэн автомашинуудыг татан гаргах ажиллагааг ОХУ-ын Онцгой байдлын яамны Байгалийн эрэн хайх, аврах төвтэй, мөн энэ үеэр хамтарсан гүний усны дадлага сургуулийг тус тус зохион байгуулах.
- "Үйлдвэрийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Монгол-Оросын Засгийн газар хоорондын ээлжит комиссын хуралдааныг Оросын Холбооны Улсын Халимаг Улсын Элиста хотод зохион байгуулахаар тохиролцжээ.

2. Бүгд Найрамдах Беларусь Улсын Минск, Борисов хотноо "Пожснаб" компанийн

үйл ажиллагаатай танилцах айлчлалд 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс 6 дугаар сарын 23-ны өдрүүдэд Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо.

Айлчлалын хүрээнд “Пожснаб” компанид зочилж, ерөнхий захирал О.А.Дерябин, дэд захирал С.Н.Захаревич болон бусад холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт хийж, тус үйлдвэрийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн явц, техник, тоног төхөөрөмжүүдтэй танилцсан. Төслөөр нийлүүлэгдсэн автомеханик шаттай автомашины хугацаат техникийн үйлчилгээг “Пожснаб” компанийн мэргэжилтнүүдийг Монгол Улсад ирүүлж хийлгэх талаар ярилцаж, цаашид хоёр дахь шатны төслийг хэрэгжүүлэх боломж, хамтын ажиллагааны талаар санал солилцжээ.

Онц байдлын яамны Иргэний хамгаалалтын их сургуулийн Давтан сургалт болон дээд боловсролын институтэд зочилж, захирал В.С.Рудольфтай уулзалт хийж, сургалтын арга зүй, чиглэл, материаллаг бааз, сургалт бэлтгэлийн талбайтай танилцсан бөгөөд Иргэний хамгаалалтын их сургуулийн Давтан сургалт болон дээд боловсролын институтэд Онцгой байдлын байгууллагын алба хаагчдыг сургах талаар хамтран ажиллахад бэлэн байгааг тус институтээс илэрхийлсэн байна.

Мөн Бүгд Найрамдах Беларусь Улсын Минск хотын Гал түймэр унтраах, аврах 30 дугаар анги, Тусгай (хонгил болон уснаас эрэн хайх, аврах үүрэг бүхий) гал түймэр унтраах, аврах ангийн үйл ажиллагаа, ашиглаж байгаа автомашин, техник тоног төхөөрөмжтэй танилцаж, тус Улсын Минск хот дахь “МАЗ” компанид зочилж автомашины экспортын Азийн орнууд хариуцсан хэлтсийн дарга И.В.Ярославович, экспортын гадаад санхүүгийн хэлтсийн дарга С.А.Папкович нартай уулзалт хийж, тус үйлдвэрийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн явц, үйлдвэрлэж байгаа автомашин, техникүүдтэй танилцаж, төслөөр нийлүүлэгдсэн автомашинуудын ашиглалтын талаар санал солилцов.



Зураг 1.Бүгд Найрамдах Беларусь Улсын Онц байдлын яам

3. Бүгд Найрамдах Франц Улсын Парис, Леон хотноо 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрүүдэд "Дэсотел" компанид зочилж, төслийн хүрээнд нийлүүлэгдэж буй автомашиныг хүлээж авах айлчлалд Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын төлөөлөгчид оролцсон.

Тус айлчлалын хүрээнд "Дэсотел" группын "Невориз" дэх автомашины үйлдвэрт зочилж, үйлдвэрийн үйл ажиллагаа, үйлдвэрлэж байгаа автомашин, техниктэй танилцсан бөгөөд тус группээс 2021 оны 8, 9 дүгээр сард Монгол Улсад нийлүүлэгдэх эхний ээлжний гал түймэр унтраах үндсэн албаны 21 автомашины үйлдвэрлэлийн сүүлчийн туршилт, шалгалтыг үзүүлэлтийн дагуу хийсэн. Туршилт, шалгалтаар автомашины өөрчлөх, засах шаардлагатай зүйлсийг ярилцаж шийдвэрлэсэн байна. Мөн Монгол Улсад нийлүүлэгдэх үйлдвэрлэлийн гал түймэр унтраах хөөсний автомашины үйлдвэрлэлийн явц, автомашинуудад нийлүүлэгдэх тоног төхөөрөмж, хамгаалах хувцас хэрэгсэлтэй танилцжээ.



Зураг 2. Бүгд Найрамдах Франц Улсын Леон хот дахь "Дэсотел" группын "Невориз" дахь автомашины үйлдвэр



Зураг 3. Бүгд Найрамдах Франц Улсын "Невориз" дахь автомашины үйлдвэрт гал түймэр унтраах үндсэн албаны автомашинуудын туршилт, шалгалт хийж байгаа явц

4. Бүгд Найрамдах Казакстан Улсын Караганда хотноо зохион байгуулагдсан Дэлхийн гал сөнөөгч, аврагчдын гал унтраах олон төрөлт спортын 16 дахь

удаагийн Дэлхийн аваргын тэмцээнд Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр тэргүүтэй баг тамирчид оролцсон бөгөөд 2021 оны 9 дүгээр сарын 2-ны өдрөөс 5-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан тус тэмцээнд шигшээ багийн 12 тамирчин, нийт 15 албан хаагч амжилттай оролцсон байна.

ГУТОТС-ын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд үзүүлсэн Монгол Улсын шигшээ багийн амжилтаас дурдвал:

- Гал унтраах техникийн олон төрөлт спортийн **Довтолгооны шатны** багийн нийлбэр дүнгээр 7-р байр,
- **Саадтай 100 метрийн төрөлд** багийн нийлбэр дүнгээр 6-р байр,
- **4*100 метрийн төрөлд** Монгол Улсын шигшээ багийн 4*100 метрийн 2 дугаар багын тамирчид 01:01:12 минутын амжилтаар 5-р байр,
- **Байлдааны тархалтын төрөлд** Монгол Улсын шигшээ багийн тамирчид 27:95 секундээр 6-р байрыг тус тус эзэлсэн.

ГУТОТС-ын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний баг тамирчид Шахтер цэнгэлдэх хүрээлэнд хаалтын ажиллагаанд оролцож, **Монгол Улсын шигшээ багийн тамирчид багийн дүнгээр 6 дугаар байранд** шалгарсан байна.



Зураг 4. "ГУТОТС-ын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн" Монгол Улсын шигшээ баг тамирчид

5. Бүгд Найрамдах Франц Улсын Парис, Леон хотноо Онцгой байдлын ерөнхий газар, Бүгд Найрамдах Франц Улсын "Десотел" компани хооронд байгуулсан гэрээний хоёрдугаар ээлжинд нийлүүлэгдэх гал түймэр унтраах үндсэн албаны автомашины үйлдвэрлэлийн туршилт, шалгалт хийх айлчлалд ОБЕГ-ын дарга

хошууч генерал Г.Ариунбуян тэргүүтэй төлөөлөгчид 9-р сарын 7-20-ны өдрийн хооронд ажлын айлчлал хийв. Тус айлчлалын хүрээнд хамтран хэрэгжүүлж байгаа төслүүдийн талаар мэдээлэл солилцож, Дотоод хэргийн яамны Иргэний аюулгүй байдал, хямралын удирдлагын ерөнхий газрын удирдлагуудтай уулзан, Хямралын удирдлагын төвийн үйл ажиллагаатай танилцсан байна.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд байгуулсан Санхүүгийн зээлийн хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж буй Гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин, техникийг нийлүүлэх төслийн хүрээнд нийт 4 төрлийн 42 гал унтраах зориулалтын автомашин нийлүүлэн, холбогдох сургалт, дадлагыг эхлүүлсэн байна. Агаараас эрэн хайх, аврах нэгжид одоогоор эрэн хайх, аврах ажиллагааны хоёр, сургалтын зориулалтаар ашиглах нэг нисдэг тэрэг нийлүүлэгдсэн бөгөөд энэхүү төсөл нь хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргасан юм.

Эдгээр төсөл нь автомашин, техник болон нисдэг тэргийг нийлүүлэхээс гадна аврагч, гал сөнөөгч, нисгэгч, инженер техникийн ажилтнуудыг сургаж, дадлагажуулах цогц хэлбэрээр хэрэгжиж байна.

6. Онцгой байдлын байгууллагаас 2021 онд гадаад улс оронд зохион байгуулагдсан 6 удаагийн айлчлал, хурал, зөвлөгөөн, уулзалт, сургалт, семинар, үзэсгэлэн, тэмцээнд нийт 34 алба хаагч оролцсон ба үүнээс дээд офицер 4, ахлах офицер 10, дунд офицер 10, ахлагч бүрэлдэхүүн 7, энгийн 3 алба хаагч байна.

7. “Үйлдвэрийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах тухай” Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд “Монгол-Оросын хамтарсан комиссын XVIII хуралдаан”-ыг 2021 оны 10 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Халимаг Улсын Элста хотод ОХУ-ын Онцгой байдлын яамтай хамтран зохион байгуулж, тус хуралдаанд ОБЕГ-ын дарга, хошууч генерал Г.Ариунбуян тэргүүтэй төлөөлөгчид оролцжээ.

Онцгой байдлын байгууллагаас 2021 онд Гамшгаас хамгаалах чиглэлээр хийсэн гадаад хамтын ажиллагааны онцлох ажлууд

• БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС

Хил орчмын ой, хээрийн гал түймэртэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн шинэчилсэн төслийг 2 талдаа хэлэлцэж тохиролцсон.

• БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛС

“Гамшгаас хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар болон Бүгд Найрамдах Турк Улсын Гамшиг, онцгой байдлын удирдлагын газар хоорондын Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан байна.

• БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар болон БНСУ-ын Дотоод хэрэг, үндэсний аюулгүй байдлын яам хоорондын гамшгаас хамгаалах салбарт хамтран

ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг 2021 оны 12-р сарын 30-ны өдөр байгуулсан.

- БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУСЬ УЛС

Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжиж буй төсөл амжилттай хэрэгжин нийт 15 сая евро бүхий 73 техник, тоног төхөөрөмжийг тус улсын “Пожснаб” компани нийлүүлж, төсөл амжилттай хэрэгжсэн байна.

1.3.2 Онцгой байдлын байгууллагад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр

1. “Монгол Улсын Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл” (2020-2023):

Төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдсэн ажлууд:

Нисдэг тэрэг, тоног төхөөрөмж, симулятор нийлүүлэлт:

1. Төслийн хүрээнд ЕС-145 маркын 3 нэгж нисдэг тэрэг, сургалтын Кабри маркын 1 нисдэг тэрэг, сургалтын симулятор нийлүүлэгдэх бөгөөд эхний ээлжийн 2 нэгж ЕС-145 нисдэг тэргийг 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр, сургалтын Кабри маркын 1 нисдэг тэргийг 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдрүүдэд тус тус хүлээн авлаа.

2. ЕС-145, Кабри маркын нисдэг тэрэгний эд анги, багаж хэрэгслийг 19 удаагийн тээвэрлэлтээр, ангарын бэлдэцийг нийт 24 удаагийн тээвэрлэлтээр нийлүүлснийг импортын татвараас чөлөөлүүлж, гаалийн бүрдүүлэлт хийж, хүлээж авсан.

Ангар, сургалтын байгууламж

Гүйцэтгэгч компанийн зүгээс ангар, сургалтын байгууламжийн барилгын суурь цутгалт, дэд бүтцийн ажлыг гүйцэтгүүлэхээр “Мета Менежмент” ХХК-тай гэрээ байгуулсан ба барилгын суурь цутгалт, дэд бүтцийн ажил 2021 оны 6-9 дүгээр сард явагдаж дууссан. Мөн “Хэли-Юнион” компанийн туслан гүйцэтгэгч Францын “Утилис” компанийн ажилчид ангарын хийц угсрах ажлыг 2021 оны 9-11 дүгээр сард гүйцэтгэсэн ба ангар, сургалтын байгууламжийг Улсын комисст хүлээлгэн өглөө.

Нисдэг тэргүүдэд хяналт шалгалт явуулж хүлээн авах, холбогдох зөвшөөрлийг олгуулах үйл ажиллагаа:

Нисдэг тэргүүдэд хяналт шалгалт хийх, ОБЕГ-ын өмчлөлд шилжүүлэх ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд тус ажлын хэсэгт Агаарын цэргийн командлал, Иргэний нисэхийн ерөнхий газрын холбогдох мэргэжлийн хүмүүс ажиллалаа.

Эхний ээлжинд тус ажлын хэсгээс 2021 оны 10 дугаар сард 9203 серийн дугаартай ЕС-145 маркын 1 нэгж нисдэг тэрэг, Кабри маркын 1 нэгж нисдэг тэргүүдэд хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргасан ба нисдэг тэргүүдэд нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгуулах, ОБЕГ-ын өмчлөлд шилжүүлэх ажил явагдаж байна.

Төслийн 2 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдсэн ажлууд:

Тусгай зориулалтын автомашин үйлдвэрлэл, нийлүүлэлт:

1. Төслийн хүрээнд нийлүүлэгдэх 42 ширхэг гал унтраах тусгай зориулалтын автомашиныг 2 удаагийн тээвэрлэлтээр нийлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд эхний ээлжийн 21 автомашиныг 2021 оны 9 дүгээр сард, 2 дахь ээлжийн 18 автомашиныг 2021 оны 12 дугаар сард тус тус хүлээн авч, автомашинууд дээр ажиллах сургалт, дадлагыг зохион байгуулан, төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсүүдэд хуваарилсан.

II. “Монгол Улсад Гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх техникийн туслалцааны төсөл” (2020-2021):

1. Эхлэлийн уулзалт /Inception Mission/: Азийн хөгжлийн банкны “Монгол Улсад гамшгийн зарлан мэдээлэх нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийн эхлэлийн уулзалтыг 2020 оны 11 дүгээр сарын 09, 11-13-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулсан. Тус уулзалтаар Харилцан ойлголцлын санамж бичгийг боловсруулж, Сангийн яамнаас тус санамж бичгийг 2021 оны 10 дугаар сарын 03-ны өдөр баталсан байна.

2. Төслийн хэрэгжилтэд үнэлгээ хийх дунд хугацааны үйл ажиллагаа /Interim Mission/: Азийн хөгжлийн банкны “Монгол Улсад Гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх” техникийн туслалцааны төслийн хэрэгжилтэд үнэлгээ хийх дунд хугацааны үйл ажиллагааг 2021 оны 10 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулсан. Тус уулзалтаар Харилцан ойлголцлын санамж бичгийг бэлтгэж, Сангийн яам, Азийн хөгжлийн банк, Онцгой байдлын ерөнхий газраас гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.

3. Төслийн хэрэгжилтэд үнэлгээ хийх сүүлийн шатны үйл ажиллагаа /Fact Finding Mission/: Азийн хөгжлийн банкны “Монгол Улсад Гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх” техникийн туслалцааны төслийн хэрэгжилтэд үнэлгээ хийх дунд хугацааны үйл ажиллагааг 2021 оны 12 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулсан. Тус уулзалтаар техникийн туслалцааны төслийн зөвлөхүүдийн боловсруулсан “Монгол Улсад Гамшгийн зарлан мэдээллийн нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх” зээлийн төслийн ТЭЗҮ, төслийн төгсгөлийн тайлан, төслийн удирдлагын гарын авлагын төслийг хянаж, санал дүгнэлт гаргажээ.

III. “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт болон эрсдэл шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх” техникийн туслалцааны төсөл (2020-2024.04-р сар):**Төслийн хэрэгжилт**

Зорилт 1: Гамшгийн эрсдэлийн үнэлгээг сайжруулах:

1.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний анхдугаар сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулсан. Сургалтаар “Эрсдэл, эрсдэлийн үнэлгээ, удирдлагын талаарх үндсэн ойлголт, нотолгоонд суурилсан

гамшгийн эрсдэлийн үнэлгээ, үнэлгээний үйл явц, арга зүй, Монгол Улсын гамшгийн эрсдэлийн үнэлгээний өнөөгийн хууль, эрх зүй, институцын орчин"-зэргийг танилцуулж, нэг болон олон аюулын цагийн байдал, эрсдэлийн матриц, эвдэрлийн муруй байгуулах, эдийн засгийн хохирол гарах магадлалын дасгал ажлыг мөн зохион байгуулсан байна.

1.2. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, аюулын зураглал боловсруулах 2 дугаар сургалтыг 2021 оны 10 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд холбогдох яам, агентлагийн төлөөлөл, Онцгой байдлын байгууллагын гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдэд зохион байгуулжээ.

1.3. Төслийн дунд хугацааны явцын үнэлгээг дүгнэх хурлыг 2021 оны 11 дүгээр сарын 24-25-ны өдөр зохион байгуулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, санамж бичигт гарын үсэг зурсан байна.

1.4. Төслийг хэрэгжүүлэх хүрээнд 5 бүсийн төвд төслийн бүсийн төв хариуцсан зохицуулагчийг сонгон шалгаруулж, 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ажиллуулж байна.

Зорилт 2: Гамшгийн тэсвэрлэх чадавхыг сайжруулах:

2.1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний сургалтын хэрэгцээ шаардлагын үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

2.2. Эрсдэлийн үнэлгээг хийх эхний 5 аймгийг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу сонгон шалгаруулав.

Зорилт 3: Гамшгийн эрсдэлийн даатгалыг хөгжүүлэх:

3.1. Гамшгийн эрсдэлийн даатгалын хуулийн төслийг боловсруулах хүрээнд хуулийн фирмийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахад "Anand Advocates" LLP зөвлөх үйлчилгээний баг шалгарч хуулийн төсөл боловсруулах ажил эхэлсэн.

3.2. Дотоодын зах зээлд байгаа гамшгийн эрсдэлийн 2 бүтээгдэхүүний талаар болон холбогдох салбарын хууль тогтоомж, Санхүүгийн Зохицуулах хорооны даатгалын багц дүрэм, холбогдох журмуудыг олон улсын зөвлөхүүдэд хөрвүүлэн хүргүүлсэн байна.

3.5. Гамшгийн эрсдэлийн санхүүжилт II сургалт, семинарыг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Энэхүү сургалтаар олон улсын хэмжээнд ашиглагдаж буй гамшгийн эрсдэлийн санхүүжилтийн талаарх ойлголтыг оролцогчдод олгож, төсвийн байгууллагуудад гамшгийн эрсдэлийг даатгал, давхар даатгал болон хөрөнгийн зах зээлд шилжүүлэх зэрэг санхүүгийн хэрэгслүүдийн талаарх мэдээллийг өглөө.

БҮЛЭГ 1.4. ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХ

1.4.1 Онцгой байдлын байгууллагын техник тоног төхөөрөмжийн бэхжилт, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын экспортын зээлээр хэрэгжсэн “Онцгой байдлын албаны гамшигтай тэмцэх техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах” төслийг 2019-2021 онд хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд 15,4 сая евро буюу 46,2 тэрбум төгрөгийн өртөг бүхий 14 төрлийн автомашин нийлүүлэгдсэн бөгөөд гэрээний дагуу 2020 онд автомашинуудыг ОБЕГ-ын даргын тушаалаар төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад хүлээлгэн өгсөн. 2021 онд АЛ-32 (6317) автомеханик шат, АШ (6317) штабын зориулалттай автомашин, МГП загварын хөдөлгөөнт эмнэлгийн автомашин, ВА загварын ээлжийн бүрэлдэхүүний тээврийн автомашин гэсэн 5 төрлийн автомашиныг хүлээн авч ашиглалт, засвар үйлчилгээний сургалт дадлагыг зохион байгуулж төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад хүлээлгэн өгснөөр төслийг амжилттай хэрэгжүүлж дуусгасан.



Зураг 5. Онцгой байдлын албаны гамшигтай тэмцэх техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах төсөл

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хооронд Санхүүгийн зээлийн хэлэлцээрийн хүрээнд “Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл”-ийг Бүгд Найрамдах Франц Улсын “Десотел сас” компанитай хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн хүрээнд 14,9 сая евро буюу 44,7 тэрбум төгрөгийн өртөг бүхий 4 төрлийн автомашинууд нийлүүлэгдэх бөгөөд 2021 онд хоёр удаагийн ээлжээр 3 төрлийн автомашин нийлүүлэгдсэнийг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад хүлээлгэн өгч автомашинуудыг ашиглах, засварлах сургалт дадлагыг 2 удаа зохион байгуулсан байна. Энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлснээр онцгой байдлын албаны

гал түймэртэй тэмцэх автомашины хангалт 60,2 хувь болсон. Нийт 2 төслийг хэрэгжүүлснээр улсын хэмжээнд гал түймэр унтраах автомашин, техникийн хангалт 19,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Зураг 6. Гал түймэр унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл

1.4.2 Бие бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийн талаар

Онцгой байдлын байгууллагын 2021 оны сургуулийн жилд сургалт бэлтгэлийг онол, дадлага, бие даалт, цахим хэлбэрээр зохион байгуулсан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/308, А/309 дугаар тушаалаар 2021 сургуулийн жилийн удирдамж, сургалтын бодлого, сургалт бэлтгэлийн хөтөлбөр, цаг, сэдвийн төлөвлөгөө, зохион байгуулах журмыг шинэчлэн боловсруулж хэрэгжилтийг хангуулж ажилласан.

2021 оны сургуулийн жилийг гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, бие бүрэлдэхүүний албаны мэдлэгийг дээшлүүлэх, мэргэжлийн ур чадвар, бие бялдрын үзүүлэлтийг хангуулах, цэргийн албыг хэвшүүлэх зорилго тавин ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй цахим шилжилтийг хангах хүрээнд Онцгой байдлын ерөнхий газраас 2021 онд нийт 39 сургалтыг төлөвлөж үүнээс 25 сургалтыг цахимаар зохион байгуулж, давхардсан тоогоор 1201 алба хаагч хамрагдсан байна.

Дотоод хэргийн их сургуулийн 2021-2022-оны хичээлийн жилд Онцгой байдлын сургуулийн “Онцгой байдал-гамшгаас хамгаалах алба” бакалаврын 3 жилийн эчнээ ангид офицер бүрэлдэхүүн 16, ОХУ-ын Иргэний хамгаалалтын академийн магистрт 2, Гал эсэргүүцэх албаны академийн магистрт 3, ҮБХИС-ийн Удирдлагын академид-2, ДХИС-ийн Удирдлагын академид-1 алба хаагч тус тус элсэн суралцаж байна.

МЭРГЭЖИЛ ОЛГОХ, МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ



480 алба хаагч



ОХУ-Иргэний хамгаалалтын академи, Гал эсэргүүцэх албаны академи, Санкт Петербург хотын Гал эсэргүүцэх албаны их сургууль

63 алба хаагч



Унгар Улс
3 алба хаагч



Япон Улс
1 алба хаагч



Бүгд Найрамдах Польш Улсын Цэргийн урлагийн академи

5 алба хаагч



Бүгд Найрамдах Турк Улс
2 алба хаагч



Бүгд Найрамдах Солонгос Улс
8 алба хаагч

Зураг 7. Гадаад дотоодын их дээд сургуульд сурч буй алба хаагчдын тоо

2021 ОНД ХИЙГДСЭН ТОМООХОН СУРГАЛТ:

“ЦАЦРАГИЙН ОСЛЫН БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ” СЭДЭВТ СУРГАЛТ, ДАДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоолоор батлагдсан “Цацрагийн ослоос хамгаалах үйл ажиллагааны улсын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангуулах, цацрагийн ослын үед ажиллах мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах чиг үүргийг тодотгох зорилгоор Онцгой байдлын ерөнхий газраас Цөмийн энергийн комиссын ажлын алба, Зэвсэгт хүчний жанжин штаб, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран “Цацрагийн ослын бэлэн байдал, хариу арга хэмжээ” сэдэвт сургалт, дадлагыг зохион байгууллаа.



Зураг 8. “Цацрагийн ослын бэлэн байдал, хариу арга хэмжээ” сэдэвт сургалт, дадлага

ЭМНЭЛГИЙН ЗААВАРЛАГЧ БЭЛТГЭХ СУРГАЛТ

2021 оны 12 сард Онцгой байдлын ерөнхий газраас Зэвсэгт хүчний Жанжин штабын Эмнэлгийн хэлтэстэй хамтран “Эмнэлгийн зааварлагч бэлтгэх” сургалтыг зохион байгууллаа. Алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилготой тус сургалтад ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригад, нийслэлийн Онцгой байдлын газрын нийт 40 гаруй алба хаагч хамрагдсан юм. Энэхүү сургалтаар аврагчид гамшиг, осолд нэрвэгдсэн иргэд болон хамтран үүрэг гүйцэтгэгчдэдээ эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх мэдлэгээ дээшлүүлсэн байна.



Зураг 9. Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх сургалт

Мөн Хөвсгөл, Төв аймгийн Онцгой байдлын газраас АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин Сайдын яамны Иргэн, цэргийн харилцааны дэмжлэгийн багтай хамтран “Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх сургалт”-ыг зохион байгууллаа.

Сургалт гамшиг, ослын голомтод эмнэлгийн анхны тусламж үзүүлэх болон бусад бэртэл гэмтлийн үед үүрэг гүйцэтгэх алба хаагчдад мэдлэг олгох, тэдгээрийг чадавхжуулах зорилгоор танхим, дадлага хосолсон хэлбэрээр явагдсан юм.

Сургалтыг АНУ-ын Иргэн, цэргийн дэмжлэгийн бүлгийн дэд тэргүүн Эрнест Күүрри болон Иргэн, цэргийн дэмжлэгийн бүлгийн ахлах эмнэлгийн зөвлөх Брайян Ёнг нар удирдан явуулж, их хэмжээний цус алдалтын үед болон амьсгалын замын бөглөрөл, цусны эргэлтийн үед үүсэх нуруу, толгойны гэмтэл болоод осголтын үед үзүүлэх анхны тусламж сэдвүүдээр зохион байгуулагдаж, алба хаагчдын үүрэг гүйцэтгэх мэдлэг чадварыг дээшлүүлээ.

АМЬСГАЛЫН БИЕ ДААСАН ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЧДЫН НЭГДСЭН СУРГАЛТ

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд “Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн амьсгалын бие даасан төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээг хийх хүрээнд тус сургалт зохион байгуулагдсанаараа онцлог юм.

Сургалтыг Бүгд Найрамдах Франц Улсын “Матесик” компанийн мэргэжилтэн Сульфид Дроуйн удирдан явуулж, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын салааны захирагч, амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварчин зэрэг нийт 82 алба хаагч хамрагджээ.



Зураг 10. Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварчдын нэгдсэн сургалт

“ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ” СУРГАЛТ, СЕМИНАР

Азийн хөгжлийн банкнаас Ядуурлыг бууруулах Японы сангийн санхүүжилтээр “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт болон эрсдэл шилжүүлэх чадавхыг бэхжүүлэх” техник туслалцааны төслийг Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжүүлж байна. Тус төсөл нь үндэсний болон орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах төлөвлөлтийг сайжруулах, гамшгийн эрсдэлийн даатгалын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилготой юм.

Тус төслийн “Үндэсний хэмжээний гамшгийн эрсдэлийн үнэлгээ” 1 дүгээр зорилтын хүрээнд “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ модуль I” сургалт, семинарыг


2021 оны 10 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгуулсан байна.



Зураг 11. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ модуль I сургалт

ОХУ-ЫН ОНЦГОЙ БАЙДЛЫН ЯАМНЫ БАЙГАЛИЙН ЭРЭН ХАЙХ, АВРАХ ОТРЯДТАЙ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛСАН ГҮНИЙ УСНЫ СУРГАЛТ

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 07-ны А/191 дүгээр тушаалаар Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах, нуурын ёроолын аюултай хаягдлыг цэвэрлэх, бохирдлыг бууруулах, нуурт живсэн Сүхбаатар хөлөг онгоцыг татан гаргах, суурь судалгаа хийх, Хөвсгөл нуурт живсэн автомашин техникийн байршлыг тогтоох, аврагч-шумбагчийг бэлтгэх зорилгоор ОХУ-ын Байгалын эрэн хайх, аврах отрядтай хамтарсан сургалт, судалгаа, дадлагыг 9 дүгээр сарын 15-28-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд Хөвсгөл нуурт хийж 50 алба хаагчийг хамруулан зохион байгуулсан.



Зураг 12. ОХУ-ын Байгалын эрэн хайх, аврах отрядтай хамтарсан сургалт, дадлага

ГАЛ УНТРААХ, ЭРЭН ХАЙХ, АВРАХ ЗОРИУЛАЛТЫН АВТОМАШИНУУДЫН ЖОЛООЧ НАРЫН СУРГАЛТ

Онцгой байдлын ерөнхий газраас Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын хөнгөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлсэн “Онцгой байдлын албаны гамшигтай тэмцэх техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах” төслийн хүрээнд нийлүүлэгдэж байгаа сүүлийн шатны гал унтраах, эрэн хайх, аврах зориулалтын 15 автомашины жолооч нарын сургалт, дадлагыг зохион байгууллаа.



Зураг 13. Гал унтраах, эрэн хайх, аврах автомашины жолооч нарын сургалт, дадлага

Автомашины ашиглалт, угсралт, үйлчилгээний чиглэлээр төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын автын инженер, механикч, жолооч нарыг сургалтад хамруулсан юм. Эдгээр автомашинууд нь гал унтраах зориулалтын автомеханик шат, хээрийн эмнэлэг, штабын болон удирдлагын автомашин бөгөөд мөн алба хаагчдыг ой, хээрийн болон аврах ажиллагаанд тээвэрлэн хүргэх зориулалттай юм.

ТАРИМАЛ УРГАМЛЫН СОРТ СОРИЛТ, ҮР ҮРЖҮҮЛГИЙН СУРГАЛТ

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/84 тоот тушаалын дагуу Гамшиг судлалын хүрээлэнгээс Булган, Сэлэнгэ, Төв аймгийн Онцгой байдлын газрын Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн ангийн захирагч, агрономичид болон Хэнтий, Увс аймгийн Онцгой байдлын газрын Улсын нөөцийн салбар, цэгийн дарга, эрхлэгч, агрономич нарт сорт, сорилт, үр үржүүлгийн арга зүйн “Таримал ургамлын сорт сорилт, үр үржүүлэг” сургалтыг 2021 оны 04 дүгээр сарын 13-16-ны өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Уг сургалтаар таримал ургамлын онцлог, үрийн норм тогтоох, соёололт, ургац тогтоолт, хянан баталгаа хийх арга зүй, биометрийн хэмжилт, талбайн журнал хөтлөлт, түүний ач тус, хөрсөнд бордоо хийх норм зэрэг сорт сорилт, үр үржүүлгийн ажил явуулахад анхаарах зүйлийн талаар мэргэжлийн сургалт, зөвлөгөө өглөө.

НӨӨЦ-АР ТАЛ, ХАНГАЛТЫН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СУРГАЛТ

ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгийн Нөөц судлалын төвөөс “Нөөц-Ар тал, хангалтын удирдлага зохион байгуулал” сэдэвт цахим онол, арга зүйн семинарыг ДХИС, Онцгой байдлын газрын Улсын нөөцийн газруудтай хамтран цахим зохион байгууллаа. Тус сургалтанд Нөөц судлалын төвийн дарга, доктор, профессор П.Даш “Улсын нөөцийн удирдлага, зохион байгуулалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд” сэдвээр, тус төвийн гэрээт судлаач, бэлтгэл хурандаа П.Батаахүү “Улсын нөөцийн сорт сорилтын ажиллагааны өнөөгийн байдал” сэдвээр, гэрээт судлаач, бэлтгэл хурандаа Ж.Амарсанаа “Гамшигийн үеийн өвс, тэжээлийн хангалтын өнөөгийн байдал” сэдвээр тус тус мэргэжлийн сургалт зохион байгуулж, зөвлөгөө өглөө.

ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦУВААНД ГАРСАН ГАЛ ТҮЙМРИЙГ УНТРААХ ТАКТИКИЙН СУРГАЛТ

Нийслэлийн Онцгой байдлын газраас Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замтай хамтран “Галт тэрэгний цуваанд үүссэн осол, шатах тослох материал алдагдаж гарсан гал түймрийг унтраах тактикийн сургууль”-ийг зохион байгууллаа. Дадлага сургууль Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Улаанбаатар төмөр замын 396 дугаар километрийн төмөр замын гарам дээр боллоо.

Гал түймэр унтраах тактикийн сургуульд ОБЕГ-ын Үндэсний Аврах бригадын химийн салбар, НОБГ-ын Аврах анги, Гал түймэр унтраах, аврах 10, 18, 26 дугаар ангийн бүрэлдэхүүнүүд, Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замын Гамшгаас хамгаалах штаб, ЦХОБАлба, бусад холбогдох салбар нэгж, гал түймэр унтраах сайн дурын бүлгэмийн гишүүд байгууллагын ажилтнууд оролцож, дадлага сургуулийн төлөвлөгөөний дагуу үүргээ гүйцэтгэсэн юм.



Зураг 14. Галт тэрэгний цуваанд гарсан гал түймрийг унтраах тактикийн сургалт

САЛААНЫ ЗАХИРАГЧ НАРЫН СУРГАЛТ

Бүгд Найрамдах Франц Улсад үйлдвэрлэгдсэн “РИНО” загварын гал түймэр унтраах үндсэн албаны автомашиныг ашиглах, алба хаагчдыг дадлагажуулах сургалтыг зохион байгуулж, РИНО загварын автомашины багаж зэвсэглэмжийн ашиглалт, ажиллах зарчим, нүүрс төрөгчийн гал унтраагуурын ашиглалт, аюулгүй байдал, гал унтраах арга зүй, гал түймэр унтраах үеийн хайгуулын ажиллагаа зэрэг сэдвүүдээр хичээл сургалт орлоо. Сургалтад НОБГ-ын Гал түймэр унтраах, аврах ангиудын Салааны захирагч нар хамрагдлаа.

ТОГТМОЛ УСАНД ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГААНЫ ДАДЛАГА СУРГУУЛЬ

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газраас алба хаагчдын мэргэжлийн мэдлэг ур чадварыг дээшлүүлж албаны бэлтгэл, бэлэн байдлыг хангах зорилгоор “Тогтмол усанд эрэн хайх, аврах ажиллагааны дадлага сургууль”-ийг зохион байгуулсан.

Сургалтад Сүхбаатар сум дахь Гал түймэр унтраах, аврах 36, Мандал сум дахь Гал түймэр унтраах, аврах 19, Сайхан сум дахь Гал түймэр унтраах, аврах 61, Баянгол сум дахь Гал түймэр унтраах, аврах 40 дүгээр анги, Эрэн хайх, аврах анги, салбарын нийт 43 алба хаагч хамрагдлаа.



Зураг 15. Тогтмол усанд эрэн хайх, аврах ажиллагааны дадлага сургууль

1.4.3 Техник хэрэгсэл, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт

2021 онд гамшгаас хамгаалах техник, хэрэгслийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор төв орон нутгийн Онцгой байдлын албанд ашиглагдаж байгаа тусгай болон туулах чадвар өндөртэй автомашинуудад шинэчлэлт хийж, аврах ажиллагаанд зориулагдсан хорт утааны хошуувч, цахилгаан үүсгэвэр, олс, хорт бодисноос хамгаалах хувцас, тусгай болон туулах чадвар өндөртэй автомашины дугуй, аккумулятор, гал унтраах хөөс үүсгэгч бодис, галын хоолой зэргийг худалдан авч, төв, орон нутгийн онцгой байдлын анги, байгууллагуудад хуваарилсан байна.

Гадаад улсын засгийн газрын нөхцөлт зээлийн хүрээнд:

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар

хоорондын Санхүүгийн зээлийн хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлж буй “Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагааны нэгж байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх” төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд: Буянт-Ухаа Олон улсын нисэх онгоцны буудлын хамгаалалтын бүсэд ангар, сургалтын байгууламж барих, агаараас эрэн хайх, аврах үйл ажиллагаа явуулах ЕС-145 маркийн 3 ширхэг нисдэг тэрэг, 1 ширхэг сургалтын Кабри нисдэг тэрэг, сургалтын симулятор нийлүүлэгдсэн.

Бүгд Найрамдах Франц Улсаас Гал унтраах үндсэн албаны автомашин 35, автомеханик шатны автомашин 3, удирдлагын зориулалттай автомашин 1 ширхэгийг тус тус хүлээн авсан. Мөн Бүгд найрамдах Беларусь Улсаас хүн тээврийн Маз маркийн автомашин 1, Пум маркийн удирдлагын автомашин 1 ширхэгийг хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн Онцгой байдлын газар хэлтсүүдэд хувиарласан байна.

Хандив тусламжийн хүрээнд 2021 онд “Дөрвөлжин интернэйшнл” ХХК-иас тусгай зориулалтын аврах ажиллагааны багажны ком болох зай хураагуураар ажилладаг тасдагч, тэлэгч, 30-60 тн-ын даацтай өргөгч хийн дэр, ивүүр, хутга, бээлий, нүүр хамгаалах хэрэгсэл мөн Бүгд найрамдах Турк Улсын буцалтгүй тусламжаар бүрэн тоноглогдсон эмнэлгийн зориулалттай 70 сертэй автомашин 1 ширхэгийг хүлээн авсан байна.

БҮЛЭГ 1.5. ГАМШГААС ХАМГААЛАХ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИ

1.5.1. Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн үйл ажиллагаа

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн А/153 дугаар тушаалаар “Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх журам”-ыг боловсруулж, батлууллаа.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/163 дугаар тушаалаар батлагдсан Хурандаа генерал С.Равдангийн нэрэмжит “Гамшгийн эрсдэлийг бууруулах” үндэсний шагнал олгох журмыг шинэчлэн боловсруулж, батлуулсан.

Онцгой байдлын ерөнхий газрын Шинжлэх ухаан технологийн зөвлөл, Гамшиг судлалын хүрээлэнгээс хагас жил тутам эрхлэн гаргадаг “Гамшиг судлал, инновац” онол аргагүйн сэтгүүлд Олон улсын эрдэм шинжилгээний стандарт дугаар (ISSN) авах ажлыг зохион байгуулж ISSN 2790-1181, eISSN 2790-119Хдугаар авч олон улсад бүртгэлтэй албан ёсны сэтгүүл боллоо.

“Гамшгаас хамгаалах бодлого, стратеги” суурь судалгааны ажлын тайланг 2021 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр ШУА-ийн Нийгмийн шинжлэх ухааны салбарын бага чуулганаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. “Гамшгаас хамгаалах бодлого, стратеги” ISBN 978-9919-24-577-1 дугаартай ном гарган БШУЯ, ШУТСанд тус тус хүлээлгэн

өглөө.

ОБЕГ-ын ШУТЗ, Гамшиг судлалын хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Гамшиг судлал инновац” сэтгүүл 2021.№1(6), 2021.№2(7) гэсэн 2 дугаарыг хэвлэн гаргасан.

ГСХ-ийн Нөөц судлалын төв, ОБС-ийн Гамшиг судлалын профессорын багтай хамтран “Улсын нөөц, түүний удирдлага”, “Логистик” сурах бичгийг тус тус хэвлүүлэн сургалтад ашиглаж байна.

2021 онд тохиолдсон гамшгийн нөхцөл байдлын мэдээлэл, учирсан хохирол, хор уршгийг арилгах арга хэмжээ, түүнээс авсан сургамж, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн гаргадаг “Гамшгаас хамгаалах цагаан ном-2020”-ийг Монгол, Англи хэлээр эхийг бэлтгэж хэвлүүлэв.

Монгол Улсад орчин цагийн шинжлэх ухааны байгууллага байгуулагдсаны 100 жилийн ой, “Шинжлэх ухааны ажилтны өдөр”-ийг тохиолдуулан ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгээс гаргасан ном бүтээлүүдийг Үндэсний төв номын сан, ШУТС, МУИС, ШУТИС, ДХИС-ийн ОБС мөн ЭШНХ, ҮБХИС, БХЭШХүрээлэнгүүдэд бүтээлийнхээ дээжээс 800 гаруй номыг өргөн барьлаа.

Оюуны өмчийн талаар Онцгой байдлын байгууллагын баримтлах бодлого, Онцгой байдлын байгууллагын инновацийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад аргагүйн дэмжлэг үзүүлэх чиглэлд:

1. Ганд тэсвэртэй буудайн нутагшсан сорт сорих туршилт, судалгааны ажлын үр дүнг улсын сорт сорилтын зөвлөлөөр хэлэлцүүлж ирээдүйтэй сортоор батлуулсан.

2. МУЗГ-ын Хэрэг эрхлэх газрын захиалгаар хэрэгжүүлэхээр зарлагдсан Инновацыг дэмжих хөтөлбөрт Дархан-Уул аймгийн ОБГ-ын санаачлан хийсэн “Ариутгалын төхөөрөмж” төслөөр оролцов.

3. Байгалийн эрдэст багсармал тэжээл Гарааны компанийн үйлдвэрлэж байгаа байгалийн эрдэст багсармал тэжээлийн бар код авах талаар “GS1 Монгол” нийгэмлэгтэй хамтран ажилласан байна. Тэжээлийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлж 15 тонн тэжээл үйлдвэрлэжээ.


4. Сингапурын их сургууль, Удирдлагын академиас хамтран зохион байгуулсан Бодлогын инноваци сургалтад 5 алба хаагчийг оролцуулж, сургалтын хүрээнд зарлагдсан төслийн уралдаанд шалгарч Бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээ авах эрх авсан.

1.5.2. Онцгой байдлын байгууллагын сургалт, эрдэм шинжилээний нэгжүүдийн гүйцэтгэсэн судалгаа, шинжилгээний ажил

НЭГ. СУДАЛГААНЫ АЖИЛ

1.1 Гамшиг судлалын хүрээлэн


Гамшиг судлалын хүрээлэн нь байгуулагдсан цагаасаа хойш буюу 2005-2021 онд нийт 125 судалгааны ажлыг хийж гамшиг судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажилласан байна.



Зураг 16. 2005-2021 он хүртэлх Гамшиг судлалын хүрээлэнгийн гүйцэтгэсэн судалгааны ажлын тоо


Тус хүрээлэнгийн 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлын амжилт бүтээлээс онцлон дурьдвал:

1. “Гамшгаас хамгаалах бодлого, стратеги” сэдэвт суурь судалгааны тайланг ШУА-ийн Нийгмийн шинжлэх ухааны салбарын бага чуулганаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. Уг судалгааны ажил нь БШУЯ-ны захиалгаар Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтээр хийгдсэн тус хүрээлэнгийн анхны томоохон суурь судалгаа бөгөөд энэ судалгааны үр дүнгээр “Гамшгаас хамгаалах бодлого, стратеги” сэдэвт бүтээл туурвиснаараа онцлог юм.




Зураг 17. 2021 онд хэвлэгдсэн ном, сэтгүүл

2. Онцгой байдлын ерөнхийн газрын захиалгат, Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтээр хийгдсэн “Ой, хээрийн түймрийг эрт илрүүлэхэд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зарим асуудал” сэдэвт судалгааны ажлын эцсийн тайланг ГСХ-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, эцсийн тайланг ШУТС-д хүлээлгэн өгсөн.



Зураг 18. Судалгааны ажлын эцсийн тайлан


3. 2021.03.24-ны өдөр ОБЕГ, ООГФХ, “Дэлхийн зөн Монгол” ОУБ-уудтай хамтран “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт шинжлэх ухаан, танин мэдэхүйн цахим сургалтыг улс орон даяар зохион байгууллаа.



Зураг 19. “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт цахим хурал

4. Гамшиг судлалын хүрээлэнгийн MNS ISO 9001:2016 “Чанарын удирдлагын менежмент”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Чанарын менежментийн тогтолцоог сайжруулах, MNS ISO 9001:2016 стандартын хэрэгжилтийг хангаж, магадлах 2 дугаар шатны хөндлөнгийн аудитад хамрагдан, Олон улсын итгэмжлэлийн форум нэгдсэн мэдээллийн санд албан ёсны бүртгэлтэй, MNS ISO 9001:2015 стандартад нийцсэн байгууллага боллоо.

Гамшигаас хамгаалах үйл ажиллагаанд дэвшилт технологи инновац нэвтрэх орчин бий болгох хүрээнд Бүтээмжийн хөтөлбөр хэрэгжүүлэх журам, гарын авлага боловсруулав.



Зураг 20. MNS ISO 9001:2016 стандартын хэрэгжилтийг ханган ажиллалаа

Тус хүрээлэн нь 2021 онд дараах 5 судалгааны ажлыг гүйцэтгэж, явцын болон эцсийн тайланг Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн хүлээн авсан байна.

Хүснэгт 1. Гамшиг судлалын хүрээлэнгээс 2021 онд гүйцэтгэсэн судалгааны ажил

ОБЕГ-ын захиалгат судалгаа		ШУТсангийн санхүүжилтээр	
1	Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн чадавхыг сайжруулах арга зам	4	Гамшгаас хамгаалах бодлого, стратеги
2	Онцгой байдлын алба хаагчдын сэтгэлзүйн байдалд хийсэн шинжилгээ	5	Хээрийн түймрийг эрт илрүүлэхэд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зарим асуудал
3	Усны ослын эрсдэлийг бууруулах судалгаа		

Эдгээр судалгааны ажлын дэлгэрэнгүй тайлан, үр дүнгийн талаар Гамшиг судлалын хүрээлэнгийн бүтээлийн эмхэтгэл 2021 номноос дэлгэрэнгүй харж болно

1.2 Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сурууль

ДХИС-ийн Онцгой байдлын сургуулийн үйл ажиллагаа нь аюулгүй байдал, гамшигтай тэмцэх салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэх, үр дүнг салбарын үйл ажиллагаанд нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулахад чиглэгдэнэ.

Онцгой байдлын сургууль нь 2021 онд 4 эрдэм шинжилгээний бага хурал, 2 онол арга зүйн семинар тус тус зохион байгуулж гамшиг судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллажээ.

- **Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн ГТТАТ-ийн дэд профессор, дэд хурандаа Б.Энхтүвшин**

“Гал түймрийн эрсдэлийн үнэлгээнд суурилсан Монгол Улсын галын аюулгүй байдлын менежментийг дэмжих загвар ба алгоритмууд” сэдвээр 2021 оны 03 дугаар сарын 31 – ний өдөр ОХУ-ын Онцгой байдлын яамны харьяа “Гал эсэргүүцэх албаны академи”-ийн докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд “техникийн ухаан”-ы доктор (Ph.D)-ын зэрэг амжилттай хамгааллаа.

Диссертацийн ажлын шинэлэг тал нь дараах дөрвөн санааг дэвшүүлсэн. Үүнд:

1. Монгол Улсын хувь хүний гал түймрийн эрсдэлд өртөх стандарт утгыг анх удаа тогтоосон.

2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн гал түймрийн эрсдэлийн утгыг тогтоох, гал түймрийн эрсдэлийн нийгэм, эдийн засгийн салшгүй үзүүлэлтүүдийг гаргаж Монгол Улсын гал түймрийн эрсдэлийг удирдах алгоритм боловсруулсан.

3. Хувь хүний гал түймрийн эрсдэлийн дээд ба доод түвшинг тооцоолох алгоритмыг боловсруулж, Монгол Улсын хувьд хүний гал түймрийн стандарт (норматив) утгыг боловсруулсан.

4. Монгол Улсын засаг захиргааны нэгжийн гал түймрийн эрсдэлийн менежментийн загварыг үндэслэн Монгол Улсын бүс нутгийн гал түймрээс хамгаалах нэгжүүдийн байршлыг үндэслэн гал түймэр унтраах, аврах ангийн галын аюулын түвшинг бууруулах эрсдэлийн математик загварыг тус тус боловсруулсан.

Судалгааны үр дүн нь Монгол Улсын Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн “Онцгой байдал-Гамшгаас хамгаалах алба” хөтөлбөр, ОХУ-ын Онцгой байдлын яамны харьяа Гал эсэргүүцэх албаны академийн эрсдэлийн удирдлага хичээлийн лекцийн сан; Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын гал түймрийн эрсдэлийн төлөвлөгөөнд диссертацийн ажлын үр дүн тусгагдсан байна.

- **Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн Гамшгаас хамгаалах албаны тэнхимийн дэд профессор, дэд хурандаа Ц.Ганчимэг**

“Гамшигт эмзэг бүлгийн эрсдэлийг бууруулах боломж” сэдвээр 2021 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Дотоод хэргийн их сургуулийг түшиглэсэн докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн хуралдаанаар Гамшиг судлалын докторын зэрэг амжилттай хамгааллаа.

Судалгааны ажлын шинэлэг тал. Гамшигийн эрсдэл, түүний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, амьжиргаа, улс орны эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчинд учрах хохирлыг бодитой бууруулах, урьдчилан сэргийлэх нь дэлхий нийтийн хэмжээнд тулгамдаад буй өнөө үед гамшигт эмзэг бүлэгт нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох, тэдгээрийг хамгаалахад чиглэсэн эрх зүйн зохицуулалт,

хууль тогтоомж өөр хоорондоо зөрчилтэй байгааг тогтоох, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох оролдлого хийснээрээ энэхүү судалгааны ажил шинэлэг болсон юм.

- **Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн Эдийн засаг-нөөц, ар талын тэнхимийн дэд профессор, хошууч Б.Саранцэцэг**

“Гамшиг судлал” чиглэлээр “Гамшгийн эрсдэлийн менежментийг сайжруулах боломж” сэдвээр 2021 оны 07 дугаар сарын 10-ны өдөр докторын зэрэг хамгааллаа.

Судалгааны ажлын шинэлэг тал. Гамшгийн эрсдэлийн менежментийн онол, арга зүй, мөн чанар, олон улсын туршлага, эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдлын хүчин зүйлийн шинжилгээ, стратегийг тодорхойлж, гамшгийн эрсдэлийн менежментийг сайжруулах чиглэлийг шинжлэх ухааны үүднээс онол, практикийн түвшинд цогц байдлаар судалсан нь судалгааны ажлын шинэлэг тал юм.

Мөн гамшгийн эрсдэлийн менежментийн онол, арга зүй эрх зүйн зохицуулалтад хийсэн дүгнэлт, асуулга, судалгааны хүчин зүйлийн шинжилгээ, түүний үр дүнгээс гарсан тулгамдсан асуудал, түүнийг боловсронгуй болгох чиглэл, зөвлөмж, хувилбар боловсруулсан зэрэг нь судалгааны ажлын практик ач холбогдлыг харуулсан юм.

Онцгой байдлын сургуулийн “Гамшиг судлалын профессорын баг”-ийн 2021 оны үйл ажиллагаа.

Их сургуулийн Эрдмийн дэд зөвлөл, профессорын багийн 3 удаагийн хуралдаанаар 2 докторант, 25 магистрантын судалгааны ажлын сэдвийг батлуулах, 1 сурах бичиг, 2 гарын авлага, эмхэтгэл, 5 докторантын судалгааны ажлын явц, 26 магистрантын судалгааны ажлын явцыг хэлэлцсэн. “Гамшиг судлал”-ын магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар 9 магистрантын судалгааны ажлыг хэлэлцэж, 100 хувь саналаар дэмжин магистрын зэрэг олгохоор шийдвэрлэсэн.

Эрдэм шинжилгээний ном, сурах бичиг, илтгэл, өгүүлэл

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургууль нь 2021 онд нийт ОХУ-д 4 эрдэм шинжилгээний өгүүлэл, 5 эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлж, дотоодод 8 эрдэм шинжилгээний өгүүлэл, 8 эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлж нийт 1 сурах бичиг, 21 эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл хэвлүүлэн нийтийн хүртээл болгожээ.

ХОЁР. ЛАБОРАТОРИЙН ТУРШИЛТ, ШИНЖИЛГЭЭ

Гамшиг судлалын хүрээлэнгийн Гал болон химийн лаборатори нь сүүлийн 16 жилийн хугацаанд жилд дунджаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн 184 бодис, материалд галын аюулын үзүүлэлтийг тодорхойлсон дүгнэлтийг,

түүнчлэн шүүх, прокурор, мөрдөгчийн тогтоолын дагуу гал түймрийн хэргийн газраас ирүүлсэн 320 дээжинд шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажиллажээ. Түүнээс гадна жилд дунджаар улсын хэмжээнд гарсан томоохон хэмжээний 150 гал түймрийн шалтгаан нөхцөлийг тодорхойлоход шинжээчээр ажилласан. Зөрчлийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор тус лабораторид хандан дүгнэлт гаргуулахаар ирүүлж буй гал түймрийн шалтгаан тогтоох шаардлагатай дээжийн тоо эрс нэмэгдсэн. Нийт шинжилгээнд ирж буй дээжний 42 хувийг цахилгаан дамжуулагчид шинжилгээ хийх дээж материал эзэлж байна.



Зураг 21. 2006-2021 онд Галын лабораторид ирүүлсэн материалын галын аюулын үзүүлэлтийг тодорхойлуулах хүсэлт болон шинжилгээ хийсэн бүтээгдэхүүний тоо

Гамшиг судлалын хүрээлэнгийн Галын лаборатори нь 2021 онд аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хүсэлтээр 140 албан бичгээр ирсэн 161 дээжинд туршилт шинжилгээ хийж, 140 лабораторийн сорилтын дүгнэлт гаргаж, шүүх цагдаагийн байгууллага, хэрэг бүртгэгч, мөрдөгчийн 153 тогтоолоор 320 дээжинд шинжилгээ хийж, шинжээчийн 153 дүгнэлт гарган ажиллажээ.

Химийн лаборатори нь цагдаагийн газраас "Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тухай" 148 мөрдөгчийн тогтоолын дагуу гал түймрийн хэргийн газраас шинжилгээнд ирүүлсэн 276 дээжийг хүлээн авч, шинжлэн 148 шинжээчийн дүгнэлт гаргасан байна.


2021 онд нэгдсэн дүнгээр 441 албан бичгийн хүрээнд ирүүлсэн 757 дээжинд батлагдсан стандарт, арга, аргачлалын дагуу холбогдох сорилт, шинжилгээг хийж, 441 шинжээчийн дүгнэлт болон лабораторийн сорилтын дүн гарган шийдвэрлэсэн байна.

ГУРАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ, СУРГАЛТ

"Коронавируст халдварын цар тахлын үеийн шинэ хэв маягт дасан зохицох нь" сэдэвт онол, практикийн бага хурал:

Монголын улаан загалмай нийгэмлэгтэй хамтран "Коронавируст халдвар /

Ковид-19/ цар тахлын үеийн шинэ хэв маягт дасан зохицох” нь сэдэвт онол практикийн бага хурлыг 2021 оны 9 сарын 30-нд зохион байгуулж, тус бага хурлаар хэлэлцүүлсэн илтгэлүүдээр эмхэтгэл хэвлүүлж нийтийн хүртээл болгосон.



Зураг 22. Онол, практикийн бага хурал

Хуралд Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн онцгой байдлын газар, Үндэсний аврах бригад, Гамшгаас хамгаалах улсын албад, Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв, Монголын улаан загалмай нийгэмлэг, Дотоод хэргийн их сургууль, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн, эрдэмтэн судлаачид зэрэг нийт 10 байгууллагын 30 гаруй төлөөлөл оролцож, коронавируст цар тахлын үе дэх амьдралын шинэ хэв маягт дасан зохицож буй талаарх бусад улс орны туршлага, сургамжаас суралцаж, салбарын болон салбар дундын хамтын ажиллагааг коронавируст халдварт цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан хөгжүүлэх, амьдралын шинэ хэв маягт дасан зохицох нөхцөл боломжийг тодорхойлох чиглэлээр шинэлэг санааг агуулсан онол, арга зүйн болоод практик ач холбогдолтой 7 илтгэлийг хэлэлцлээ. Тус хурлыг зохион байгуулснаар коронавируст цар тахлын үеийн шинэ хэв маягт дассан зохицоход салбаруудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, шинжлэх ухаанд суурилсан бодлого, шийдвэрийг гаргах аргазүйн талаар зөвлөмж гарах, шинэ хэв маягт дассан зохицоход шаардлагатай аргазүй, аргачлалын талаарх оролцогч талуудын мэдлэг, ойлголт нэмэгдэж, талуудын харилцан мэдлэг, туршлагаа хуваалцаж хамтын ажиллагаа сайжрах нөхцөл бүрдэхэд ач холбогдолтой байсан юм.

“Шинжлэх ухаанч ГЭБ санаачилга” сэдэвт арга хэмжээ:

ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэнгээс “Дэлхийн Зөн Монгол” ОУБ-тай хамтран Монгол Улсад орчин цагийн Шинжлэх ухааны байгууллага үүсэж

хөгжсөний 100 жилийн ой, “Шинжлэх ухааны ажилтны өдөр”-ийг тохиолдуулан зохион байгуулсан Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг багасгах чиглэлээр “Шинжлэх ухаанч гамшгийн эрсдэлийг бууруулах санаачлага” сэдэвт арга хэмжээг 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр зохион байгууллаа.

ШИНЖЛЭХ УХААНЧ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ САНААЧЛАГА
сэдэвт арга хэмжээний нээлт, “Эрдэмтдийн үе” хэлэлцүүлэг

ПҮРЭВИЙН ДАШ
Мэдээлэл: ГСХ-ийн Ивээх Судлалын төвийн дарга, хэргийн генерал, доктор Ph.D, профессор

Д.СЭРИНЧИДАГ
Зочин урьдчилсан: Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Аюулын албаны ахлах референт, доктор (Ph.D), дэд профессор, дэд хурандаа

М.АЛТАНБАГАНА
Зочин урьдчилсан: ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хуралтөрийн Нийгэм, эдийн засгийн газаруудын салбарын дарга, доктор (Ph.D), профессор

Ч.ОДОНБААТАР
Зочин урьдчилсан: Орлон голлохын хуралтөрийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), профессор

Б.ЭРДИНЦЭЦЭГ
Зочин урьдчилсан: Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хуралтөрийн Хөдөө аж ахуйн цаг уурын судалгааны хэлтсийн дарга, доктор (Ph.D)

ИИТГЭЛИЙН ЧИГЭЭЛ
Гамшгийн эрсдэлийг бууруулахад шинэчлэн ухааны аргачлалыг хөгжүүлэх нь сэрвэлж, шийдэл

ИИТГЭЛИЙН ЧИГЭЭЛ
Уур амьсгалын өөрчлөлтөөс нийгэм эдийн засагт уулзвал эрхдэг, эмгэг байдлын судалгаа

ИИТГЭЛИЙН ЧИГЭЭЛ
Монгол орны газар мэдлэлийн аюулын уналттай судалгаа

ИИТГЭЛИЙН ЧИГЭЭЛ
Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилсан гэмтлийн эрсдэл, даалгавал, гас, гүйц, үр, г.м.л, түүнийг бууруулахад амжилтын аргаар

Хэлэлцүүлгийн өдөр: 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр
Хоч: БУД, 4 дугаар хороо, Ажлаа хотын баруун талд

Хоч: Найзгалын-Гамшгаас хамгаалах суртал, арга зүйн төв



Зураг 23. “Шинжлэх ухаанч ГЭБ санаачлага” сэдэвт арга хэмжээний үеэр

Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлого Алсын хараа 2050 баримт бичигт “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулна (2021-2030)”, “Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг үр дагаврыг багасгах, гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөрийг шинэчилж хэрэгжүүлнэ (2031-2040)” гэж тусгажээ. Монгол орны хувьд сүүлийн 80 жилийн хугацаанд жилийн дундаж температур 2.2 хэмээр нэмэгдсэн. Энэ нь дэлхийн дунджаас 2.5 дахин эрчимтэй буюу Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд

өртөх магадлал өндөртэй гэдгийг харуулсан. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй цаг агаарын гамшигт үзэгдлийн тоо сүүлийн 20 жилд өмнөх 10 жилтэй нь харьцуулахад гамшгийн төрөл зүйл бүрээр хоёр дахин нэмэгдсэн байна. Тус арга хэмжээ нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлд шинжлэх ухааны салбаруудын оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны үр дүнг инновац болгоход чухал ач холбогдолтой 4 илтгэлийг хэлэлцүүлсэн.

Хэлэлцүүлэгт ОБЕГ, Гамшиг судлалын хүрээлэн, НОБГ, Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалтын төв, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, БШУЯ, Шинжлэх ухааны академи, УЦУОСМХ, Одон орон, геофизикийн хүрээлэн, Газарзүй геоэкологийн хүрээлэн, Стратеги судалгааны хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, ДХИС-ын Онцгой байдлын сургууль, ҮБХИС, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, яам, эрдэм шинжилгээний хүрээлэн болон “Дэлхийн Зөн Монгол” ОУБ, МУЗН-ийн эрдэмтэн судлаачид оролцсон.

1.5.3. Онцгой байдлын байгууллагын инновацийн үйл ажиллагаа

Онцгой байдлын байгууллагын хэмжээнд инновацийн үйл ажиллагаа нь Инновацийн тухай хууль, “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого”, Шинжлэх ухаан технологийн тухай хууль, Патентын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай хууль, ОБЕГ-ын даргын 2017.12.20-ны өдрийн А/332 тушаалаар батлагдсан “Оюуны өмчийн талаар онцгой байдлын байгууллагын баримтлах бодлого”, ОБЕГ-ын даргын 2017.12.21-ний А/334 тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын инновацийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө” зэрэг эрх зүйн баримт бичгийн хүрээнд явагдаж байна.

Онцгой байдлын байгууллагын “Бүтээмжийн хөтөлбөр”-ийг байгууллагын алба хаагч, ажилчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, инновацийн мэдлэгийг сайжруулах, тэдгээрийг шинэ, шинэлэг санаа, дэвшилтэт арга, шийдлийг дэвшүүлж үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг дэмжих орчныг бүрдүүлж, байгууллагын ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлэх юм.


Хөтөлбөр нь 5 жилийн хугацаанд нэгд, Онцгой байдлын байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх орчин бүрдүүлэх; хоёрт, Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилчдын бүтээлч хандлагыг төлөвшүүлэх замаар байгууллагын чанарын удирдлагад тасралтгүй сайжруулалтыг хэвшүүлэх; гуравт, Сайн саналын системээр дамжуулан инновацийн дотоод эх үүсвэрийг бий болгох гэсэн 3 зорилтын хүрээнд 3 үе шатаар хэрэгжих ба зохион байгуулалтын 3 түвшинд “5 сайн зарчим (5С)”, “Сайн саналын систем (3С)”-ийг өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр ажлын бүтээмж дээшилсэн үр дүнгээр хэмжигдэнэ.

Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөр,

/ОБЕГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/292 тоот тушаал/

Хөтөлбөрийн зорилго

Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтнуудын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, инновацын мэдлэгийг сайжруулах, тэдгээрийг шинэ, шинэлэг санаа, дэвшилтэт арга, шийдлийг дэвшүүлж үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг дэмжих орчныг бүрдүүлж, байгууллагын ажлын бүтээмжийг дээшлүүлэх



Зураг 24. Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөрийн товч агуулга

Онцгой байдлын байгууллагын салбар нэгжүүдээс 2018 оноос эхлэн үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хийгдсэн ажлын судалгааг авч дүн шинжилгээ хийж үзэхэд гадны сайн туршлага, техник, технологи нэвтрүүлсэн ажил 70%, өөрсдийн гараар ажлаа хялбаршуулж бүтээмжээ нэмэгдүүлсэн ажил 30 орчим хувийг эзэлж байна.

ОББ-ын алба хаагчдын санаачилсан бүтээлүүдээс харахад ихэвчлэн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хийж санаачилсан байгаа нь тэдний ажлыг урамшуулах, дэмжих орчин бүрдүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна. Иймээс Гамшиг судлалын хүрээлэнгээс Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөрийг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хангахаар төлөвлөн ажилласан байна.

Бүтээмжийн зөвлөл нь бүтээмжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, тухайн салбар, нэгжийн онцлогт тохирсон бүтээмжийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөтөлбөртэй холбоотой аливаа асуудлаар удирдах зөвлөлд мэдээлэл хийх, санал уламжлах; бүтээмж, чанарын бүлгүүд нь тухайн бүтцийн нэгжийн хэмжээнд бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хувь хүний хандлага, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх; бүтээмж, чанарын бүлгүүд (БЧБ) нь салбар, нэгжүүд өөрсдийн хариуцсан ажлыг багийн зохион байгуулалттайгаар сайжруулж, харилцан өөрсдийгөө хөгжүүлэх замаар байгууллагын чанарын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож улмаар чанар, үр ашиг, бүтээмжийг сайжруулах үүрэгтэйгээр оролцох юм. БЧБ-ийн гишүүд үйл ажиллагаа явуулахад өөрт тулгамдаж байгаа асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох ба үүний үр дүнд алба хаагч, ажилтнууд шийдвэр гаргалтад нөлөөлснөөр тэдний ажилдаа хандах хандлага сайжирч бүтээмж нэмэгдэнэ.



Зураг 25. Бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүүдүүч

БЧБ-үүд нь 5 сайн зарчим (5С), Сайн саналын систем (3С) гэсэн 2 аргыг хэрэгжүүлж бүтээмжээ нэмэгдүүлэх ба эдгээр нь харилцан шүтэлцээтэй үйл ажиллагаа байна.

“5 сайн зарчим” (5С) нь хамгийн өндөр бүтээмжтэй хамт олон төдийгүй хамгийн бүтээмжтэй байгууллага болох анхны алхам юм. 5С-ийг хэрэгжүүлснээр ажлын байр, хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох стандарт журмыг тогтоон хэрэгжүүлэх, ажлын чанарыг сайжруулах, алба хаагч, ажилтнуудын хөдөлмөрийн сахилга батыг төлөвшүүлэхэд чиглэсэн системтэй үйл ажиллагааг бүрдүүлнэ. Өөрөөр хэлбэл ажлын байрны зохион байгуулалтыг сайжруулах, ажлын төвөгшлийг багасгах, богино хугацаанд бага зардлаар илүү ихийг хийж гүйцэтгэх арга хэрэгслийн цогц юм.

5С зарчимын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дараах алхамуудыг баримтална.

Үүнд:


1. Тасралтгүй сайжруулах 4 алхам (төлөвлөх -> хийж гүйцэтгэх -> үйл ажиллагаа ба үр дүнгээ хянах -> үйл ажиллагаагаа хэвшүүлэх) – ыг баримтлах,

2. Сурсан зүйлээ хэвшүүлэх 4 алхам (сайжруулж байгаа үйл ажиллагаандаа стандарт тогтоох -> стандартын дагуу хийж гүйцэтгэх -> стандартын биелэлт, үр дүнд хяналт тавих -> үйл ажиллагаагаа хэвшүүлэх) - ыг хэрэгжүүлэх,

“Сайн саналын систем (3С)” нь аливаа үйл ажиллагааг тасралтгүй алхам алхамаар сайжруулах чиг хандлага бөгөөд байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготойгоор алба хаагч, ажилтнуудаас гарах шинэлэг санаа, бодлыг нэгтгэх зорилготой хийгдэнэ. Сайн саналын систем нь аливаа асуудлыг бүх нийтээр хамтран хэлэлцэж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох үндсэн дээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулж, үр ашиг, бүтээмж чанарыг дээшлүүлэх чиглэлээр алба хаагч, ажилтнуудаас гаргаж байгаа шинэ санал санаачлагыг урамшуулан дэмжих систем юм. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр байгууллагын алба хаагч, ажилчдын бүтээлч хандлага нэмэгдэж, шинэ, шинэлэг санаа, дэвшилтэт арга, шийдлийг инновац болгох таатай орчин бүрдэж улмаар байгууллагын ажлын бүтээмж дээшлэх боломж бүрдэнэ.

Мөн Онцгой байдлын байгууллага бүхэлдээ MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлж эхэлсэнтэй холбоотой стандартыг нутагшуулах хэвшүүлэхэд чухал ач холбогдолтой.

Онцгой байдлын байгууллагын сургалт, бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын удирдамж, төлөвлөгөөг ОБЕГ-ын даргын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн А/110 тоот тушаалаар батлуулж, 5 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд Төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагын Гал түймэр, унтраах аврах ангийн захирагч, Эрэн хайх, аврах анги, салбарын захирагч, бүлгийн дарга нарын нийт 465 хүний бүрэлдэхүүнтэйгээр цахимаар зохион байгууллаа.



Зураг 26. 5 сайн зарчим "5C" үйл ажиллагааны цахим хурал

Онцгой байдлын байгууллагын бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх журмын хэрэгжилтийг хангах зорилгоор Модуль 2 цахим хичээлийг innovation.nema@gmail.com цахим хаягийн Google Classroom платформ ашиглан “Бүтээмж-Инновац” дундын ангид линкээр шууд холбогдож тогтмол ашиглах боломжтойгоор байршуулсан байна.

Мөн ДХИС-иас жил бүр зохион байгуулагддаг шилдэг инновацын бүтээл шалгаруулах уралдаанд Онцгой байдлын сургуулийн гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн ахлах багш, ахмад Л.Булганхангай “Аврагч-гал сөнөөгчдын давхар эргэх байнгын шат” угсрах төслөөр оролцож 2 дугаар байрт шалгарсан байна. Тус давхар эргэх байнгын шат нь гал сөнөөгч, аврагчдын бие бялдар, тэсвэр хатуужлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.



Зураг 27.
Инновац-2021
их сургуулийн
шилдэг бүтээлийн
уралдаанд тус
сургуулийн
ГТТАТ-ийн ахлах
багш, ахмад
Л.Булганхангай
2 дугаар байрт
шалгарсан

ХОЁРДУГААР ХЭСЭГ:

**ГАМШГААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ
БУУРУУЛАХ**



БҮЛЭГ 2.1. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1.1. Монгол Улсын Шадар сайдын баталсан нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийн удирдамжийн хүрээнд хийсэн ажил

Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2021 онд нийт 7 төрлийн нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийг зохион байгуулах төлөвлөгөө, удирдамжийг Монгол Улсын Шадар сайдаар батлуулж, хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулан ажиллаа.

Хүснэгт. 2021 онд зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийн хуваарь

д/д	Нэгдсэн арга хэмжээний нэр	2021 он											
		1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
1	Эрчим хүч, ус дулаан хангамжийн тогтвортой ажиллагаа, аж ахуйн нэгж байгууллага, айл өрхийн галын аюулгүй байдлыг хангуулах нэгдсэн арга хэмжээ	■	■	■	■	■							
2	Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ	■	■	■	■						■	■	■
3	Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ			■	■	■							
4	Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ						■	■	■				
5	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөрлөг			■									
6	Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөрлөг										■		
7	Олон улсын иргэний хамгаалалтын өдөрлөг			■									

2020 оны нэгдсэн арга хэмжээний удирдамжийг Монгол Улсын Шадар сайдаар “2021 онд зохион байгуулах нэгдсэн арга хэмжээ, өдөрлөг”-ийн удирдамжийн хүрээнд хийгдсэн ажлуудаас дурьдвал,

1. “Эрчим хүч, ус дулаан хангамжийн тогтвортой ажиллагаа, аж ахуйн нэгж байгууллага, айл өрхийн галын аюулгүй байдлыг хангуулах нэгдсэн арга хэмжээний удирдамж”-ийн төлөвлөгөөнд тусгасан ажлын үр дүнд эрчим хүчний хэрэглээний ачааллаас үүдэлтэй ноцтой гэмтэл, зөрчил үүсээгүй, цахилгаан станц, дулаан хангамж хэвийн хэмжээнд ажиллаж, 2020-2021 оны өвлийн улирлын их ачааллыг амжилттай давсан юм.

2. “Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон зудын аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-ний хүрээнд танхимын болон цахим сургалтыг 85 удаа зохион байгуулж, цаг агаарын нөхцөл байдалтай холбоотой сэрэмжлүүлэг мэдээ мэдээллийг Онцгой байдлын албаны цахим хуудсанд 1273 удаа байршуулж, үндэсний болон олон нийтийн 34 телевизэд 127 ярилцлага өгч, давхардсан тоогоор 400,968 малчдын гар утсанд цаг агаарын урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг / багц мессеж/-ийг хүргэж ажиллаа. Мөн аймаг бүрийн зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийж, төлөвлөгөө боловсруулан

хэрэгжүүлж ажилласан нь ихээхэн үр дүнтэй ажил болсон.

3. “Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-ний хүрээнд үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, голомтод үүрэг гүйцэтгэх хүч хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангаж ажилласан. Тус арга хэмжээний хүрээнд төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг, мэдээллийн багц мессежийг 51408 удаа, ярилцлага 184 удаа хийж, 22419 ширхэг сурталчилгааны материал тараан, 842649 иргэнд ухуулга сурталчилгаа хийж, үерийн аюултай бүсэд байрласан 38 айл өрхийг нүүлгэн шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

4. “Үер усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-ний хүрээнд “Үер уснаас үрсээ хамгаальа” аянг 2021-2022 онд хоёр үе шаттай зохион байгуулжээ. Мөн үерийн усны буулт бүхий газраар нутаглаж, суурьшсан 212 айл өрхийг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулж, үерийн далан, ус зайлуулах шугам, инженерийн байгууламжид үзлэг шалгалт зохион байгуулж, 119 м³ хог хаягдлыг цэвэрлэн, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газруудтай хамтран хөдөлгөөнт завьт эргүүл хийж, гол усанд осолдохоос урьдчилан сэргийлэх гарын авлага, тараах материалаас 5901 ширхэгийг тарааж, 53,372 иргэнд сэрэмжлүүлэг яриа хийж, голын эрэг дагуу байрласан 6210 тээврийн хэрэгслийг ногоон бүсээс гаргаж ажиллаа.

5. “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөрлөг”-ийг дэлхий нийтээр тархаад байгаа коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам”-д заасан түвшинтэй уялдуулан Улаанбаатар хот болон 13 аймагт телевиз болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

Арга хэмжээ зохион байгуулагдах үед “Ногоон” түвшинд байсан Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Ховд, Өмнөговь, Сүхбаатар аймгуудад Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолын дагуу гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллаж, иргэдийг аюулгүй талбайд цуглуулж, нүүлгэн шилжүүлэх дадлага сургуулийг нийт 42234 иргэдийг хамруулан 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр амжилттай зохион байгуулсан.

Мөн тус өдөрлөгийн хүрээнд ШУА-ийн Одон орон, геофизикийн хүрээлэн, “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагуудтай хамтран “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт шинжлэх ухаан, танин мэдэхүйн цахим сургалтыг улсын хэмжээнд 2021 оны 03 дугаар сарын 24- 25-ны өдрүүдэд зохион байгуулав. Тус сургалтад аймаг, нийслэл, дүүргийн Боловсролын газар, хэлтэс, аюулгүй байдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын 824,000 алба хаагчид, иргэд идэвхтэй оролцсон.

6. Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөрлөгийг зохион байгуулахдаа НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2021 онд дэвшүүлсэн “Зөвхөн хамтдаа... Бид эх дэлхийгээ аварч чадна” уриа болон “Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030” баримт бичгийн “Хөгжиж буй орнуудад 2030 он хүртэл Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагаагаа зохион байгуулахад зохистой, тогтвортой дэмжлэг үзүүлэх замаар олон улсын хамтын ажиллагааг бодитойгоор нэмэгдүүлэх” зорилттой уялдуулан улсын хэмжээнд зохион байгуулж, сурталчилж ажилласан.

7. Олон улсын иргэний хамгаалалтын өдөрлөгийг “Иргэний хамгаалалтын үйл ажиллагаа нь хүчтэй байснаар үндэсний эдийн засгийг авч үлдэнэ” уриан дор зохион байгуулсан бөгөөд болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох цахим хичээл, сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагын 11380 алба хаагчдыг хамруулж, 30 гаруй төрлийн мэдээ, мэдээлэл, 16 төрлийн шторкыг бэлтгэн төв, олон нутгийн телевиз, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлсэн. Тус өдөрлөгийн талаар мэдээллийг цахим сүлжээнд байрлуулахад 200,000 мянга орчим хүний хандалт авсан байна.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН БАТАЛСАН УДИРДАМЖИЙН ХҮРЭЭНД

1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах цахим сургалтад **1,324,260** (гандалт судалгаагаар) хүн хамрагдсан

5. 2021 онд усанд ослодсон иргэдийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад **8,1** хувиар буурсан байна.

2. Өвөлжилт, хаваржилт хүндрэх болон эздын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд **1,492,424** иргэнд багц мессежээр сэрэмжлүүлэг хүргэсэн

6. Олон улсын иргэний хамгаалалтын өдөр “Иргэний хамгаалалтын үйл ажиллагаа нь хүчтэй байснаар үндэсний эдийн засгийг авч үлдэнэ” уриан дор цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан **50** удаа цахим сургалт зохион байгуулахад **1948** хүн хамрагдсан, сайтад байршуулсан мэдээллийг **1.5** сая хүн үзсэн.

3. Шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд **842,649** иргэнд ухулга сурталчилгаа хийж, үерийн аюултай бусад байрласан нийт **38** айл өрхийг нүүлгэн шилжүүлсэн

7. Эрчим хүчний үнийн чөлөөлөлттэй холбоотой хэт ачаалал үүсэх эрсдэлийг бууруулах чиглэлээр Эрчим хүчний яам, УБЦТС, УБДС, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ус сүвгийн удирдах газартай хамтран ажилласан

4. Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийг “Зөвхөн хамтдаа... Бид эх дэлхийгээ аварч чадна” уриан дор өдөрлөг, нэгдсэн арга хэмжээг нийт **43** удаа зохион байгуулж, нийт **28,150** иргэн, **870** оюутан, сурагчдыг хамруулж, **5-10** төрлийн **16,880** ширхэг сурталчилгааны гарын авлага, боршур, **5** төрлийн сэрэмжлүүлэг бүхий хөргөгчний наалт **600** ширхэгийг тараасан байна.

Зураг 28. Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн дагуу зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийн үеэр хийсэн гүйцэтгэсэн ажлын хураангуй


2.1.2. 2021 онд төв, орон нутгийн хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажил

2021 онд коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан аюултүзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ухулга сурталчилгааг улсын хэмжээнд эхний хагас жилд цахимаар, сүүлийн хагас жилд халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан зохион байгуулж ажилласан.



Зураг 29. 2020–2021 онуудад аюултүзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний харьцуулалт

Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагаас гамшгаас хамгаалах ангиллын танхимын сургалт болон дадлага сургуулийг нийт 5209 удаа зохион байгуулж, 1458840 хүнийг хамруулсан байна.



Зураг 30. Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт

2.1.3. Дадлага, сургалт, бэлэн байдлын үзлэг

“Хангай-21” гамшгийн хор уршгийг арилгах хамтарсан дадлага сургууль

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/185 дугаар тушаалын дагуу “Хангай-21” гамшгийн хор уршгийг арилгах хамтарсан дадлага сургуулийг Онцгой байдлын ерөнхий газар, АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Иргэн цэргийн харилцааны дэмжлэгийн багтай хамтран 2021 оны 9 дүгээр сарын 14-24-ний өдрүүдэд Архангай аймагт зохион байгуулсан.

Энэхүү дадлага сургуульд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Тагнуулын ерөнхий газар, Үндэсний аврах бригад, Давтан сургалт сэргээн заслын төв-113 дугаар анги, нийслэлийн Онцгой байдлын газрын Аврах анги, өмнөд болон хойд бүсийн аймгуудын Онцгой байдлын газар, хэвлэл мэдээллийн байгууллагуудын нийт 130 алба хаагчид оролцлоо.





Зураг 31. “Хангай-21” гамшгийн хор уршгийг арилгах хамтарсан дадлага, сургуулийн үйл явцаас

Хамтарсан дадлага, сургуульд оролцогчид олон улсын сургагч багш нараар өндөр өнцөг болон олсны аврах ажиллагаа, давчуун орон зай, нурангинаас аврах ажиллагаа, хээрийн эмнэлэг дэлгэх зэрэг хичээл заалгаж, гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээний мэдлэгээ дээшлүүлсэн үр дүнтэй дадлага сургууль болсон юм.

Гамшгаас хамгаалах команд штабын сургууль

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/216 дугаар тушаалын дагуу Баянхонгор, Өвөрхангай аймгуудад “Бүх шатны нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах орон нутгийн албад, мэргэжлийн анги, хуулийн этгээд, төрийн бус байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал, тэдгээрийн харилцан ажиллагаа” сэдвээр гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг 2021 оны 10 дугаар сарын 07-12-ны өдрүүдэд зохион байгууллаа.




Зураг 32. Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн үйл явц

Дээрх сургуульд Баянхонгор, Өвөрхангай аймгуудын Онцгой комисс, сумдын гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, Онцгой байдлын газар, гамшгаас хамгаалах орон нутгийн 24 алба, 39 мэргэжлийн ангийн томилгоот нийт 960 удирдах албан тушаалтан, албад, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг цахимаар болон танхимаар хамруулсан байна.

“Бэлэн бай” сургалт

Онцгой байдлын ерөнхий газар, Насан туршийн боловсролын үндэсний төвтэй хамтран ажиллах санаамж бичгийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/245 дугаар тушаалаар 11 аймаг (Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Завхан, Орхон, Увс, Ховд, Сүхбаатар, Хэнтий), 9 дүүргийн Насан туршийн боловсролын төвийн нийт 193 багш нарт гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг, чадвар олгох “Бэлэн бай” модуль сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 09-10-ны өдрүүдэд цахимаар зохион байгууллаа.




Зураг 33. Насан туршийн боловсролын төвийн сургагч багш нарт зохион байгуулсан “Бэлэн бай” модуль сургалтын үйл явцаас

Сургалтанд хамрагдсан сургагч багш нарын хүчтэй цасан болон шороон шуурга, зуд, газар хөдлөлт, гал түймэр, гал түймэр, анхны тусламж, гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын асуудлын талаарх онолын мэдлэг, ойлголтыг дээшлүүллээ.

2.1.4. Онцгой байдлын албаны үйл ажиллагаа, алба хаагчдын ажил мэргэжлийн онцлогийг олон нийтэд сурталчлах

2021 онд объектын болон ой, хээрийн гал түймэр, газар хөдлөлт, коронавируст халдвар, үер, хүчтэй цасан болон шороон шуурга зэрэг цаг үеийн нөхцөл байдал, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг болон хандив тусламжийн талаарх мэдээ мэдээллүүдийг давхардсан тоогоор 3860 удаа олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сайтуудаар дамжуулан иргэдэд хүргэж ажиллав.



Зураг 34. Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан дүн /2020-2021 он/

2021 онд аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан зохион байгуулсан ажил өмнөх онтой харьцуулахад сурталчилгааны бүхий л төрлүүдээр өссөн үзүүлэлттэй байна.

Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн 3D, бага насны хүүхдийн сургалтын, газар хөдлөлтийн, гал унтраах сургалт дадлагын, утаат орчноос аврах ажиллагааны, анхны тусламжийн, аюулгүй өрхийн зэрэг нийт 7 танхимд түшиглэн иргэдэд аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх анхан шатны мэдлэг, дадлага олгох сургалтыг зохион байгуулж ажиллалаа.




Зураг 35. Гамшгаас хамгаалах сургалт, аргазүйн төвд зохион байгуулсан сургалтууд

Мөн тус төвөөс газар хөдлөлт, гал унтраах, утаажилтын, өндрөөс аврах, анхны тусламжийн хэсгүүдээр тоноглогдсон автомашиныг ашиглан Дархан, Сэлэнгэ, Орхон, Булган, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Төв аймгийн нийт 11064 иргэн, Хүүхдийн найрамдал зусланд амрагч 340 хүүхэд, Орчлон дунд сургуулийн 693 сурагч, Оюуны ундраа группын 320 ажилчид, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн 95 багш ажилтан, 75 эмчлүүлэгч хүүхдүүдэд явуулын сургалтыг зохион байгуулсан байна.



Зураг 36. Тусгай хэрэгслээр тоноглогдсон автомашинаар явуулын сургалт зохион байгуулсан

Давтан сургалт, сэргээн заслын төв-113 дугаар ангиас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй хүртээмжтэй хүргэх, дуудлага, захиалга хүлээн авах үйл ажиллагааны чанарыг сайжруулах зорилгоор “CALL PRO” автомат дуудлагын систем болон үйлчлүүлэгчдийн мэдээллийг бүрэн цахимжуулж, өвчтөний түүх, сувилгааны түүх бичилт, эмчийн үзлэгийн тэмдэглэл хийх зэрэгт ашигладаг AX-IS-SYSTEM бүртгэл программуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн юм.




Зураг 37. ДССЗТ-ийн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн цахим системүүд

Тус 113 дугаар анги нь Монгол Улсын Шадар сайдын ивээл дор Стандарт, хэмжилзүйн газраас жил бүр зохион байгуулдаг Үндэсний чанарын чуулганаар Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо ISO 45001:2018 стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, Монгол Улсын Үндэсний чанарын шагналын шалгаруулалтад нэр дэвшиж, олон улсын ба үндэсний шаардлагыг хангаж ажилласан тул **“ҮНДЭСНИЙ ЧАНАРЫН ШАГНАЛ-ШИЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ”** төрөлд шалгарсан байна.



Зураг 38. Давтан сургалт, сэргээн заслын төв “Үндэсний чанарын шагнал-шилдэг үйлчилгээ” шагнал гардан авлаа

Нийслэлийн онцгой байдлын газрын даргын 2021 оны А/66 дугаар тушаалаар алба хаагчдынхаа ажлыг стандартчилах зорилгоор албан тушаалын тодорхойлолттой уялдуулан чиглэл тус бүрээр зураглал гаргаж “Нэгдсэн менежментийн тогтолцооны гарын авлага-II” -ыг боловсруулан гаргасан.



Зураг 39. Алба хаагчдын ажил мэргэжлийн онцлогийг стандартчилах зорилгоор гаргасан гарын авлага

Гамшиг ослын үед ажил үүрэг гүйцэтгэх алба хаагчдын бие бялдрын чадавхыг дээшлүүлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилготой цахим сургалтыг туухай өргөлт, усанд сэлэлт, бие бялдрын ерөнхий болон тусгай чанарыг хөгжүүлэх дасгал, цэргийн биеийн тамирын чиглэлээр бэлтгэн, www.avragch.nema.gov.mn сайтад байрлуулжээ.

ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ

2021 онд цаг үеийн асуудлаар нийт 14 удаагийн хэвлэлийн бага хурлыг зохион байгуулан “Онцгой байдлын ерөнхий газар” пейж хуудсаар шууд дамжуулж, 70 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээг ашиглан олон нийтэд хүргэсэн





Зураг 40. Цаг үеийн асуудлаар хэвлэлийн бага хурал хийж ажиллалаа

байна.

ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРТАЛЧИЛГААНЫ АЯН

Болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэдийн оролцоо, хувь нэмрийг нэмэгдүүлэх, үүрэг, хариуцлага, мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Үүнд:

- Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Байгаль орчны газар, Экологийн цагдаагийн алба, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх “Алдвал галдана” болон ахуйн гал түймрээс урьдчилан сэргийлэх “Мартаж болохгүй” нөлөөллийн аянуудыг өрнүүлэн зурагт хуудас, шторк;
- Коронавируст халдвараас сэргийлэх, сар шинийн баярыг өргөн хүрээнд тэмдэглэлгүй, өрх гэртээ тэмдэглэхтэй холбогдуулан “Ойлгоё, хайрлая”, “Цахимаар золгоё” цахим аяны хүрээнд “Цар тахлыг хамтын хүчээр даван туулцгаая” уриалга бүхий 7 төрлийн видео шторк;
- Засгийн газар, УОК-оос өрнүүлсэн “Та бид хамтдаа хичээе. Тархалтыг хумья” аяны хүрээнд 5 төрлийн видео шторк;
- “Ковидгүй зуны төлөө вакцинаа хийлгэе” уриалга бүхий 2 төрлийн видео шторкуудыг тус тус бэлтгэж, МҮОНТ, Өлзий, UBS, TV8, TV9, ТВ5, С1, Ийгль, UBS телевизүүд, neta.gov.mn сайт, “Онцгой байдлын ерөнхий газар”, “УОК-ын шуурхай штаб”, “Админуудын нэгдэл” зэрэг пейж хуудсуудаар дамжуулан давхардсан тоогоор 9,7 сая иргэнд хүргэсэн байна.



Зураг 41. “Алдвал галдана”, “Мартаж болохгүй” аяны зурагт хуудсууд



Зураг 42. “Цар тахлыг хамтын хүчээр туулцгаая”, “Ойлгоё, хайрлая” уриалга бүхий видео шторкуудын загварууд

Мөн Коронавируст халдварын үед ажиллах журмыг иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэх 120 төрлийн зурагт хуудас, тусгаарлан ажиглах байр болон гэрээр тусгаарлагдаж байгаа иргэдэд зориулан 4 төрлийн гарын авлага, “Ковид-19-ийн халдварын гинжин хэлхээг таслахад хэвшүүлэх 6 дадал” зөвлөмжүүдийг тус тус хийж, www.nema.gov.mn цахим хуудас, “Онцгой байдлын ерөнхий газар”, “Улсын онцгой комиссын Шуурхай штаб” пэйж хуудсуудаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэсэн.

ЦАХИМ СУРТАЛЧИЛГАА

Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, төрийн бодлого, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэдээллийн ил тод байдлыг хангах, гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор “Онцгой байдлын ерөнхий газар” фэйсбүүк хуудас, www.nema.gov.mn, www.ontsgoisur.gov.mn цахим хуудсуудад байрлуулахад 2021 онд 1553597 хүн хандаж мэдээ, мэдээлэл авсан. Тухайлбал,

- Улирлын онцлогт тохируулан тухай бүр шар усны үер, мөс цөмрөх аюул, ой, хээрийн болон объектын гал түймэр, газар хөдлөлт, хүүхдийн аюулгүй байдал, ахуйн осол, коронавируст халдвар, хүчтэй цасан шуурга, зам даваа хаагдах зэрэг аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг шторкуудыг дээрх

цахим хуудсуудад давхардсан тоогоор 980 гаруй удаа байршуулан ажиллажээ.



Зураг 43. neta.gov.mn цахим хуудасны мэдээ, мэдээлэл, хандалтын тоо

- 2021 онд Засгийн газрын болон УОК-ын хуралдааны шийдвэрийн хэрэгжилт, болон УОК-ын Нэгдсэн шуурхай штабаас хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай холбоотой нийт 5417 мэдээллийг бэлтгэн 12 сонин, 36 телевиз, 42 сайт нийт 90 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан давхардсан тоогоор нийт 20.4 сая хүнд хүрсэн байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний хүрээнд Монгол Улсын Онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабаас хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар нэгдсэн мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор “УОК-ын Шуурхай штаб” пэйж хуудсыг ажиллуулж, цаг үеийн мэдээллийг тухай бүрт байршуулан ажиллуулснаар 114 мянган




Зураг 44. УОК-ийн шуурхай штабын пэйж хуудас

дагагчтай болж, сард сая орчим хүн хандаж мэдээ, мэдээлэл авч байна. Тус пэйж хуудсанд коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай холбоотой мэдээ мэдээлэл-1652, зурган зөвлөмж мэдээлэл-1312, видео зөвлөмж-675нийтлэж, иргэдээс ирүүлсэн асуулт, хүсэлтэд холбогдох хариултуудыг өгч, гомдол, саналыг

шийдвэрлэн ажилласан.

“ОНЦГОЙ БАЙДЛЫН ЦАГ” НЭВТРҮҮЛЭГ

МҮОНТ-тэй хамтран ажиллах гэрээ байгуулж, иргэдэд болзошгүй аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг, боловсролыг олгох, Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын ажил, мэргэжлийн онцлогийг олон нийтэд сурталчлан таниулахад чиглэгдсэн “Онцгой байдлын цаг” 15 минутын нэвтрүүлгийг “Аврагч” студидээ бэлтгэн, 14 хоног тутамд давталттайгаар МҮОНТ-ийн 1 дүгээр сувгаар бямба гарагийн 18:20 цагаас, 2 дугаар сувгаар даваа гарагийн 21:20 цагаас, мягмар гарагт “Өлзий ТВ”-ээр 18:40 цагаас тус тус тогтмол нэвтрүүлж байгаа бөгөөд 2021 онд нийт 24 дугаар буюу 30 цагийн нэвтрүүлгийг бэлтгэн үзэгчдэд хүргэсэн байна.



Зураг 45. МҮОНТ-ийн 1, 2 дугаар суваг, “Өлзий ТВ”-ээр “Онцгой байдлын цаг” нэвтрүүлгийг бэлтгэн үзэгчдэд хүргэж байна.

“ОНЦГОЙ МЭДЭЭ” СОНИН

Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа болон төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги байгууллагын ажил, үйлсийг сурталчлах, тэргүүний шилдэг алба хаагчдыг алдаршуулах, байгууллага, хамт олны шинэ санаачлага, тэргүүн туршлагыг алба хаагчидтай хуваалцах, бусдад түгээх зорилготой “Онцгой мэдээ” сонины 130-153 дахь дугаар буюу нийт 24 дугаарыг 2021 онд эрхлэн



Зураг 46. “Онцгой мэдээ” сонины мэдээллийн төрөл

гаргалаа.

2021 оны 9 дүгээр сараас “Онцгой мэдээ” сонины хэмжээг томсгон шинэчилж, А2 хэмжээтэй 8 нүүрээр хэвлэх болсон бөгөөд сонинд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтны ярилцлага-58, орон нутгийн мэдээ-284, албаны үйл ажиллагаатай холбоотой мэдээ, нийтлэл, сурвалжлага-132 бэлтгэн хэвлэгдсэн байна.

"ОНЦГОЙ" СЭТГҮҮЛ

“Онцгой” сургалт, танин мэдэхүйн чөлөөт сэтгүүлийн гурван дугаарыг эрхлэн гаргаж, 300 ширхэгийг хэвлүүлэн төв, орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги байгууллагуудад хүргүүлэв.



Зураг 47. 2021 онд хэвлэгдэн нийтийн хүртээл болсон “Онцгой” сэтгүүлүүд

2.1.5. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагаа

Тус зөвлөл нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 282 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө” болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газраас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангахаар 39 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласан. 2021 онд хийж хэрэгжүүлсэн ажлуудыг дурьдвал:

- **Хууль, эрх зүйн хэрэгжилтийг хангах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлууд:**

Барилга хот байгуулалтын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газруудтай хамтран “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”, “Газар хөдлөлтийн тухай мэдээ, мэдээллийг дамжуулах, мэдээлэх журам”, “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”-уудыг батлуулсан.

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар барилга байгууламжийг

паспортжуулах зөвлөлийг байгуулж, дүрмийг батлуулж, паспортжуулах барилга байгууламжийн жагсаалт гарган ажиллаж байна. Судалгаагаар, 21 аймагт боловсрол, соёл, спортын салбарт 330 гаруй барилга байгууламж газар хөдлөлтийг тэсвэрлэх чадвар-“хангалтгүй”, 259 барилга байгууламж “цаашид ашиглалтын шаардлага хангахгүй” гэсэн дүгнэлт гарсан.

1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих чиглэлээр:

Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 141 дүгээр захирамжаар газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх болон цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах үүрэгтэй ажлын хэсэг байгуулсан.

Барилга, хот байгуулалтын сайдын багцад “Барилга, хот байгуулалтын салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт”-ийн төсөл, арга хэмжээний хүрээнд Баянгол дүүрэгт 242.1 сая төгрөг, Хан-Уул дүүрэгт 91.6 сая төгрөг, Баянзүрх дүүрэгт 128.4 сая төгрөгийг барилга байгууламжийг дахин барилгажуулахаар баталсан байна.

Мөн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны дахин төлөвлөлтөөр 170 барилгын төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй урилгыг 2015-2021 онд удаа дараа зарласнаар 97 барилгад төсөл хэрэгжүүлэгч шалгарч, журмын дагуу буулган шинээр барих үйл ажиллагаа явагдсаны үр дүнд одоогийн байдлаар 892 айлын 48 орон сууцыг буулгаж, 2478 айлын 15 орон сууцны зураг төсөл, ашиглалтад оруулах болон их, дээд, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт гамшгаас хамгаалах чиглэлээр зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл худалдан авах зэрэг зардалд 48.6 тэрбум төгрөг зарцуулахаар батлагдсан нь газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангахад ач холбогдол бүхий арга хэмжээ боллоо.

Улаанбаатар хот болон 16 аймгийн хэмжээнд 2021 онд 154 нийтийн орон сууцны барилга, байгууламжид “ногоон” гэрчилгээг олгоод байгаа боловч Говь-Алтай, Говьсүмбэр, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий аймгуудад ажлын хэсэг томилогдоогүйн улмаас гэрчилгээ олгоогүй байна.

2022 оны улсын төсөвт Улаанбаатар хотын сав газарт газар хөдлөлтийн чичирхийллийг бүртгэх 10 акселерометрийн станцын тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулах, “Сэлэнгэ”, “Богд”, “Мандалговь” газар хөдлөлтийн идэвхжилтийг хянах станцад шаардлагатай багаж, төхөөрөмжийг худалдаж авах, Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн идэвхжилтийг хянах 5 автомат станцыг байгуулах зардлуудыг тусгаж, батлуулах саналыг Боловсрол, шинжлэх ухааны сайдад хүргүүлснээр сайдын төсвийн багцад 15.0 тэрбум төгрөг батлууллаа.

3. Гамшгийн үеийн удирдлага, аврах, эрэн хайх үйл ажиллагааг дэмжих чиглэлээр:

Гамшгийн аюулыг зарлан мэдээллэх дуут дохиоллын цамхагийг нэмж байгуулах ажлын хүрээнд Баянгол дүүрэгт 1, Чингэлтэй дүүрэгт 1, Сонгинохайрхан дүүрэгт 2, Хан-Уул дүүрэгт 3 нийт 7 цамхагийг нэмж байгууллаа.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/304 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтад заасны дагуу “Газар хөдлөлтийн гамшиг болсон үед иргэдийг нүүлгэн шилжүүлж байршуулах хотхон байгуулах зураглал”-ыг гаргаж батлуулсан.

4. Боловсон хүчин бэлтгэх, мэргэшүүлэх, үйл ажиллагааг сурталчлах, олон нийтийг сургаж дадлагажуулах чиглэлээр:

Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах бэлэн байдлыг хангах талаар олон нийтэд сургалт, сурталчилгаа явуулах, олон нийтийн гамшгаас хамгаалах мэдлэгийг дээшлүүлэхэд сургагч багшаар ажиллах Улаан загалмайн нийгэмлэгийн сайн дурын идэвхтэн 15 хүний бүрэлдэхүүнтэй “Сайн дурын бүлэг”-ийг байгуулж, 270 сайн дурын идэвхтнийг сургаж дадлагажуулав.

Гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг, чадварыг олон нийтэд олгох “Бэлэн бай” сургалтын сургагч багш бэлтгэх цахим сургалтыг “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллагатай хамтран 2021 оны 3 дугаар сарын 3-5-ны өдрүүдэд зохион байгуулж төв, орон нутгийн хэмжээнд 300 гаруй сургагч багш бэлтгэлээ.

Нийслэлийн Засаг даргын баталсан “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургалт”-ийн хөтөлбөрийн хүрээнд 232 цэцэрлэгийн 2600 багш, ажилтан болзошгүй аюул осол, байгалийн гамшгийн үед бага насны хүүхдийг авран хамгаалах, гамшгаас учрах хохирлыг бууруулах арга зүйд суралцсан.

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын дэмжлэгтэйгээр “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг нь уртасгах туршилтын төсөл”-ийн хүрээнд аймаг, нийслэлийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газрын 100 гаруй албан хаагчдыг хамруулсан цахим сургалтыг 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдөр зохион байгууллаа.

Эрүүл мэндийн яам, Монголын Улаанзагалмай нийгэмлэг, Олон улсын улаан загалмай, улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбоотой хамтран зохион байгуулсан “Халдварт өвчний үед эрүүл мэндийн ажилтнуудад дэмжлэг үзүүлж, тандалт судалгаа хийх чиглэлээр сайн дурын идэвхтэн бэлтгэх” сургалтаар 400 сайн дурын идэвхтэн бэлтгэв.

Монголын Улаанзагалмай нийгэмлэгийн 60 сургагч багш болон сайн дурын ажилтнуудад “Нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх” сургалтыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран зохион байгуулав.

Эрүүл мэндийн яам, нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран 2021 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр газар хөдлөлтийн гамшгийн үед нэрвэгдэгсдийг эрэмблэн ангилах, эмнэлгийн анхны яаралтай тусламж үзүүлэх чиглэлээр зохион байгуулсан дадлага сургалтад Нийслэлийн харъяа эрүүл мэндийн байгууллагуудын нийт 142 эмч, эмнэлэгийн ажилчид хамрагдлаа.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтын цэг, тандалт хариу арга хэмжээний багийн гишүүдэд эмнэлгийн яаралтай тусламж, амилуулах суурь тусламж үзүүлэх сургалтыг 270 гаруй эмч, эмнэлгийн ажилтныг хамруулан зохион байгуулсан.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн эмч нарт яаралтай тусламж, амилуулах суурь тусламж үзүүлэх сургалтыг цахимаар зохион байгуулж 900 гаруй эмч, багш нарыг хамруулсан.

БҮЛЭГ 2.2. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.

2.2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор “Гамшгийн

эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги"-ийг батлуулж, 3 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

"Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги"-ийн II үе шатыг улсын хэмжээнд 2021-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж, төлөвлөгөөг Шадар сайдын 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 51 дүгээр тушаалаар баталсан.

Стратегийн I үе шатанд санхүү, хөрөнгө оруулалт шийдэгдээгүйн улмаас хэрэгжилт бүрэн хангагдаагүй 30, 70 хувьтай дүгнэгдсэн 4 арга хэмжээг "Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги"-ийг хэрэгжүүлэх II үе шат (2021-2025)-ны арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.


Энэхүү II үе шатны арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд үндэсний хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа эрчимжиж, гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн чадавх дээшилж, гамшгийн эрсдэлийн мэдээллийн сан бий болж, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах олон нийтийн мэдлэг ойлголт нэмэгдэх юм.

"Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги"-ийг хэрэгжүүлэх II үе шатны арга хэмжээний төлөвлөгөө нь 4 тэргүүлэх чиглэл, 9 зорилтын хүрээнд нийт 56 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд гамшгийн эрсдэлийг бууруулахад эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон жендэрийн талаарх асуудлыг тусгасан. Эдгээр арга хэмжээг нийт 35 яам, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн захиргааны байгууллага хариуцах болон хамтран хэрэгжүүлэхээр тусгасан.

2.2.2. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал


1. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ

2021 онд Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг нийслэлд 52, орон нутагт 95 нийт 147 аж ахуйн нэгж, байгууллагад тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдүүд хийж гүйцэтгэсэн.



Зураг 48. Нийслэлд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо, үнэлгээний чиглэл

Дээрх зургаас харахад гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг Баянгол, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай үйлдвэр, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагууд хийлгэсэн бол Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай ерөнхий боловсролын сургуулиуд түлхүү хийлгэсэн байна. Харин Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт дэд бүтцийн 1 байгууламжид гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийгдэж, эмнэлэг, шатахуун түгээх станц, газрын тосны бүтээгдэхүүний агуулахуудад хийгдээгүй байна.



Зураг 49. Аймаг, орон нутагт гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо, үнэлгээний чиглэл

Дээрх зургаас харахад гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг Хэнтий, Өмнөговь, Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт байршилтай үйлдвэр, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагууд түлхүү хийлгэсэн бол Төв, Орхон, Говьсүмбэр, Архангай аймгийн нутаг дэвсгэрт байршилтай шатахуун түгээх станцууд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг идэвхтэй хийлгэсэн байна. Мөн Өмнөговь, Сэлэнгэ, Сүхбаатар, Хэнтий, Дундговь аймгуудын нутаг дэвсгэрт байршилтай уул уурхайн компаниуд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн байна.

Төв, Увс, Ховд аймгуудын хувьд дэд бүтэцдээ гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн байна.

Харин аль ч аймаг засаг захиргаа нутаг дэвсгэрийн түвшинд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгээгүй байна.

2. Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ

Шадар сайдын 2021 оны 19 дүгээр тушаалаар ХХААХҮЯ, ЭМЯ, ЗТХЯ, ХНХЯ, ОБЕГ, УЦУОШГ-ын хамтарсан ажлын хэсэг зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээг 2021 оны 3 дугаар сард 9 аймагт газар дээр нь, 12 аймагт цахимаар хийсэн. Тус үнэлгээг зуншлагын байдал, бэлчээрийн даац, малын тарга хүч, өвөлжилтийн бэлтгэл, малын хорогдол, өвс тэжээлийн үлдэгдэл нөөц, малын сэг зэм устгах, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хашаа хороо болон усан хангамж, хаваржилтын төлөв зэрэг үзүүлэлт дээр үндэслэн үнэлэхэд Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь аймгууд **“Их”**, Архангай, Завхан, Төв, Хөвсгөл аймгууд **“Дунд”**, Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Увс, Ховд, Хэнтий аймгууд **“Дунд”**, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгууд **“Бага”** эрсдэлтэй дүгнэгдсэн.



Зураг 50. Зудын эрсдэлийн түвшинг өнгөөр илэрхийлэв.
(Шар өнгөөр “дунд”, ногоон өнгөөр “бага”, улаан өнгөөр “их”)

УОК-ын даргын 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 60 дугаар тушаалаар хөдөө аж ахуйн салбарын болон хот суурин газрын өвөлжилтийн бэлтгэл, орон нутаг дахь коронавирусын халдварын нөхцөл байдал, хадлан бэлтгэл, отор нүүдлийн зохицуулалт, малын гоц халдварт өвчний голомт, отор нүүдэл ихтэй аймгуудын нөхцөл байдалтай танилцах, хүйтний улирлын цаг агаарын төлөв зэрэг хүчин зүйлүүдийг судлаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилго бүхий шуурхай бүлэг зудын эрсдэлийн үнэлгээг 8 аймагт газар дээр нь, 13 аймагт цахимаар зохион байгуулж хийж гүйцэтгэсэн. Тус үнэлгээгээр Өмнөговь, Завхан, Дундговь, Говь-Алтай, Архангай, Төв, Дорноговь, Ховд, Сүхбаатар, Сэлэнгэ, Говьсүмбэр аймгууд “Дунд”, Өвөрхангай, Баян-Өлгий, Увс, Хэнтий, Булган, Дорнод, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Хөвсгөл аймгууд “Бага” эрсдэлтэй буюу хэвийн дүгнэгдсэн байна.



Зураг 51. Зудын эрсдэлийн түвшинг өнгөөр илэрхийлэв.
(Шар өнгөөр “дунд”, ногоон өнгөөр “бага”, улаан өнгөөр “их”)

3. Баянхонгор аймгийн газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ:

Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 1/03 дугаар тушаалаар Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд “Газар хөдлөлтийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ”-г хийхэд мэргэжил арга зүй, заавар, зөвлөмж, мэдээ мэдээллээр хангах, ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсгийг байгууллаа. Тус эрсдэлийн ерөнхий үнэлгээг 2016-2019 онд Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-тай хамтран хэрэгжүүлсэн “Монгол Улсын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулсан “Газар хөдлөлтийн хохирлыг хялбаршуулсан аргаар тооцох эксел хүснэгт”-ийг ашиглан үнэлсэн.

4. Ковид-19 халдварын салбар дундын эрсдэлийн үнэлгээ:

Монгол Улсын Шадар сайдын 2017 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу салбар бүрийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг коронавируст халдварын эрсдэлийн 19-26 дахь шатны үнэлгээг 2021 оны 1 дүгээр сарын 03-ны өдрөөс 11 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд 8 удаа зохион байгуулж холбогдох зөвлөмж гаргаж ажиллалаа. Коронавируст халдвар /КОВИД-19/-н тархалтын эсрэг хариу арга хэмжээ авахад тус эрсдэлийн үнэлгээний үр дүнг шууд ашигласан.

Хүснэгт. Коронавируст халдварын эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал

№	Хугацаа	Эрсдэлийн түвшин	Оролцогч талууд
1	2021.01.03	Маш өндөр	<ul style="list-style-type: none"> • УОК Шуурхай штаб • Эрүүл мэндийн яам
2	2021.01.21	Өндөр	<ul style="list-style-type: none"> • Хүнс хөдөө, аж, ахуй, хөнгөн үйлдвэрийн яам • Зам, тээврийн яам
3	2021.01.31	Өндөр	<ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн хяналтын ерөнхий газар • Цагдаагийн ерөнхий газар • Тагнуулын ерөнхий газар
4	2021.03.22	Маш өндөр	<ul style="list-style-type: none"> • Онцгой байдлын ерөнхий газар • Гаалийн ерөнхий газар
5	2021.04.16	Маш өндөр	<ul style="list-style-type: none"> • Хил хамгаалах ерөнхий газар
6	2021.06.07	Маш өндөр	<ul style="list-style-type: none"> • Халдварт өвчин судлалын үндэсний төв • Зоонозын өвчин судлалын үндэсний төв
7	2021.07.04	Өндөр	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв • Нийслэлийн онцгой байдлын газар
8	2021.11.29	Өндөр	<ul style="list-style-type: none"> • Улаанбаатар төмөр замын удирдах газар • Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

5. Коронавируст халдвар /ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм, аюулгүй байдал алдагдах эрсдэлийн үнэлгээ:

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 13 дугаар тушаалаар батлагдсан “Хилийн боомтуудад коронавируст халдвар /КОВИД-19/-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, аюулгүй байдал алдагдах эрсдэлийн үнэлгээ”-г Буянт-Ухаа, Чингис хаан, Алтанбулаг, Сүхбаатар, Замын-Үүд төмөр зам, авто замын нийт 6 боомтыг хамруулан 2021 оны 2 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд

хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт. Хилийн боомтуудад коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм, аюулгүй байдал алдагдах эрсдэлийн үнэлгээг хийсэн үр дүн

Боомтын нэр	Заагдсан эрсдэл	16	12	7-9	4-6	2-3	0-1
1. Буянт-Ухаа боомт	25	4	5	5	9	2	0
2. Чингис хаан боомт	76	0	1	3	11	6	55
3. Чингис хаан боомт /2021.07.01/	104	0	7	4	25	15	53
4. Алтанбулаг боомт	25	7	5	4	9	0	0
5. Сүхбаатар боомт	15	2	3	3	7	0	0
6. Замын-Үүд авто замын боомт	43	5	4	11	16	6	1
7. Замын-Үүд төмөр замын боомт	27	2	2	6	9	7	1
Боомтын эрсдэлийн нэгдсэн үнэлгээ	315	20	27	36	86	36	110

Дээрх хилийн 6 боомтын эрсдэлийн үнэлгээний нэгдсэн дүнгээр 315 эрсдэлтэй хүчин зүйл тодорхойлогдсон бөгөөд үүнээс хойшлуулшгүй яаралтай арга хэмжээ авах 20, нэн түрүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөх 27, дунд, богино хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөх 36, урт хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөх 86, эрсдэл бий болох магадлал бага 36, эрсдэл олж тогтоогоогүй 110 арга хэмжээ байгааг тогтоосон.

6. Сургуулийн орчинд коронавируст халдвар (ковид-19)-ын эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ:

Улсын хэмжээнд 2021-2022 оны хичээлийн шинэ жил эхлэхтэй холбогдуулан СӨБ, ЕБС, Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын орчинд коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын тархах эрсдэлийн үнэлгээг 2021 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр, их, дээд сургууль, коллежийн түвшинд коронавируст халдвар/ КОВИД-19/-ын тархах эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээг 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр БШУЯ, ЭМЯ, ХНХЯ, МХЕГ, ОБЕГ, ХӨСҮТ, НЭМҮТ, УОК-ын ШШ хамтран зохион байгуулсан.

Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, Их, дээд сургууль, коллежийн түвшинд коронавируст халдвар (КОВИД-19)-ын эрсдэлийн түвшин **"ӨНДӨР"** үнэлэгдсэн.

2.2.3. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланг хүлээн авч дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус Гамшгийн эрсдэлийн үнэлгээний Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмын нэмэлт өөрчлөлтийг Шадар сайдын 2021 оны 100 дугаар тушаалаар батлуулсан.

Тус зөвлөлийн хуралдааныг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр зохион

байгуулсан. Дээрх хуралдааны шийдвэрээр 2021 оны байдлаар нийт 30 хуулийн этгээдэд 6 чиглэлээр гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгосон.

2.2.4. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагаа

Япон Улсад 2005 онд зохион байгуулсан Гамшгийн эрсдэлийг бууруулах хоёрдугаар бага хурлаар Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийг байгуулах санааг дэвшүүлж, улмаар 2015 онд Сендай хотод болсон гуравдугаар бага хурлын үеэр энэхүү зөвлөлийг баталгаажуулах ажил олон улсын түвшинд хийгдэж эхэлсэн.

Засгийн газрын 2020 оны 189 дүгээр тогтоолоор “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажиллах журам” шинэчлэн батлагдсантай холбогдуулан 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл бүрэлдэхүүн, ажиллах журамд өөрчлөлт оруулж өнөөдрийн байдлаар үндэсний 1, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд 31, нийт 32 зөвлөл үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн даргаар 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр “Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай” зөвлөмжийг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Тус зөвлөмжид нийт 15 бүлэг, 29 арга хэмжээ тусгагдсанаас 2021 онд хэрэгжилтийн биелэлт 89.6 хувьтай дүгнэгдсэн. Хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай 4 арга хэмжээг 2021 оны зөвлөмжинд тусгасан. Түүнчлэн Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн 2021 оны ээлжит хуралдааныг 07 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж, хуралдааныг тус зөвлөлийн орлогч дарга, Монгол Улсын Шадар сайд удирдан явуулсан.

Хуралдаанаас гарсан нийт 24 арга хэмжээ бүхий зөвлөмж, чиглэлийг Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн гишүүд, орон нутгийн зөвлөлд хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2021 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар хэрэгжилтийн явц 80 хувьтай байна.

Зөвлөлийн 2021 оны ээлжит хуралдаан нь дэлхийн хэмжээнд тархаад буй коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын сөрөг үр дагаврыг даван туулах, КОВИД-19 халдвартай зэрэгцэн амьдрах амьдралын шинэ хэв маягт шилжихэд бэлтгэх, халдварын эрсдэл, түүнээс учрах сөрөг нөлөөллийг бууруулах асуудлыг урт хугацааны бодлогоор шийдвэрлэх, болзошгүй хүчтэй газар хөдлөлт, гал түймэр, цаг агаарын гаралтай гамшиг, аюулт үзэгдлийн эрсдэлийг бууруулах, барилга, байгууламж, зам, дэд бүтцийн гамшгийг тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн механизмыг хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулан ажилласан.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 12 дугаар тогтоолоор “Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөл”-ийг шинэчлэн байгуулж, зөвлөлийн ажиллах журам, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөл дараах ажлуудыг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:

1. Нийслэлийн хэмжээнд төрийн өмчийн ерөнхий боловсролын 150 сургуулийн 137-д нь, сургуулийн өмнөх боловсролын 272 байгууллагын 200-д нь гамшгийн



Зураг 52. Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй зарим СӨБ, ЕБС-иудад гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр зөвлөмж өгч байгаа нь


эрсдэлийн ерөнхий үнэлгээг зохион байгуулж, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулахад арга зүйн зөвлөмж өгч ажилласан.

Нийслэлийн хэмжээнд 23 аж ахуйн нэгж, байгууллагад гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх арга зүйгээр хангаж, Нийслэлийн Мал эмнэлгийн газар / Мал эмнэлгийн алба/, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Цацраг, химийн алба/-д “Байгууллагын чадавхын үнэлгээний аргачлал”-аар гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх арга зүйгээр ханган ажилласан.



Зураг 53. “Байгууллагын чадавхын үнэлгээний аргачлал”-аар гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх арга зүйгээр хангасан

Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний нийт 56 тайланд Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт шинжилгээ хийж, ОБЕГ-ын Мэргэжлийн зөвлөлд хүргүүлсэн байна. Монгол Улсын Шадар сайдын 2017 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалын дагуу нийслэлийн коронавируст халдвар /Ковид-19/-ын тархах эрсдэлийн үнэлгээг зохион байгуулж, эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн нийт 113 авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмжийг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан байна.



Зураг 54. Нийслэлийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнд хяналт шинжилгээ хийж ажиллалаа

ГУРАВДУГААР ХЭСЭГ:

**ГАМШГИЙН ШУУРХАЙ
УДИРДАГА, ЗОХИЦУУЛАЛТ**



БҮЛЭГ 3.1. ГАМШГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

3.1.1. Монгол оронд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын тойм


Монгол Улсын хэмжээнд 2021 онд нийт 4075 удаагийн аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 319 хүн амь насаа алдаж, 149 хүн гэмтэж бэртэн, 163716 толгой мал, амьтан хорогдож, 25.9 тэрбум төгрөгийн шууд хохирол учирсан байна.

Эдгээр аюулт үзэгдэл ослын хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд Онцгой байдал, Зэвсэгт хүчин, Хил хамгаалах, Цагдаагийн байгууллагын алба хаагчид, байгаль хамгаалагчид, иргэд оролцсон нийт 48644 хүн, 11056 автомашин ажиллаж, 3802 хүний амь насыг аварч байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн 114.5 тэрбум төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалж, гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах ажилд 1.4 тэрбум төгрөг зарцуулсан байна.

	Газар хөдлөлт	Үер	Аянга	Өвөржилт хүндэрсэн	Мөндөр	Объектын гал түймэр	Хүчтэй салхи	Ой, хээрийн түймэр	Биологийн гаралтай аюулт үзэгдэл	Хүний үйл ажиллагаатай холбоотой
2020	59	64	9	1	2	3036	51	142	96	546
2021	295	72	1		1	2671	91	65	208	671


Зураг 55. 2020, 2021 онуудад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын тоо

Нийт тохиолдсон аюулт үзэгдэл, ослын 67.1 хувь нь гал түймэр, 5.1 хувь нь биологийн гаралтай аюулт үзэгдэл, 16.5 хувь нь хүний үйл, ажиллагаатай холбоотой осол, 4.0 хувь нь ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл, 7.2 хувь нь геологийн гаралтай аюулт үзэгдэл байна.




Зураг 56. 2021 онд нийт тохиолдсон аюулт үзэгдэл, ослын эзлэх хувь /гамшгийн төрлөөр/

Аюулт, үзэгдэл ослын улмаас учирсан нийт хохирлын 63 хувь буюу 16.4 тэрбум төгрөг нь гал түймрийн улмаас, 35 хувь буюу 9.1 тэрбум төгрөг нь ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлийн улмаас, 0.7 хувь буюу 231 сая төгрөг нь биологийн гаралтай аюулт, үзэгдэл ослын улмаас, 1.3 хувь буюу 348 сая төгрөг нь хүний үйл ажиллагаатай холбоотой ослын улмаас учирсан байна.



Зураг 57. 2021 онд нийт тохиолдсон аюул үзэгдэл, ослын эзлэх хувь /гамшгийн төрлөөр/

Аюулт, үзэгдэл ослын улмаас нас барсан иргэдийн ослын шалтгаанаар нь авч үзвэл 42.3 хувь буюу 135 хүн усны ослын улмаас, 19.1 хувь буюу 61 хүн объектын гал түймрийн улмаас, 3.4 хувь буюу 11 хүн хүчтэй салхи шуурганы улмаас, 1.8 хувь буюу 6 хүн үерийн улмаас, 6.5 хувь буюу 21 хүн төөрч сураггүй болсоны улмаас, 1.6 хувь буюу 5 хүн уул, уурхайн ослын улмаас, 0.6 хувь буюу 2 хүн аянганы улмаас, 24.4 хувь буюу 78 хүн бусад төрлийн ослын улмаас амь насаа алдсан байна.



Зураг 58. 2021 онд аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүний эзлэх хувь /гамшгийн төрлөөр/

УС, ЦАГ АГААРЫН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ:

Аадар бороо, үер:

Нийслэл хот, 20 аймгийн нийт 58 сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан 72 удаагийн аадар бороо орж, үер болсны улмаас 6 хүн амь насаа алдаж, 5789 толгой мал хорогдож, 229 гэр, байшин урсан эвдэрч, 5.1 тэрбум төгрөгийн хохирол учирчээ. Үерийн голомтод 1071 албан хаагчид, 193 автомашин техниктэй ажиллаж, 703 хүний амь насыг авран хамгаалсан байна.

Аянга:

Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт аянга буусны улмаас, 2 хүн амь насаа алдаж, 1.2 сая төгрөгийн хохирол учирсан байна.

Хүчтэй салхи шуурга:

Нийслэл хот, 20 аймгийн нийт 67 сум, дүүргийн нутаг дэвсгэрийг хамарсан 91 удаагийн хүчтэй салхи, шуурганы улмаас 11 хүн амь насаа алдаж, 1230 гэр, байшин нурж эвдрэн 3.9 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Шуурганд төөрсөн хүмүүсийг эрэн хайх ажиллагаанд Онцгой байдлын байгууллага, орон нутгийн иргэд нийт 1794 хүн, 488 автомашин техниктэйгээр үүрэг гүйцэтгэж ажиллажээ.

ГЕОЛОГИЙН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ:**Газар хөдлөлт:**


Монгол Улсын 18 аймгийн 41 сумын нутагт 3.5 магнитудаас дээш хүчтэй газар хөдлөлтийн 264 тохиолдол бүртгэгджээ. Газар хөдлөлтийн улмаас 11 гэр, байшин эвдрэн 10.4 сая төгрөгийн хохирол учирсан байна. Онцгой байдлын байгууллага, орон нутгийн иргэд нийт 42 хүн, 10 автомашин техник ашиглан үүрэг гүйцэтгэж ажилласан.

БИОЛОГИЙН ГАРАЛТАЙ ӨВЧИН, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ:

Шүлхий, бог малын мялзан, үхрийн арьс товруутах зэрэг мал, амьтны гоц халдварт өвчин нийт 186 удаа гарч, 4413 толгой мал хорогдсон. Хорогдсон мал, амьтдыг булж устган, ариутгал халдваргүйжүүлэлт хийж урьдчилан сэргийлэх зорилгоор 2 сая толгой малыг вакцинжуулахад нийт 1361 хүн, 423 техник ашиглан ажилласан байна.


ХҮНИЙ БУРУУТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ОСОЛ:

Усны осол, бичил уурхай нуранги зэрэг хүний үйл ажиллагаатай холбоотой осол нийт 671 удаа гарч, 239 хүн амь насаа алдаж, 92 хүн гэмтэж бэртжээ. Ослын голомтод Онцгой байдлын байгууллага, орон нутгаас нийт 6089 хүн, 1494 автомашин техниктэйгээр ажиллаж 706 хүний амь насыг авран хамгаалж ажиллаж байна.


Аюулт үзэгдэл, ослын хохирлын харьцуулалт

Зураг 59. Аюулт үзэгдэл, ослын улмаас учирсан хохирлын хэмжээг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

2021 онд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аварсан хүний тоо, эд хөрөнгийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байна.



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1563 буюу буюу 58.8 хувь өссөн байна.




Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 44.7 сая төгрөгөөр өссөн байна.



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1152 буюу 87.3 хувиар буурсан байна.



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 64 буюу 25 хувиар өссөн байна.



Зураг 60. 2021 онд аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүн /аймаг, нийслэлээр/

Дээрх зургаас харахад аюулт үзэгдэл, ослын улмаас нас барсан хүний тоогоор Улаанбаатар, Баян-Өлгий аймаг, Хөвсгөл аймаг орж байгаа боловч тухайн орон нутгийн 100000 хүн тутамд ногдох нас баралтын графикаар Дундговь аймаг, Баян-Өлгий аймаг, Говь-Алтай аймгууд өндөр байгаа нь харагдаж байна.

**Хүснэгт. 2020–2021 онд аюулт үзэгдэл, ослын улмаас
нас барсан хүний тооны харьцуулалт**


№	Аюулт үзэгдэл, ослын төрөл	Нас барсан нийт хүн		Харьцуулалт /тоогоор/	
		2020 он	2021 он	Өсөлт	Бууралт
1	Хүчтэй салхи, шуурга	3	11	8	
2	Үер	9	6		3
3	Аянга	1	2	1	
4	Тарваган тахал	3	0		3
5	Усны осол	121	135	14	
6	Объектын гал түймэр	77	61		16
7	Уурхайн осол	2	5	3	
8	Тэсэрч, дэлбэрэх осол	2	0		2
9	Бусад осол	30	78	48	
	НИЙТ	255	319	64	

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол орны болон хил орчмын бүс нутгийн газар хөдлөлт:

2021 онд Монгол орны нутаг дэвсгэр болон хил орчмын бүс нутагт 159396 удаагийн газар хөдлөлт болсон байна. Эдгээр газар хөдлөлтүүдээс Монгол орны нутаг дэвсгэрт 137849 удаагийн газар хөдлөлт болсон бөгөөд хүчний хувьд ялган авч үзвэл:

- Магнитуд нь $M < 1.0$ газар хөдлөлт 85370 удаа,
- Магнитуд нь $1.0 \leq M \leq 1.9$ газар хөдлөлт 40388 удаа,
- Магнитуд нь $2.0 \leq M \leq 2.9$ газар хөдлөлт 5586 удаа,
- Магнитуд нь $3.0 \leq M \leq 3.9$ газар хөдлөлт 445 удаа,
- Магнитуд нь $4.0 \leq M \leq 4.9$ газар хөдлөлт 102 удаа,
- Магнитуд нь $5.0 \leq M \leq 5.9$ газар хөдлөлт 11 удаа,
- Магнитуд нь $6.0 \leq M \leq 6.9$ газар хөдлөлт 2 удаа болсон байна.




Зураг 61. Монгол орны нутаг дэвсгэр болон хилийн ойролцоох бүс нутагт болсон газар хөдлөлтийн төвийн тархалтын зураг

Монгол орны нутаг дэвсгэрт магнитуд нь 3.5 болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт 264 удаа болсон байна бөгөөд хүнд мэдрэгдэм газар хөдлөлт сүүлийн 10 жилийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад 6 дахин их болжээ /Хавсралт 1/.

Улаанбаатар хотын газар хөдлөлт:

2021 онд Улаанбаатар хот орчмын бүс нутагт нийт 1043 газар хөдлөлт болсон байна. Эдгээр газар хөдлөлтүүдийг хүчний хувьд ялган авч үзвэл:

- Магнитуд нь $M < 1.0$ газар хөдлөлт 700 удаа,
- Магнитуд нь $1.0 \leq M \leq 1.9$ газар хөдлөлт 306 удаа,
- Магнитуд нь $2.0 \leq M \leq 2.9$ газар хөдлөлт 33 удаа,
- Магнитуд нь $3.0 \leq M \leq 3.9$ газар хөдлөлт 3 удаа,
- Магнитуд нь $5.0 \leq M \leq 5.9$ газар хөдлөлт 1 удаа болсон байна.



Зураг 62. Улаанбаатар хот орчмын газар хөдлөлтийн төвийн тархалтын зураг.

3.1.2. МОНГОЛ УЛСАД 2021 ОНД ГАРСАН ЗАРИМ ТОМООХОН АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, МАЛЫН ӨВЧИН, ОСЛЫН ТОЙМ:

Шүлхий өвчин:

Монгол Улсад 2021 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн байдлаар нийт 20 аймгийн 170 суманд шүлхий өвчний 301 голомтод 147337 толгой мал, амьтан өвчилсөн байсан бол 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 7 аймгийн 10 суманд шүлхий өвчний 8112 тохиолдол нэмэгдэж гарсан байна.

№	Аймгийн нэрс	Нийт өвчилсөн малын тоо	Тухайн өдөр нэмэгдсэн (2021.12.30)			Дархлаажуулалт		
			Малын тоо	Сумын тоо	Голомтын тоо	Төлөвлөгөөт	Гүйцэтгэл	%
1	Архангай	4,684	366			235,091	73,742	20.8
2	Баянхонгор	5,117				1,326,600	1,260,329	95.0
3	Баян-Өлгий	136				628,244	606,749	96.6
4	Булган	8,375	23			188,157	117,374	100
5	Говь-Алтай	7,467				409,050	409,810	100
6	Дархан-Уул	919				315,900	303,845	96.0
7	Дорнод	2023				479,736	356,494	71.6
8	Дорноговь	1,718				2,316,083	2,349,898	101.0
9	Дундговь	15,218				2,202,015	1,812,091	82.3
10	Завхан	20,346	4634			38,265	38,185	96.1
11	Сүхбаатар	51				1,921,885	1,937,122	101.0
12	Сэлэнгэ	7,268				635,711	595,479	92.3
13	Орхон	19				195,597	195,149	100
14	Өмнөговь	652				288,200	287,842	99.9
15	Өвөрхангай	8,387	232			1,741,841	1,731,945	99.4
16	Төв	7,448				2,120,794	1,914,555	90.5
17	Ховд	7,357	35			1,864,379	1,647,310	87.7
18	Хэнтий	1,309				255,491	254,292	99.5
19	Увс	32,129	364			15,300	14,585	97.6
20	Хөвсгөл	16,714	2458			26,678	11,174	11.2
	НИЙТ	147,337	8112			12,897,714	11,475,915	90.0

Зураг 63 .Монгол Улсад бүртгэгдсэн шүлхий өвчний гаралт, дархлаажуулалт

2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 17 аймгийн 100 сум, 159 голомтонд хорио цээрийн арга хэмжээ хэрэгжүүлж, 5 аймгийн 6 сум, 18 голомтыг хязгаарлалтын дэглэмд шилжүүлсэн. Мөн 13 аймгийн 64 сум, 124 голомтын хорио цээрийн дэглэмийг цуцалжээ.

Аймгийн нэрс	Өвчлөл бүртгэгдсэн сумдын мэдээлэл				Голомтын мэдээлэл			
	Сумын тоо	Хорио цээртэй	Хязгаарлалтын дэглэмтэй	Хорио цээр цуцлагдсан	Голомтын тоо	Хорио цээртэй	Хязгаарлалтын дэглэмтэй	Хорио цээр цуцлагдсан
Архангай	9	7		2	18	14		4
Баянхонгор	10	2		8	23	2		21
Баян-Өлгий	2			2	5			5
Булган	11	11			21	21		
Говь-Алтай	9	5	2	2	23	9	5	9
Дархан-Уул	3	3			4	4		
Дорнод	11	8	2	1	30	23	6	1
Дорноговь	4			4	4			4
Дундговь	12	2		10	34	2	1	31
Завхан	15	15			20	19	1	
Орхон	1	1			2	2		
Өмнөговь	1	1			2	2		
Өвөрхангай	11	2		9	15	2		13
Сүхбаатар	2			2	3			3
Сэлэнгэ	9	8		1	9	8		1
Төв	16	7		9	33	19		14
Ховд	13	5	2	6	23	10	5	8
Хэнтий	9	1		8	11	1		10
Увс	8	8			5	5		
Хөвсгөл	14	14			16	16		
Нийт	170	100	6	64	301	159	18	124
Хувь		51.0	1.0	48.0		52.0	1.0	47.0

Зураг 64. Улсын хэмжээнд шүлхий өвчний голомтод авч хэрэгжүүлсэн хорио цээрийн арга хэмжээний судалгаа

Үхрийн арьс товруутах өвчин:

Дорнод аймгийн Чулуунхороот суманд 2021 оны 8 дугаар сарын 21-ний өдөр үхрийн арьс товруутах өвчний анхны сэжигтэй тохиолдол илэрч, УМЭАЦТЛ-ийн 2021 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн шинжилгээний дүнд үндэслэн Монгол Улсад уг халдварт өвчин анх удаа оношлогдсон болохыг тогтоосон.

2021 оны 12 дугаар сарын 29-ний байдлаар улсын хэмжээнд 3 аймгийн 20 сум, 60 голомтод үхрийн арьс товруутах өвчний 20 тохиолдол бүртгэгдсэн. Өвчлөл бүртгэгдсэн 20 суманд 185412 толгой малыг урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамруулсан бөгөөд хамралт 95.5 хувь байна.

Хүснэгт 3. Монгол Улсад бүртгэгдсэн үхрийн арьс товруутах өвчний гаралт, дархлаажуулалтад хамрагдсан байдал

Аймгийн нэрс	Өвчлөл бүртгэгдсэн сумын тоо	Өвчилсөн нийт малын тоо толгой	Дархлаажуулалт		
			Төлөвлөгөөт	Гүйцэтгэл	Хувь
Дорнод	13	2861	148835	141596	92.0
Хэнтий	2	31	22766	22766	100.0
Сүхбаатар	5	124	21104	19663	93.2
Улсын дүн					
3 аймаг	20	3016	194150	185412	95.5

Хонины цэцэг өвчин:

Монгол Улсад 2021 онд 3 аймгийн 4 сумын 4 голомтын 6 өрхөд хонины цэцэг өвчний 277 тохиолдол бүртгэгдсэн. 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдрөөс хойш улсын хэмжээнд хонины цэцэг өвчний тохиолдол бүртгэгдээгүй тул өвчлөл бүртгэгдсэн аймгуудад хорио цээрийн дэглэм бүрэн цуцалсан байна.

Хүснэгт 4. Монгол Улсад бүртгэгдсэн хонины цэцэг өвчний гаралт, дархлаажуулалтад хамрагдсан байдал

Аймгийн нэрс	Өвчлөл бүртгэгдсэн сумын тоо	Өвчилсөн нийт малын тоо толгой	Дархлаажуулалт		
			Төлөвлөгөөт	Гүйцэтгэл	Хувь
Хэнтий	2	55	127412	135595	99.85
Өвөрхангай	1	190	7900	7.937	100.0
Дорнод	1	32	18414	17.963	97.6
Улсын дүн					
3 аймаг	4	277	153726	161.495	100.0

Бог малын мялзан өвчин:

2021 онд улсын хэмжээнд нийт 5 аймгийн 17 сум, Улаанбаатар хотын 1 дүүрэгт бог малын мялзан өвчний 36 голомт бүртгэгдэж, нийт 96 өрхийн 5038 толгой бог мал өвчилсөн. 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс хойш улсын хэмжээнд бог малын мялзан өвчний тохиолдол бүртгэгдээгүй. Өвчлөл бүртгэгдсэн сумдад 1817508 толгой малыг урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамруулсан байна.

Хүснэгт 5. Монгол Улсад бүртгэгдсэн бог малын мялзан өвчний гаралт, дархлаажуулалтад хамрагдсан байдал

Аймгийн нэрс	Өвчлөл бүртгэгдсэн сум, дүүргийн тоо	Өвчилсөн нийт малын тоо толгой	Хорио цээрийн дэглэм	Дархлаажуулалт		
				Төлөвлөгөөт	Гүйцэтгэл	Хувь
Дорнод	3	774	Бүрэн цуцлагдсан	636,994	506,499	79.5
Дорноговь	1	1022	Хязгаарлалтын дэглэмд шилжсэн	73,669	73,000	99.1
Өмнөговь	8	2957	Бүрэн цуцлагдсан	1,027,000	1,024,361	99.7
Ховд	3	20	Бүрэн цуцлагдсан	-	-	-
Хэнтий	2	241	Бүрэн цуцлагдсан	207,000	199,925	96.6
Улаанбаатар	1	24	Бүрэн цуцлагдсан	13,757	13,723	99.8
Улсын дүн						
Улаанбаатар хот, 5 аймаг,	17	5038		1,958,420	1,817,508	92.8

Усны осол

2021 оны байдлаар усны ослын 5 удаагийн томоохон дуудлагаар давхардсан тоогоор 60 алба хаагч 33 хоног үүрэг гүйцэтгэж, 3-7 метрийн гүнд нийт 18 алба хаагч 67 удаа шумбалт хийж 3 буцалтгүй нэрвэгдэгчийг олж хуулийн байгууллагад хүлээлгэн ажилласан. Үүнд:

- 2021 оны 07 дугаар сарын 15-ны өдөр Сэлэнгэ аймгийн Зүүн бүрэн суманд гарсан усны ослын дуудлаганд 11 алба хаагч;
- 2021 оны 08 сарын 02-ны өдөр Төв аймгийн Лүн сум, Туул голын усны ослын дуудлагад 7 алба хаагч;
- 2021 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Булган аймгийн Дашинчилэн суманд гарсан усны ослын дуудлаганд 8 алба хаагч;
- 2021 оны 8 сарын 10-ны өдөр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын “Хойд элдэв”-ийн нүүрсний уурхайн осолд 5 алба хаагч;
- 2021 оны 10-р сарын 14-ний өдөр Төв аймгийн Заамар сумын хайлааст 3 дугаар баг, Туул голд осолдсон 2 иргэнийг эрэн хайх ажиллагаанд 8 алба хаагч тус тус албан үүргээ гүйцэтгэж ажиллажээ.



Зураг 65. Эрэн хайх аврах салбарын алба хаагчид усны ослын дуудлагаар ажиллаж байна.

Сэлэнгэ аймагт осолдсон вагоны осол

2021 оны 06-р сарын 24-ний өдөр Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын 1-р баг Бэлэндалай өртөөний 76 дугаар км-ийн 10 дугаар зуутад ОХУ-аас Орхон аймгийн чиглэлд явж байсан 4002 элчит тэрэгтэй 3202 галт тэрэгний 23 дугаар цувааны дизель түлш ачсан 7, техникийн масло ачсан 1, элс ачсан 1 нийт 9 вагон унаж, таг болон илүүдлийн хавхлагаар дизель түлш, масло асгарсан осол болсон.

Тус ослын дуудлагад Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 61 дүгээр анги, Улаанбаатар төмөр замын харъяа Салхитын Аврах ангийн алба хаагчид, Сайхан, Орхонтуул сумдын өртөөний ажилчид 10 Дархан Төмөр замын цагдаагийн газар, Сайхан сум дахь цагдаагийн хэлтсийн алба хаагчид, Улаанбаатар төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын Онцгой байдлын албаны тээврийн албаны алба хаагчид, Эрдэнэт үйлдвэр, "НИК" ХХК-ийн ажилчид буюу нийт 169 албан хаагч 34 автомашин механизм, 6 галт тэрэгтэйгээр ажилласан.

Эдгээр алба хаагчид унасан вагонуудыг вагоны замаас холдуулж, түлш асгарч байсан вагонуудад гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлж элсээр саармагжуулалт хийн түлшийг "НИК" ХХК-ийн 11 автоцистернд, унаагүй 1 вагоны түлшийг хөөрөг /помп/ ашиглан вагонцистрнд шилжүүлэн ачилт хийж, торхтой масло ачсан вагоны тэвшийг нээж кранаар том оврын 3 автомашин /шланз/-д ачих ажиллагаа явуулсан. Улмаар гал тэрэгний замыг цэвэрлэж, хайрга асгаж, зам засварын ажлыг бүрэн дуусгаж, галт тэрэг явах боломжтой болгосон.



Зураг 66. Вагоны ослын голомт

Цасан болон шороон шуурга

2021 оны 3 дугаар сарын 13-наас 15-ны өдрүүдэд Монгол орны нийт нутгаар хүчтэй салхи, цасан болон шороон шуурга шуурч Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн нутгаар салхины хурд 16-24 м/с, зарим үед 34 м/с, Завхан аймгийн нутгаарсалхины хурд 28 м/с хүрч, хүчтэй цасан шуурга 7 цаг орчим үргэлжилж, мөн Дундговь аймгийн Сайнцагаан, Эрдэнэдалай сумын салхины хурд 40 м/с хүртэл ширүүсч шороон шуурга шуурч гамшигт үзэгдлийн хэмжээнд хүрсэн байна.

Цаг агаарын гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээг бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухайлбал, МҮОНТ, NTV, TV5, TV6, EAGLE TV, MNC зэрэг 10 орчим телевиз, 30 орчим мэдээллийн сайт, Монголын үндэсний радио, үүрэн холбооны оператор, дуут дохиоллын цамхаг зэргийг ашиглаж иргэдэд хүргэж, мөн бүх яамдуудад албан тоотоор цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл хүргүүлж ажилласан.

Цаг агаарын гамшигт үзэгдлийн улмаас 12 аймгийн 51 суманд нийт 706 хүн төөрч, сураггүй болсон ба үүнээс 696 хүнийг эсэн мэнд олж, амь насыг нь аварсан бол Архангай аймгийн Өгийнуур суманд 1 хүүхэд, Дундговь аймагт 9 хүн (үүнээс тус аймгийн Гурвансайхан суманд хүүхэд 1), нийт 10 хүн амь насаа алдсан байна. Мөн ОХУ-аас Баруун бүсийн аймгуудад цахилгаан эрчим хүч нийлүүлдэг С-458 дугаар агаарын шугамын 216 дугаар тулгуур багана унаж, Баян-Өлгий, Увс, Ховд аймагт цахилгаан тасарсан. Нийт 16 аймгийн 154 суманд 531 гэр, 2244 хашаа саравч нурж, 283 байшингийн дээвэр хууларч, 140,347 толгой мал хорогдож, орон нутагт цахилгаан дамжуулах агаарын шугамын 220В-ийн 128 тулгуур багана унаж, 10 аймгийн 34 суманд цахилгаан эрчим хүч түр тасалджээ.

Цасан болон шороон шуурганы үеэр эрэн хайх, аврах, хор уршгийг арилгахад Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, нутгийн захиргааны байгууллагын 1404 алба хаагчид 362 техник хэрэгсэлтэйгээр ажиллалаа.






Зураг 67. Хүчтэй салхи шуурганы дараах нөхцөл байдал

3.1.3. 2021 оны уур амьсгалын жилийн тойм

Агаарын температур

Монгол орноор дунджилсан 2021 оны жилийн дундаж агаарын температур 1.7°C буюу 1940 оноос хойш ажиглагдсан 2 дахь дулаан жил болж өнгөрлөө.

Бүс нутгаар авч үзвэл говийн бүсийн өмнөд, Алтайн өвөр говиор +6.0...+10.1°C, тал хээрийн бүс нутгуудаар болон Их нууруудын хотгор орчмоор +2.0...+5.8°C, Хангайн нуруу, Дархадын хотгор орчмын нутгаар -4.0...-8.0°C, бусад нутгаар -1.0...+2.0°C орчим байлаа.




Зураг 68. 2021 оны жилийн дундаж агаарын температурын орон зайн тархалт

Хур тунадас

Монгол орноор дунджилсан 2021 оны жилийн нийлбэр хур тунадас 261.7 мм буюу 1940 оноос хойш тохиолдсон 5 дахь хур тунадас ихтэй жил байлаа.


Жилийн нийлбэр хур тунадасны орон зайн тархалтыг авч үзэхэд Хөвсгөлийн уулс, Хэнтийн нуруу, Хангайн нуруу, Идэр Тэс голын ай сав орчим, Өвөрхангайн Хархорин, Увсын Малчин, Баруунтуруун, Ховдын Чандмань сумдын нутгаар 404-

585.7 мм, тал хээрийн болон говийн бүс нутгаар 100.2-198.8 мм, Их нууруудын хотгор, Алтайн өвөр говь, Эхийн гол орчмоор 27.8-94.2 мм орсон байна. Жилийн нийлбэр тунадасны хамгийн их утга нь Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумд 585.7 мм тунадас оржээ.



Зураг 69. 2021 оны улирлын нийлбэр хур тунадасны орон зайн тархалт

Цасны зузаан




Зураг 70. 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар цасны зузаан (см)

Экстремаль утгууд

2021 онд агаарын температурын үнэмлэхүй их утга Дорноговь аймгийн Хөвсгөл суманд 39.3°C, хөрсний температурын үнэмлэхүй их утга Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд 70°C хүрч ажиглагдсан бол үнэмлэхүй бага утга Завхан аймгийн


Отгон суманд агаарын температур -49.6°C , хөрсний температур -52°C хүрч хүйтэрсэн байна. Хоногт орсон хамгийн их хур тунадас Хэнтий аймгийн Оргил суманд 8 дугаар сарын 13-ны өдөр 81.9 мм орсон. Салхины хурд хамгийн их нь Баян-Өлгий аймгийн Өлгий суманд 46 м/с хүрчээ.



Зураг 71. 2021 онд ажиглагдсан экстремаль утга

Зуншлагын байдал


Бэлчээрийн ургамал хаврын сүүлч гэхэд нийт нутгийн 30 гаруй хувьд хэвийн, 70 орчим хувьд тааруу байсан бол 7 дугаар дундаас зуншлагын байдал сайжирч 8 дугаар сарын сүүл гэхэд нийт нутгийн 80 орчим хувьд сайн, 10 гаруй хувьд дунд, 10 хүрэхгүй хувьд буюу Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар аймгийн цөөн хэдэн сумын нутгаар тааруу байсан.



Зураг 72. Бэлчээрийн ургамлын ургалтын байдал

Зудын эрсдэл

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд 2021 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар зудын эрсдэлийг тооцоолж зураглал гаргасан.



Зураг 73. Зудын эрсдэлийн зураг

Дээрх зудын эрсдэлийн зургаас харахад нийт нутгийн 2.6 хувьд **“их”** эрсдэлтэй, 10.8 хувьд **“дунд”** зэрэг эрсдэлтэй, бусад нутгаар эрсдэл **“бага”**-тай гарсан.

Аймгийн дүнгээр авч үзвэл Баян-Өлгий, Увс, Ховд, Төв аймгуудын зарим хэсгээр зудын эрсдэл **“их”** гарсан байна.

БҮЛЭГ 3.2. ГАЛ ТҮЙМРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

3.2.1. Объектын гал түймэр

Улсын хэмжээнд 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар объектын гал түймрийн 2501 тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс 1550 дуудлагад гал түймэр унтраах, аврах анги ажиллаж унтраасан, 771 зөрчил, 180 мэдээлэл бүртгэгдсэн байна. Объектын гал түймрийн дуудлагын тоог өнгөрсөн онтой харьцуулбал 17.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Гал түймрийн аюулаас 1263 хүний амь насыг, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын 103.1 тэрбум төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгааллаа. Аварсан хүний тоог өнгөрсөн онтой харьцуулбал 33.1 хувиар, аварсан хөрөнгө 9.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Гал түймрийн улмаас 12.5 тэрбум төгрөгийн хохирол учирчээ. Учирсан хохирлыг өнгөрсөн онтой харьцуулбал 10.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Зураг 74. Объектын гал түймрийн нөхцөл байдал


Объектын гал түймэрт 45 том хүн, 15 хүүхэд нийт 60 хүн өртөж нас баржээ. Нас барсан хүний тоог өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 20 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Түүнчлэн 48 том хүн, 2 хүүхэд нийт 50 хүн түлэгдсэн байна. Түлэгдсэн хүний тоог өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 22 хувиар өссөн байна.



Зураг 75. Объектын гал түймрээс учирсан хохиролын өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

3.2.2. Ой, хээрийн гал түймэр


Улсын хэмжээнд 2021 онд Архангай, Булган, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хэнтий зэрэг 9 аймгийн 35 суманд нийт 65 удаагийн ой, хээрийн гал түймэр бүртгэгдсэн. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад ой, хээрийн гал түймрийн дуудлагын тоо 45,7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Мөн Дорнод аймгийн Халхгол, Чойбалсан, Сүхбаатар аймгийн Дарьганга зэрэг сумдын хилээр нийт 4 удаагийн хээрийн түймэр Монгол Улсаас БНХАУ-ын хил давж гарсан байна.



Зураг 76. Ой, хээрийн түймрийн нөхцөл байдал

Өнгөрсөн онд ой, хээрийн гал түймэрт 2092,1 га ой, 201,538 га хээр, нийт 203.630 га талбай өртсөн байна. 2020 онтой харьцуулахад ойн гал түймэрт өртсөн талбай 78.1 хувьтай, хээрийн түймэрт өртсөн талбай 14.5 хувь, нийт гал түймэрт өртсөн

талбай 16.9 хувиар буурсан аерэг үзүүлэлттэй байна.



Зураг 77. Ой, хээрийн түймрийн нөхцөл байдлыг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

2021 онд ой, хээрийн гал түймрийг унтраахад 29,034,656 төгрөг зарцуулж, эд материалын 44,400,000 төгрөг, байгаль экологид 3,100,617,595 төгрөг, нийт 3,174,052,251 төгрөгийн хохирол учирсан байна. Нийт учирсан хохирлыг өнгөрсөн онтой харьцуулбал 1.7 хувиар буурсан байна.



Зураг 78. Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт




Зураг 79. Ой, хээрийн түймрийг унтраах үйл ажиллагаанд оролцсон хүч хэрэгсэл


2021 онд гарсан 65 удаагийн ой, хээрийн га түймрийг унтраахад Онцгой байдлын байгууллагаас 627 алба хаагч, 64 автомашин, Хил хамгаалах байгууллагаас 176 алба хаагч, 26 автомашин, Цагдаагийн байгууллагаас 21 алба хаагч, 6 автомашин, Орон нутгаас 1599 иргэн, 315 автомашин, нийт 2441 хүн, 409 автомашин, 43 мотоциклтойажиллаж ой, хээрийн гал түймрийг унтрааж ажилласан байна.

3.2.3. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын үйл ажиллагаа

Хяналт шалгалтын ажлын хүрээнд Гал түймрийн улсын хяналтын байцаагч нар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 4891 гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага, 4289 мэдэгдэл, 3704 ажлын байрны дүгнэлт, 1879 гал түймэр унтраасан тухай нотломж, 1424 зөрчлийн тэмдэглэл, 229 танилцуулгыг боловсруулж иргэн, хуулийн этгээдэд хүргүүлж, 23 хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож гал түймрийн аюулгүй байдлыг хангуулан ажилласан байна.




Зураг 80. Гал түймрийн хяналтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ



Зураг 81. Гал түймрийн хяналт, шалгалтын чиглээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт


Энэ онд гал түймрийн улсын хяналтын байцаагч нар 795 барилгын зураг төсөл хянаж, 974 барилга ашиглалтад хүлээн авах комисст ажиллаж, 3704 ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргасан байна.



Зураг 82. 2021 онд гарсан гал түймрийн шалтгаан

Гал түймэр гарах болсон шалтгаан нөхцлийг судлаж үзэхэд, 2021 онд гарсан нийт гал түймрийн 37.4 хувь нь ил галаас, 28.5 хувь нь цахилгаан угсралт ашиглалтын буруугаас, 16 хувь нь пийшин зуух, яндангийн цоолтоос, 0.7 хувь

нь гагнуур, паялникаас, 1.3 хувь нь хүүхдийн болгоомжгүй үйл ажиллагаанаас, 6.3 хувь нь машин техникийн гэмтэл, технологи зөрчиснөөс, 0.4 хувь нь тэсэрч дэлбэрсэн ослоос, 0.5 хувь нь автомашины яндангийн оч болон цахилгаанаас, 0.6 хувь нь санаатай үйлдлээс, 0.2 хувь нь архидан согтуурснаас, 4.2 хувь нь шалтгаан тогтоогдоогүй, 2.5 хувь нь бусад шалтгаанаар тус тус гал түймэр гарсан байна.



ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ:

**ХОР УРШГИЙГ АРИЛГАХ,
СЭРГЭЭН БОСГОХ АЖИЛЛАГАА**

БҮЛЭГ 4.1. УЛСЫН НӨӨЦ ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ

Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламж

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр гамшиг, эдийн засгийн хүндрэл бэрхшээл тохиолдсон үед нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор ашиглах стратегийн болон гамшгийн үеийн нөөцийн бараа, материалыг төв, орон нутаг дахь Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн анги, салбар, цэгт бүрдүүлж, бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Улсын нөөцийн бараа, материал

Монгол Улсын хэмжээнд коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал бүртгэгдсэнтэй холбогдуулан гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд улс оронд тохиолдсон байгалийн гамшиг, аюулт үзэгдлийг даван туулах, хор уршгийг арилгахад 9.2 тэрбум төгрөгийн, коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд 1.9 тэрбум төгрөгийн, шатахууны хомсдлоос үүсэх хор уршгийг арилгахад 2.7 тэрбум төгрөгийн, газар тариалангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд 597.2 сая төгрөгийн буюу нийт 17 нэр төрлийн 14.5 тэрбум төгрөгийн бараа, материалыг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 28, 40, 76, 92, 153, 222, 297 дугаар бүхий 7 удаагийн тогтоол, Засгийн газрын 2021 оны 52 дугаар хуралдааны тэмдэглэл, Шадар сайд болон Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан 2021 оны 115/А/276 дугаар тушаалаар улсын нөөцөөс олгож, холбогдох байгууллагуудад ханган нийлүүлэх ажлыг зохион байгууллаа.

Улсын нөөцөөс зарцуулсан бараа, материалыг төрөл тус бүрээр нь авч үзвэл:

- 3.1 тэрбум төгрөгийн 8,240 тонн өвс;
- 3.2 тэрбум төгрөгийн 6,340 тонн тэжээл;
- 0.6 тэрбум төгрөгийн 941 тонн үр тарианы таримлын үр;
- 1.7 тэрбум төгрөгийн хүнсний багц, цэвэр ус;
- 0.9 тэрбум төгрөгийн 182 ширхэг иж бүрэн гэр;
- 2.1 тэрбум төгрөгийн 39 ширхэг автомашин, техник хэрэгсэл;
- 2.9 тэрбум төгрөгийн 1391.18 тонн газрын тосны бүтээгдэхүүн нийт 14.5 тэрбум төгрөгийн бараа, материалыг зарцуулсан байна.



Зураг 83. Гамшиг ослын хор уршгийг арилгахад зарцуулсан зардал

Улсын хэмжээнд 2021 онд тохиолдсон гамшиг ослын хор уршигийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд зориулан улсын нөөцөөс зарцуулсан зардал нь 2020 оныхтой харьцуулбал 20,7 хувиар өссөн байна.

Гамшиг ослын үед хэрэглэх дараах нэр төрлийн бараа материалыг Улсын нөөцөд бүрдүүлэн ажилласан байна. Үүнд:

- 2021 оны 12 дугаар сарын байдлаар 10 нэр төрлийн өргөн хэрэглээний хүнсний бараа, материалын бүрдүүлэлт 84.7 хувь, шатахуун тосолгооны материалын бүрдүүлэлт 52.1 хувь, үйлдвэр техникийн бараа, хүний эм, багаж хэрэгслийн бүрдүүлэлт 70.2 хувьтай байв.

- Стратегийн зориулалттай хүнсний улаанбуудай хадгалах зориулалттаар Дархан-Уул аймаг дахь 36.0 мянган тонн багтаамжтай төмөр бетон элеваторыг Хөдөө аж ахуйг дэмжих сангийн Дархан салбарт байгуулав. Мөн тариалангийн баруун, зүүн бүсэд үр тарианы үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр Увс аймгийн Баруунтуруун сум, Дорнод аймгийн Хэрлэн суманд тус бүр нь 10.0 мянган тонн багтаамжтай элеватор байгуулах зорилгоор 5.0 тэрбум төгрөгийн төсвийг батлуулсан.

- Хөвсгөл аймагт хүнсний ногооны 500 тонн багтаамжтай механикжсан агуулах байгуулах сонгон шалгаруулалтыг хийсэн бөгөөд 2022 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

- “Сайн дурын, авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэхэд донор зохион байгуулагч, сайн дурын идэвхтнүүдийг чадавхжуулах” сургалтыг 21 аймаг болон нийслэлийн 9 дүүргийн Улаан загалмайн нийгэмлэгийн алба хаагчдад танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулсан. Цус сэлбэлт судлалын үндэсний төвд хэвийн болон өвөрмөц иммуноглобулины үйлдвэрлэлийн түүхий эд болох 350 литр цус, 1769 нэгж сийвэнг цуглуулж, 38 хоногийн нөөц бэлтгэн ажиллав.

- 5.6 тэрбум төгрөгөөр эм эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг үзүүлэх худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

Гамшгаас хамгаалах Түлш, эрчим хүчний улсын албаны бэлэн байдлыг хангах, гамшиг аюулт үзэгдэл томоохон осол, саатал гарсан үед ашиглахад шаардлагатай материалын судалгаа болон төсвийг гаргаж тендер зарласан.

Хүмүүнлэгийн тусламж

Коронавируст халдварт /COVID-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбогдуулан Улсын Онцгой комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр 2021 онд 884.7 сая төгрөгийн бараа, материалын тусламж ирүүлснийг хүлээн авч хандивлагч байгууллагын хүсэлт болон Монгол Улсын Шадар сайдын баталсан хуваарийн дагуу тусгаарлан ажиглах байрууд, аймаг, нийслэлийн Онцгой комисс, автозамын шалган нэвтрүүлэх товчоо, Улаанбаатар хотын постууд, УОК-ын Шуурхай штаб болон өндөржүүлсэн бэлэн байдалд үүрэг гүйцэтгэж байгаа төрийн байгууллагын албан хаагчдад олгосон.

Хандив, тусламжийг хүлээн авах, хуваарилах, хяналт тавих үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам” 133 дугаар тогтоол, УОК-ын даргын баталсан тушаал шийдвэр, хуваарийн дагуу тус тус зохицуулан ажилласан бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 250.6 сая төгрөгийн бараа,

материалын үлдэгдэлтэй байна.

УОК-т ирүүлсэн хандив, тусламжийн орлого, зарцуулалтын талаарх мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын www.nema.gov.mn цахим хуудсаар тухай бүр мэдээлж байгаа болно.

Бусад хандив тусламжийн хүрээнд:

2021 онд “Дөрвөлжин интернэйшнл” ХХК-иас тусгай зориулалтын аврах ажиллагааны багажийн иж бүрдэл болох зай хураагуураар ажилладаг тасдагч, тэлэгч, 30-60 тн-ын даацтай өргөгч хийн дэр, ивүүр, хутга, бээлий, нүүр хамгаалах хэрэгсэл,

Бүгд найрамдах Турк Улсын буцалтгүй тусламжаар бүрэн тоноглогдсон эмнэлгийн зориулалттай 70 сертэй автомашин 1 ширхэгийг хүлээн авсан.

Гамшгаас хамгаалах техник, хэрэгслийн чадавхыг бэхжүүлэх хөрөнгө оруулалтын талаар:

2021 онд гамшгаас хамгаалах техник, хэрэгслийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төв орон нутгийн Онцгой байдлын албанд ашиглагдаж байгаа тусгай болон туулах чадвар өндөртэй 81 автомашины шинэчлэлт хийв;
- Аврах ажиллагаанд зориулагдсан хорт утааны хошуувч, цахилгаан үүсгэвэр, олс, хорт бодисноос хамгаалах хувцас 78 ширхэгийг;
- Онцгой байдлын ерөнхий газарт ашиглагдаж байгаа тусгай болон туулах чадвар өндөртэй автомашины дугуй 48 ширхэгийг;
- Аккумулятор 57 ширхэгийг;
- 6700 литр гал унтраах хөөс үүсгэгч бодис, болон галын хоолой 257 ширхэгийг тус тус худалдан авч, төв, орон нутгийн онцгой байдлын анги байгууллагуудад хуваарилсан.


Гадаад улсын засгийн газрын нөхцөлт зээлийн хүрээнд:

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн зээлийн хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлж буй “Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагааны нэгж байгуулах, нисдэг тэрэг нийлүүлэх” төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд: Буянт-Ухаа Олон улсын нисэх онгоцны буудлын хамгаалалтын бүсд ангар, сургалтын байгууламж барих, агаараас эрэн хайх, аврах үйл ажиллагаа явуулах ЕС-145 маркийн 3ш нисдэг тэрэг, 1ш сургалтын Кабри нисдэг тэрэг, сургалтын симулятор нийлүүлэгдсэн.

Бүгд найрамдах Франц Улсаас гал унтраах үндсэн албаны автомашин 35, автомеханик шатны автомашин 3, удирдлагын зориулалттай автомашин 1 ширхэгийг тус тус хүлээн авсан. Мөн Бүгд найрамдах Беларусь Улсаас Хүн тээврийн маз маркийн автомашин 1, пум маркийн удирдлагын автомашин 1 ширхэгийг хүлээн авч холбогдох хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн Онцгой байдлын газар хэлтсүүдэд хуваарилсан болно.

БҮЛЭГ 4.2. УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2021 онд Улсын онцгой комисс нь Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтынасуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдуулан Улсын онцгой комисс дараах бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажилласан.



Зураг 84. Улсын онцгой комиссоос 2020 он, 2021 онд гаргасан тушаал, шийдвэрийг харьцуулан харуулав.

Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос халдварын цар тахлаас хүн амыг урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоолоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, нийт 18 удаа хугацаа сунгасан бол бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 4 удаа шилжүүлж, 3 удаа хугацаа сунгаж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагааг 79 хоног хязгаарлан, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Нэг хаалга-нэг шинжилгээ арга хэмжээ:

2021.02.11-02.22-ны өдрүүдэд нийслэлийн хэмжээнд “Нэг хаалга- нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулж, 9 дүүргийн 442,303 өрхийн 504,949 иргэнийг шинжилгээнд хамруулж, анхдагч 56, ойрын хавьтлын 66 тохиолдлыг

илрүүлсэн бөгөөд уг арга хэмжээг өргөжүүлэн 7,279 эмч, эмнэлгийн ажилтан, 5,849 төрийн албан хаагч, нийт 13,128 албан хаагч, 785 автобус, 993 автомашинтай ажиллаж, халдварын 33 голомт, 126 тохиолдлыг илрүүлсэн.

Вакцинжуулалт:

Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллага нь 2021 онд яаралтай хэрэглэх вакцины жагсаалтад дараах 10 вакциныг бүртгэсэн. Үүнд:

1. Пфайзер /БиоНТех 2020.12.31
2. Астра Зенека AZD1222(SK Bio) 2021.02.15
3. Астра Зенека AZD1222(EU Nodes) 2021.04.16
4. AZD1222 (Japan MHLW/PMDA) 2021.07.09
5. Астра Зенека AZD1222 (Australia TGA) 2021.07.09
6. Астра ЗенекаКовишилд (ChAdOx1_nCoV-19) 2021.02.15
7. Жонсон Жонсон (Ad26.COV2.S) 2021.03.12
8. Модерна (mRNA-1273) 2021.04.30
9. Вероцелл (CorV) Синофарм 2021.05.07
10. Синовак (Vero Cell) 2021.06.01

Монгол Улсын Засгийн газар гадаад харилцааны шугамаар болон олон улсын байгууллага, хандивлагч орнуудын дэмжлэг, оролцоотойгоор 4 төрлийн вакцины нийт 8.397.550 тунг татан авч, хүн амыг вакцинжуулсан байна. Үүнд:

- Нийт хүн амын 11.3 хувийг хандив тусламжаар вакцинжуулахаар:
 - Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас (150.000 тун), Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас (300.000 тун), Америкийн нэгдсэн улсаас-188.370 тун вакцин
 - Хүн амын 20 хувийг КОВАКС хөтөлбөрийн хүрээнд вакцинжуулахаар:
 - АстраЗенека вакцины лицензээр СК-Биосайнс үйлдвэрлэсэн AZD1222 112.800 тун вакцин;
 - Пфайзер/БиоНТех үйлдвэрийн Комирнэти буюу Пфайзер/БиоНТех BNT162-1.214.460 тун вакцин;
 - Монгол Улсын Засгийн Газраас Оросын Холбооны Улсын Гамалей институтын Спутник-В “Гам-КОВИД-Вак” вакцины 40.000 тун, БНХАУ-ын Синофарм BBIBP үйлдвэрийн Вероцелл буюу CorV вакцины-4.000.000 тун;
 - Пфайзер /БиоНТех үйлдвэрийн Комирнэти буюу Пфайзер /БиоНТех BNT162 вакцин-2.500.290 тун;
- “Монгол Эм Импекс Концерн” ХХК нь Оросын Холбооны Улсын Гамалей институтын Спутник-В “Гам-КОВИД-Вак” вакцины 80,000 тунг тус тус худалдан авч вакцинжуулалтыг хийсэн байна.

Санхүүгийн талаар:

Монгол Улсын Засгийн газраас 2021 онд 36 тогтоол батлагдсанаас “Хөрөнгө гаргах тухай” тогтоолын хүрээнд нийт 15.3 тэрбум төгрөг зарцуулжээ.

Засгийн газрын тусгай сангаас:

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Мөнгөн хөрөнгө		Бараа материал	
		Орлого	Зарлага	Орлого	Зарлага
1	Хүмүүнлэгийн тусламж	187,176,769.00	901,877,253.20	4,669,124,898.00	4,377,009,026.00
2	МУ-ын ЗГ-ын тогтоол	15,444,135,992.41	15,274,012,155.41		

№	Засгийн газрын тогтоолын он, дугаар	Зориулалт	Дүн /төгрөгөөр/
1	Засгийн газрын 2021 оны 28 дугаар тогтоол	Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалтын газрын хамгаалалтад шаардагдах зардал	72,000,000
2	Засгийн газрын 2021 оны "Хөрөнгө гаргах тухай" 40 дүгээр тогтоол	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлыг хумих, тархалтыг бууруулах зорилгоор зохион байгуулсан "Нэг хаалга-Нэг шинжилгээ" арга хэмжээний зардал	2,700,000,000
3	Засгийн газрын 2021 оны "Улсын нөөцөөс бараа, материал гаргах, нөхөн бүрдүүлэх тухай" 76 дугаар тогтоол	Байгалын аюулт үзэгдлээс болж орон гэргүй болж хохирсон айл өрхүүдэд тусламж үзүүлэхэд шаардагдах зардалд	430,000,000
4	Засгийн газрын 2021 оны "Хөрөнгө гаргах тухай" 92 дугаар тогтоол	Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд зорилтот бүлгийн 30 мянган өрхөд хүнсний багцын тусламжинд шаардагдах хөрөнгө	1,200,000,000
5	Засгийн газрын 2021 оны "Хөрөнгө гаргах тухай" 153 дугаар тогтоол	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулийн үед коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хувийн хамгаалах хэрэгслийн зардалд шаардагдах хөрөнгө	1,200,000,000
6	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Хөрөнгө гаргах тухай" 222 дугаар тогтоол	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зардал	332,400,000
7	Засгийн газрын 2021 оны "Улсын нөөцөөс бараа, материал гаргаж нөхөн бүрдүүлэх тухай" 297 дугаар тогтоол	Гамшгийн улмаас зарим аймагт учирсан хохирлыг арилгах хойшлуулашгүй сэргээн босгоход шаардагдах зардал	612,000,000
Нийт			5,934,400,000

БҮЛЭГ 4.3. ХӨВСГӨЛ НУУРТ 1985 ОНД ЖИВСЭН “СҮХБААТАР” ХӨЛӨГ ОНГОЦЫГ ТАТАН ГАРГАХ АЖИЛЛАГАА

“Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах ажиллагаа нь Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах, бохирдлыг бууруулах зорилгын хүрээнд хийгдсэн хамгийн том ажиллагаа гэдгээрээ онцлог. Мөн энэхүү ажиллагаа нь Монгол Улсад урьд өмнө хийгдэж байгаагүй бөгөөд усны гүнд, хөндлөн чиглэлд гүйцэтгэсэн түүхэн арга хэмжээ болсон.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Ерөнхий сайд байхдаа “Хөвсгөл” нуурт живсэн техник хэрэгслийг илрүүлэх тооцоо судалгаа гаргах, “Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах ажлыг зохион байгуулах 117 дугаар захирамжийг гаргасан.

Энэхүү захирамжийн дагуу “Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах ажиллагааг зохион байгуулах үндсэн ажлын хэсгийг БОАЖС-ын Н.Уртнасан, БХ-ын сайд Г.Сайханбаяр нараар ахлуулан байгуулсан юм.

Үндсэн ажлын хэсэг нь 12 удаа хуралдаж, “Хөвсгөл нуурыг хамгаалах, бохирдлыг бууруулах зорилгоор нуурт живсэн машин техникийг илрүүлэх суурь судалгаа хийж, татаж гаргах ажлыг эрсдэлгүй зохион байгуулах талаар нарийвчилсан төлөвлөгөө гарган, Монгол Улсын Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамд танилцуулж шийдвэрлүүлсэн.

Тус шийдвэрийн дагуу Хөвсгөл нууранд живсэн “Сүхбаатар” хөлөг онгоцны нөхцөл байдлыг газар дээр нь судлах, шумбалт хийж усны гүнд зураг, бичлэгээр баримтжуулах, тооцооллыг гаргах ажлыг хэсэг Хөвсгөл аймагт 4 удаа ажиллажээ.

Үндсэн ажлын хэсгийн шийдвэрийн дагуу Батлан хамгаалахын сайдын 2021 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/199 дүгээр тушаалаар ОБЕГ-ын Тэргүүн дэд дарга бөгөөд Штабын дарга, хурандаа Ж.Чүлтэмсүрэнгээр ахлуулсан дэд ажлын хэсгийг байгуулав. Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн шинжлэх ухааны үндэслэлтэй инженер, техникийн тооцооллыг гаргаж, ШУТИС-ийн эрдэмтэн, судлаачид болон цэргийн зөвлөх инженерүүдтэй хамтран технологийн картыг боловсруулан, мөрдөж ажиллав.

“Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах ажиллагааг зохион байгуулахаар ОБЕГ-ын даргын 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/210 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн төлөвлөсөн 5 маршрутын дагуу Улаанбаатараас хөдөлгөөн үйлдэж, 10 дугаар сарын 01-ний өдөр хээрийн байрлалд шилжин, бэлтгэл ажлыг хангаж ажилласан.

“Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах ажиллагааг дараах төлөвлөгөөний дагуу гүйцэтгэхээр төлөвлөж боловсруулсан. Ингэхдээ

1. Татан гаргах ажиллагаанд бэлтгэх;
2. Хөлөг онгоцыг татах ган татлагыг холбох, хөвүүлэх;
3. Хөлөг онгоцыг татах ажиллагааг төлөвлөлтийн дагуу явуулах;
4. Хөлөг онгоцыг эрэгт байрлуулах гэсэн үе шаттайгаар явуулахаар төлөвлөж амжилттай хэрэгжүүлсэн.

Тус ажиллагаанд оролцохоор томилогдсон бие бүрэлдэхүүн автомашин техник хэрэгслээр нуурын эрэгт байрлуулах, хөлөг онгоцонд хөндлөн хөшүүрэг байрлуулах бэхлэх, ган татлагыг сүлжих, толгойлох, усны гүнд холбох, хөвүүлэх ажлыг технологийн картын дагуу гүйцэтгэлээ.

“Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргахад нийт 126 троссын үзүүрийг сүлжиж таталгад бэлтгэн, 5500 орчим метрийн троссоор үндсэн 4, хөндлөн 3 цэгээс нийт

7 чиглэлээс татах ажиллагааг “БТС-4” нэгж 3-ийг 225 тн, “Ургон” нэгж 1-ийг 40 тн, “Краз” нэгж 5 –ыг 35 тн буюу нийт 300 тн татах хүчийг тооцоолон, таталтын ажиллагааг зохион байгууллаа. Үндсэн таталтаас хөндлөн таталт руу 43 удаа техник хэрэгслийг шилжүүлэн байрлуулсан байна.

Усны гүнд “Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах ажиллагаанд 16 шумбагч, ажиллаж, 12-16 метрийн гүнд ган татлагыг хөлөг онгоцны урд, хойд, хажуу талд холбох, бэхлэх, салгах, бөгжлөх, тайрах, залгах, хөрөөдөх, хөлгийн сэнс, хажуу тал, урд талуудад татах хөшүүрэг хийх, боломжит өрөө, тасалгаанд дугуйны 30 ширхэг олгойг хийлэн байрлуулж, усны эзэлхүүнийг шахах, усны гүнд төмөр эд зүйлийг тасдах, гүн хэмжих, хязгаарлах хөвүүр тэмдэгтийг байрлуулах, хөлгийг дотор болон гадна талаас битүүмжлэх, усан эргүүл, аврах ажиллагааны бэлэн байдалд тус тус үүрэг гүйцэтгэж ажилласан.

Таталтын ажиллагааг зохион байгуулахдаа батлагдсан технологийн карт, дарааллын дагуу Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн эрдэмтэн, багш, инженерүүд, удирдлагын бүрэлдэхүүн таталт бүрийн тооцооллыг өдөр, цаг, минутаар төлөвлөж, ажиллагааны ярилцлага бүрт нарийвчлал, тооцоог гаргаж, нийт 60 удаагийн таталтын ажиллагааг зохион байгуулсан.

“Сүхбаатар” хөлөг онгоцыг 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 17:58 цагт анх хөдөлгөж, 2021 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 12:45 цагт эрэгт байрлуулан, орон нутгийн холбогдох байгууллагад хүлээлгэн өгөв.

“Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах явцад 200 литр 2 торх масло шүүрч байсныг аюулгүй болгон ажиллалаа. Олон улсын жишгээр 100 литр шатахуун алдагдахад 1,1 км/куб эзэлхүүнтэй усыг бохирдуулдаг гэсэн судалгаа байдаг байна. “Хөвсгөл” нуур нь 380 м/куб эзэлхүүнтэй. Үүгээр жишээлэхэд 100 литр масло асгарахад нуурын 0,29 хувь нь бохирдох эрсдэлтэй байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварлагчид холбогдох зааварчилгааг боловсруулан үүрэг, даалгаврыг бүрэлдэхүүнд тухай бүрт өгч, аюулгүй ажиллагааг ханган ажиллалаа. Мөн татан гаргах ажиллагааны үед бие бүрэлдэхүүний эрүүл мэнд, халдвар хамгааллын талаар тусгай төлөвлөгөө гаргаж /хүнсний эрүүл ахуй, ковид, шумбагчдын эрүүл ахуй, нийт бүрэлдэхүүний эрүүл мэндийн ерөнхий байдлыг хянаж / эмчилгээ үйлчилгээг үзүүлж байв.

Татан гаргах ажиллагааг зохион байгуулах хугацаанд Ус цаг уур орчны шинжилгээний газраас албан ёсны цаг агаарын мэдээг тухай бүр авч үйл ажиллагаандаа тооцооллон ажилласан. Ажиллагааны үеэр цаг агаарын хувьд үүлэрхэг, хур тундастай, агаарын температур -2-оос -10 0С, салхины хурд 6-11 м/с байв.

ЗХУ-д 1956 онд үйлдвэрлэгдсэн “БОР-500” загварын “Сүхбаатар” хөлөг онгоц нь 1985 онд Хөвсгөл нуурын эргээс 110-120 метрийн зайд, 12-16 метрийн гүнд (хөлөг онгоцны тэнхлэгээр тооцвол хойд хэсгээрээ усны түвшнээс 9 м, урд хэсгээрээ 3,2 м гүнд), зүүн хойноос баруун урд чигт байрлаж, нуурын ёроолд 1,4-1,9 метр гүн шигдсэн байсан.



Зураг 85. Нуурын гүехэн хэсэг рүү татах үе



Зураг 86. Үндсэн байрлалд шилжүүлж усыг шавхан хөвүүлэх үе

“Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргах ажиллагааг 2021 оны 10 дугаар сарын 01-нээс 11 дүгээр сарын 05-ныг хүртэл нийт 36 хоног ажилласан. Татан гаргах ажиллагаанд ОБЕГ-ын тэргүүн дэд дарга, хурандаа Ж.Чүлтэмсүрэнгээр ахлуулсан БХЯ, ЗХЖШ, түүний харьяа Зэвсэгт хүчний 011, 186, 234, 7780 дугаар анги, ОБЕГ, түүний харьяа Үндэсний аврах бригад, Нийслэлийн болон Орхон, Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газар, ЗТХЯ-ны харьяа Далайн захиргааны газар, МХЕГ, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, ШУТИС, Хөвсгөл аймгийн ЗДТГ, Цагдаагийн газар, Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны захирагчийн ажлын алба, “Хөвсгөл усан зам” ХК-ийн нийт 120 гаруй алба хаагч, 50 нэгж техник хэрэгсэлтэйгээр амжилттай гүйцэтгэсэн.





Зураг 87. "Сүхбаатар" хөлөг онгоцыг татан гаргасан бие бүрэлдэхүүн

ТАВДУГААР ХЭСЭГ:

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР
(КОВИД-19)-ЫН ҮЕИЙН
НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХАРИУ
АРГА ХЭМЖЭЭ**



БҮЛЭГ 5.1. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдал

Монгол Улсын хэмжээнд 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар коронавируст халдвар (КОВИД-19)-ыг илрүүлэх тандалт шинжилгээг түргэвчилсэн оношлуураар 1,822,892 сорьцонд, ПГУ шинжилгээгээр 4,569,837 сорьцонд нийт 6,392,729 сорьцонд шинжилгээ хийснээс давхардсан тоогоор 692,621 тохиолдол батлагдаж, 1986 иргэн амь насаа алдаж, 266,422 иргэн эмнэлэгт хэвтэн, эмчлэгдэн гарч, гэрийн хяналтанд 448,841 иргэн байна.

Хүүхдийн өвчлөл: Монгол Улсад коронавируст халдвараар 0-17 хүртэлх насны хүүхэд өвчилсөн 149,638 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварын тохиолдлын 21.6 хувийг эзэлж байна. Коронавируст халдвараар өвчилсөн хүүхдийн тохиолдлыг насны бүлгээр ангилж дараах графикаар үзүүлэв.



Зураг 88. Коронавируст халдвараар өвчилсөн хүүхдийн тохиолдлыг насны бүлгээр ангилсан үзүүлэлт

Дээрх судалгаанаас харахад, коронавируст халдвараар өвчилсөн нийт хүүхдийн 26.7 хувь нь 0-4 настай, 46.6 хувь нь 5-11 настай, 18.5 хувь нь 12-15 настай, 8.2 хувь нь 16-17 настай хүүхдүүд байна.

2021 онд улсын хэмжээнд коронавируст халдвар(КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, эмчлэх зорилгоор ашиглах 40 нэр төрлийн нийт 29.6 тэрбум төгрөгийн эмийн нөөцийг, 16 нэр төрлийн нийт 28.0 тэрбум төгрөгийн хувийн хамгаалах хэрэгслийн нөөцийг, 13 нэр төрлийн нийт 1.0 тэрбум төгрөгийн эмнэлгийн хэрэгслийн нөөцийг тус тус бүрдүүлэн ажилласан байна.

Түүнчлэн улсын хэмжээнд ПГУ-ын тодорхойлох оношлуур-514,340, ПГУ-ын ялгах оношлуур-419,292, шүлсний ПГУ-ын оношлуур-156, хамар залгиурын түргэвчилсэн оношлуур-383,845, Gene Expert оношлуур-84 ширхэг нөөцтэй байв. Оношлуурын

нөөцийг Улаанбаатар хотод өдөрт 7000 шинжилгээ хийхээр тооцвол ПГУ-ын ялгах оношлуур 55 өдөр, ПГУ-ын тодорхойлох оношлуур 69 өдрийн нөөцтэй гэсэн үг бөгөөд харин орон нутагт өдөрт 6400 шинжилгээ хийхээр тооцвол ПГУ-ын ялгах оношлуур 5 өдөр, ПГУ-ын тодорхойлох оношлуур 5 өдрийн нөөцтэй байна гэсэн үг юм.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын үеийн удирдлага, зохион байгуулалт

Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 3 удаагийн хуулийг Улсын Их Хурлаар батлан хэрэгжүүлсэн ба хуулийн хэрэгжилтийг хангах, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, халдварын тархалтыг хумих, нийгэм, эсийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр 2021 онд Монгол Улсын Засгийн газраас 33 тогтоол, Улсын онцгой комиссоос 27 хурлын тэмдэглэл, 58 тушаал шийдвэр, үйл ажиллагааг зохицуулах 10 түр журам, заавар гарган, хэрэгжилтийг Улсын онцгой комиссын дэргэдэх Шуурхай штаб зохион байгуулалтын хувьд ханган ажилласан.

2021 онд Улсын онцгой комиссын дэргэдэх эрдэмтэн, судлаачдын болон Эрүүл мэндийн яамны санал, эрсдэлийн үнэлгээний дүнг үндэслэн коронавируст халдварын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, халдварын тархалтыг бууруулах, хүн амыг вакцинд эрсдэлгүй хамруулах зорилгоор Засгийн газрын 27, 91 дүгээр тогтоолоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т 2 удаа шилжүүлж, нэг удаа сунгаж хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Улсын онцгой комиссын даргын 2021 оны 22 дугаар тушаалаар Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Улсын онцгой комиссын Шуурхай штабыг нийт 46 байгууллагын 186 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан ба аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд Онцгой комиссын шуурхай штабууд коронавируст халдварын эсрэг хариу арга хэмжээг тухай бүр төлөвлөн, зохион байгуулалтыг ханган ажиллалаа.






Зураг 89. Улсын онцгой комиссын шуурхай штаб

Монгол Улсын Засгийн газраас улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг нийт 3 удаа сунгаж, гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 4, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 17 удаа сунгажээ.

Улсын хэмжээнд коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх тогтолцоог дараах зургаар үзүүлэв.



Зураг 90. Монгол Улсын хэмжээнд коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх тогтолцоо

Монгол Улсын Засгийн газраас Гамшгаас хамгаалах тухай болон бусад холбогдох хууль тогтоомж мөн УИХ-аар 2020 онд батлагдсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн дагуу коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаа.

Эдгээр хууль тогтоомжийн дагуу Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн чиглүүлж, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдан зохион байгуулж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдэд тэдгээрийн удирдлагууд зохион байгуулж, хэрэгжүүлээ.

Бодлогын түвшинд хөгжлийн бодлого төлөвлөлтөд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг тусгах, бодлогын зөвлөмж, чиглэл гаргах чиг үүрэгтэй, орон тооны бус Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл ажиллаж байна.

Улсын хэмжээнд гамшгийн нөхцөл байдлын үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий Улсын онцгой комисс (УОК)-ыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.3-ын дагуу байгуулан ажиллуулдаг бөгөөд энэхүү чиг үүргийнхээ хүрээнд УОК нь 2021 онд коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг цаг алдалгүй, шуурхай зохион байгуулан ажилласан.

Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 6 дугаар тушаалаар 23 яам, агентлагийн 70 гаруй гишүүнтэйгээр байгуулагдсан УОК-ын Шуурхай штаб үйл ажиллагаагаа явуулж байгаад коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлаас шалтгаалж, Шадар сайдын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 58 дугаар тушаалаар “Улсын онцгой комиссын нэгдсэн шуурхай штаб” болж өөрчлөгдөн үйл ажиллагаагаа үргэлжүүлэн явуулж ажиллаа.

Улмаар “Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штаб” нь Онцгой байдлын ерөнхий газарт, “Орон нутгийн онцгой комиссын шуурхай штаб” нь орон нутгийн онцгой комиссын дэргэд байгуулагдсан бөгөөд коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх чиглэлээр гаргасан Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрүүдийг хэрэгжүүлж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах чиглэлд үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллага нь чиг үүргийнхээ дагуу коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх ажиллагааг удирдан чиглүүлэх, зохицуулалтаар хангах асуудалд гол үүрэг гүйцэтгэн, удирдах, шийдвэр гаргах, зохицуулах үүргийг засаг захиргааны нэгжийн бүх түвшинд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож ажилласан.

Монгол Улсын Шадар сайдын 70, 104 дүгээр тушаалуудыг хэрэгжүүлэх зорилгоор “Коронавируст халдвар (ковид-19)-ын хариу арга хэмжээний явцын үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, бригадын генерал Б.Ууганбаяраар ахлуулсан ажлын хэсэг Дорноговь, Дархан-Уул, Завхан, Орхон, Өмнөговь, Дорноговь, Ховд зэрэг нийт 8 аймагт ажиллаж тухайн орон нутгийн шуурхай штабын зохион байгуулалт, авч хэрэгжүүлж буй арга

хэмжээ, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, холбогдох үүрэг чиглэл өгч ажилласан.



Зураг 90. Монгол Улсын хэмжээнд коронавируст халдвар (КОВИД-19)-тай тэмцэх тогтолцоо

БҮЛЭГ 5.2. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Вакцинжуулалт

Монгол Улсын Засгийн газар гадаад харилцааны шугамаар болон олон улсын байгууллага, хандивлагч орнуудын дэмжлэг, оролцоотойгоор 4 төрлийн вакцины нийт 6,376,960 тунг татан авч, хүн амыг вакцинжуулжээ. 2021 оны 11 сарын байдлаар:

- БНХАУ-ын Синофарм/BBIBP үйлдвэрийн Вероцелл буюу CoV вакцин 686,560 тунг;
- Пфайзер/БионТех үйлдвэрийн Комирнэти буюу Пфайзер/БионТех BNT162 вакцин 377,340 тунг;
- Оросын Холбооны Улсын Гамалей институтын Спутник-В “Гам-КОВИД-Вак” вакцин 120 тунг үлдэгдэлтэй байгаа бөгөөд нэмэлт татан авалтууд хуваарийн дагуу явагдсан.

Монгол Улс дахь коронавируст халдварын эсрэг вакцинжуулалтын үр нөлөөг 34,500 хүнийг хамруулан санамсаргүй түүврийн аргаар судалсан тархвар зүйн судалгаагаар нийт вакцины халдвараас сэргийлэх нөлөө 1-р тунгийн дараа 33 хувь, 2-р тунгийн дараа 72 хувь болж өссөн үр дүнтэй байв. Түүнчлэн нийт вакцины нас баралтаас сэргийлэх нөлөө 1-р тунгийн дараа 51 хувь, 2-р тунгийн дараа 92 хувьтай байв.

Ковид-19-ийн эсрэг вакцины 1 дүгээр тунд 2,266,150 иргэн, 2 дугаар тунд 2,164,097 иргэн, 3 дугаар тунд 916,096 иргэн хамрагдсан гэсэн судалгаанаас харахад нийт хүн амын 69.7 хувь нь 1-р тунд, 66.5 хувь нь 2-р тунд, 28.2 хувь нь 3-р тунд тус тус хамрагджээ.

Иргэдийн КОВИД-19-ын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан байдлын судалгаанаас харахад, 1-р тунд 6,388 жирэмсэн эмэгтэй, 7,734 хөхүүл эмэгтэй, 12-

15 насны 176,251 хүүхэд, 16-17 насны 76,763 хүүхэд хамрагдсан бөгөөд зорилтот бүлгийн иргэдийн 1-р тунгийн хамралт 96.1 хувь нь 1-р тунд, 91.8 хувь нь 2-р тунд, 47.9 хувь нь 3-р тунгаа хийлгэсэн байна.

УОК-ын даргын 2021 он 05 дугаар тушаал, МХЕГ-ын даргын баталсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг вакциныг хилээр нэвтрүүлэх болон вакцинжуулалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай 01/45 дугаартай удирдамжийн хүрээнд аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын эм биобэлдмэл, эмчилгээ, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчид 9 дүүргийн дархлаажуулалтын 120 цэгт давхардсан тоогоор 1,073 удаагийн хяналт шалгалт, 21 аймгийн 150 цэгт 843 удаагийн хяналт шалгалт хийн, давхардсан тоогоор 2066 зөрчил илрүүлж 583 буюу 28.2 хувийг газар дээр нь арилгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллажээ.

Мөн хүн амыг дархлаажуулалтад идэвхитэй хамруулах, дархлаа дэмжих 3 дахь тунгийн хамрагдалтыг идэвхижүүлэх нэг сарын аяныг зохион байгуулж УОКНШШ-н даргаар батлуулсан 3 удаагийн удирдамжийн дагуу дархлаажуулалтын байнгын болон түр цэгийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй халдвар хамгаалал, иргэдийн хамрагдалтын байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тухай бүрт зөвлөмж, мэдээллийг хүргэж ажиллалаа.



Зураг 91. Вакцины гурав дахь тунгийн хамрагдалт

Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэлт болон эмнэлгийн тусламж үйлчилгээ

Коронавируст халдварын цар тахлын эсрэг хариу арга хэмжээний хүрээнд Засгийн газар, Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яам эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, хувийн хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлэх, тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлжээ. Тухайлбал, Эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн оношлуурын

нөөцийг өдөр бүр www.burtgel.mohs.mn програмаар авч, тасалдал үүссэн эмийн мэдээллийг тухай бүр эм ханган нийлүүлэх байгууллагуудад мэдээлэлж байгаа бол тасалдах эрсдэлтэй эмийн зах зээлийн нөөц, нийлүүлэлтийн мэдээг долоо хоног бүрийн Пүрэв гарагт тогтмол авч, мэдээллийн урсгалыг нэг болгосны үр дүнд шаардлагатай эм тарианы тасалдалгүйгээр ажиллах бололцоог эмнэлгийн байгууллагуудад бий болголоо.

2021 оны 09 сарын байдлаар коронавируст халдвартай иргэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхээр нийт 21,662 ор дэлгэснээс бүс нутгаар авч үзвэл, орон нутагт 6,952 нийслэлд 6,177 ор тус тус дэлгэсэн байна. Мөн эмнэлгийн бус орчинд нийт 8,533 ор дэлгэсэн байгаагаас сумдын хэмжээнд 5,313, аймгийн хэмжээнд 2,453, нийслэлийн хэмжээнд 767 ор тус тус байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон бүс нутгийн эмнэлзүйн удирдамжид тулгуурлан өөрийн орны нөхцөл байдал, хүн амын онцлогт тохируулан оношилгоо, эмчилгээний удирдамжийг цаг тухай бүрт шинэчлэх, тохируулах байдлаар ажиллаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 9.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 16 хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэрийг эмчилгээ, үйлчилгээнд зориулан шинээр байгуулж, Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Завхан аймгуудын нэгдсэн эмнэлэг, Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв, Сонгинохайрхан дүүргийн жишиг нэгдсэн эмнэлэг, Нийслэлийн төр захиргааны төв байр, Улсын гуравдугаар төв эмнэлэг, АШУҮИС-ийн харьяа Япон-Монгол эмнэлэг, эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-2 эмнэлгүүдэд бүрэн суурилуулсан бол Баян-Өлгий, Орхон, Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд суурилуулах ажлыг эхлүүлээ.

Монгол Улсын хувьд зөвхөн товлолын болон халдварт өвчний фондын вакциныг хадгалах тооцоолоор баригдсан нийт 600,000 хүн тун вакциныг нөөцлөх багтаамж бүхий агуулахтай байсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын захиалгаар Дэлхийн банкны “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн хариу арга хэмжээ, эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдлыг хангах” төслөөр, НҮБ-ын Хүүхдийн сангийн техник хамтын ажиллагааны хүрээнд “Вакцин, биобэлдмэлийн төв агуулахын өргөтгөл”-ийн 1.686 м.кв талбай бүхий барилгыг 3 сарын хугацаанд барьж, ашиглалтад оруулсан. Энэ агуулах ашиглалтад орсноор хамгийн багадаа 2-3 сая тун вакциныг нэг дор хүлээн авах, вакцины нөөцийг зохистой бүх хэмд (+2)-(+8), (-15)-(-25), (-70)-(-80) стандартын дагуу хадгалах, ашиглах боломжийг бүрдүүлээ.

Мөн 2010 оноос үйл ажиллагаа нь зогсоод байсан НЭМҮТ-ийн “Биобэлдмэлийн үйлдвэр”-ийг ажиллагаанд оруулах, цар тахлын эсрэг иммуноглобулин үйлдвэрлэх үндэслэл, судалгааг Засгийн газрын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлснээр дотооддоо цар тахлын эсрэг иммуноглобулин үйлдвэрлэж эхэллээ.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 79 дүгээр тогтоолоор халдварын голомтод ажиллаж байгаа эмч, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 2.7 тэрбум төгрөгийг олгосон.

Онцгой байдлын байгууллагын Давтан сургалт сэргээн заслын төв-113 дугаар ангид коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлыг эмчлэх, тусгаарлах арга хэмжээг авч ажилласан. Тухайлбал,

